



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-83

1.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.28-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/	9-14
2.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	14-15
3.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	14-15
4.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/	16
5.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	16-25
6.Хуулийн төслийг эцэслэн батлах	25-28
7.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	28-48
8.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	48-58
9.Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	58-83
10.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох	83

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 12-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 70 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батбаатар, Ж.Батжаргал, Ж.Баясгалан, Ш.Бямбасүрэн, С.Бямбацогт, А.Ганбаатар, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, О.Амгаланбаатар, О.Батнайрамдал, Б.Заяабал, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, Д.Пүрэвдаваа, Д.Үүрийнтуяа;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Х.Булгантуяа, Д.Ганбат, Л.Гантөмөр, Б.Пунсалмаа, Б.Тулга, Х.Тэмүүжин, А.Ундраа, М.Энхцэцэг;

Тасалсан: Т.Аубакир, Б.Жавхлан, Ч.Лодойсамбуу, Л.Оюун-Эрдэнэ;

Хоцорсон: Ч.Анар-36 минут, Ц.Баатархүү-09 минут, Д.Батбаяр-17 минут, Н.Батсүмбэрэл-2 цаг 13 минут, Б.Батцэцэг-01 минут, Э.Батшугар-20 минут, Г.Ганбаатар-52 минут, Д.Жаргалсайхан-2 цаг 17 минут, Г.Лувсанжамц-19 минут, М.Мандхай-02 минут, Ц.Мөнхбат-14 минут, П.Мөнхтулга-40 минут, З.Мэндсайхан-44 минут, Б.Найдалаа-48 минут, Ч.Номин-02 минут, С.Одонтуяа-31 минут, О.Саранчулуун-19 минут, Р.Сэддорж-4 цаг 38 минут, Б.Түвшин-40 минут, Г.Уянгахишиг-22 минут, Да.Цогтбаатар-08 минут, Б.Чойжилсүрэн-11 минут, Л.Энх-Амгалан-13 минут, Ж.Энхбаяр-01 минут, Р.Эрдэнэбүрэн-3 цаг 39 минут.

Нэг.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Н.Учрал: 1.Байнгын хорооны саналаар Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 13

Бүгд: 81

84.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл баталсантай холбогдуулан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Монгол Улс болон эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталсантай холбогдуулан “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол гаргах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 20

Бүгд: 83

75.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Л.Мөнхбаясгалан нарыг дэмжсэнээр тооцож, 78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Уг асуудлыг 10 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох.

11.1.“Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 22
Бүгд: 84
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Н.Учрал: 1.Байнгын хорооны саналаар “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 24
Бүгд: 85
71.8 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 19
Бүгд: 85
77.6 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны Нэгдсэн статистикийн газрын дарга Ц.Тэгшжаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант, мөн компанийн Эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан П.Шинэзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ц.Мөнхбат, Ц.Туваан, Б.Түвшин нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант нар хариулж, тайлбар хийв.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа байлцав.

Н.Учрал: 1.Байнгын хорооны саналаар Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 39

Бүгд: 92

57.6 хувийн саналаар эцэслэн батлах санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 31

Бүгд: 92

66.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Учрал: 1.Байнгын хорооны саналаар Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 23

Бүгд: 92

75.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Н.Учрал: 2.Байнгын хорооны саналаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 19

Бүгд: 92

79.3 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байнгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Л.Соронзонболд, Н.Алтаншагай, Б.Бейсен, П.Сайнзориг, Б.Мөнхсоёл, П.Батчимэг, М.Мандхай, Ц.Баатархүү, Ц.Мөнхбат нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Ж.Алдаржавхлан, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Жаргалсайхан нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:44/

Найм. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг танилцуулав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 57 минут үргэлжилж, 13 цаг 03 минутад өндөрлөв.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутад эхлэв.

Хуралдаан “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлын асуулт, хариултаар үргэлжлэв.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Да.Цотбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:24/

Ес. Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, Боловсролын яамны Дээд мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Г.Батнэмэх, мөн газрын шинжээч Д.Баттогтох, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга Б.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Б.Энхмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Д.Бум-Очир, П.Сайнзориг, А.Ариунзаяа, Ц.Баатархүү, Д.Жаргалсайхан, Ж.Галбадрах, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Б.Уянга, Боловсролын сайд П.Наранбаяр, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:44/

Арав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох

1.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:46/

2.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:46/

3.Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:47/

Бусад: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн урилгаар Хэнтий аймгийн

Баянмөнх сумын Монгол Ардын намын гишүүд, Социал демократ Монголын залуучуудын холбооны гишүүд, “Тэмүүлэл дартс мастерс” клубийн багш дасгалжуулагч, тамирчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн урилгаар Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, Хэнтий аймгийн Өндөрхаан хотын ерөнхий боловсролын сургуулийн 1995 оны төгсөгчид, Багахангай дүүргийн бизнес эрхлэгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн урилгаар Сүхбаатар дүүргийн иргэдийн төлөөлөл Төрийн ордон болон Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 43 минут үргэлжилж, 126 гишүүнээс 98 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 06 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 10 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улс болон эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Гишүүдийг танхимд урья. 64 гишүүнээр санал хураалт явуулна.

Хоёрдугаарт, Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Зарчмын зөрүүтэй нэг саналтай.

Гуравдугаарт, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Тавдугаарт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Зургаадугаарт, Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Долоодугаарт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Наймдугаарт, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Есдүгээрт, Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Аравдугаарт, Баталсан хууль, тогтоолын төслийн эцсийн найруулгыг сонсоно.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.28-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/

Хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж хариулт авч үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулах ёстой. Гишүүд ирцээ бүрдүүлье.

Бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлье. Шууд санал хураалтаар эхэлнэ. Номтойбаяр гишүүн санал хэлэх үү.

Н.Номтойбаяр: Монгол Улсыг 2026-аас 2030 он хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй холбогдуулаад тогтоолын төсөл боловсруулсан. Энэ тогтоолын төслийн нэг дээр юу вэ гэхээр энэ үндсэн чиглэлд тусгачихсан ажлуудыг ажил хэрэг болгоход нөгөө эрх зүйн орчин маань маш дутмаг, өөр хоорондоо зөрчилтэй, зарим нь огт байхгүй, зарим нь аливаа ажил асуудлыг явуулахад эсрэгээрээ хууль нь үйлчилдэг. Тэгэхээр энийг бүгдийг нь нэг зохицуулах ажлууд энд нь орчихсон байгаа юм. Тэгсэн 1 том асуудал нь юу вэ гэхээр бид чинь ингээд төсвөө баталдаг дараа нь эдийн засгийн төлөвлөлтөө баталдаг. Тэгээд үндсэн чиглэл буюу нөгөө малгай бодлогоо хамгийн сүүлд нь батлаад байгаа нь өөрөө зарчмын хувьд маш буруу яваад байгаа юм.

Тэгэхээр энэ нөгөө аливаа асуудлуудаа батлахдаа цагалбараа, зөв, эрх зүйн орчинд, зөв цаг дараалалд оруулахгүй бол эхлээд ингээд жижиг ажлуудаа хийчхээд хамгийн сүүлд нь том малгай бодлогоо батлаад байдаг. Эхлээд малгай бодлогоо баталчхаад энэ бодлогынхоо хэрэгжилтийг хангахад нэг талдаа төлөвлөлт нөгөө талдаа төсөв батлагдаж хоорондын уялдаа холбоогоороо энэ үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах л ийм эрх зүйн орчин бүрдэх хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр миний хэлэх гээд байгаа санаа юу вэ гэхээр энэ тогтоолын төслийг батлахдаа редакцын засвар хийхээр энэ тэмдэглэлд үйлдээд энэ цагалбараа зөв болгоё гэдэг саналыг гаргамаар байна.

Н.Учрал: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоол мөн 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолуудыг үргэлжлүүлээд хэлэлцэнэ.

Хэлэлцэх үеэр Номтойбаяр гишүүний саналыг тусгаад явъя.

Эхний асуудал бол Евразийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслөөр санал хураалтыг явуулна.

Гишүүд танхимд цуглая. Бат-Эрдэнэ дарга ирц яаж байна. Ирцэд орсон гишүүд танхимд цуглая.

Санал хураалт явуулна.

Одоо энэ чинь 57 гишүүн байна шүү дээ. Санал хураалтад бэлтгэе. Ирцэд орчихсон байгаа 26 гишүүн танхим цуглая. Норовын Алтанхуяг гишүүн, Баасанжаргал гишүүн, Бадамсүрэн гишүүн, Батчимэг гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн орох ёстой юм байна шүү. Баярбаатар гишүүн, Баярмаа гишүүн, Х.Болормаа гишүүн, Э.Болормаа гишүүн, Ж.Ганбаатар, С.Ганбаатар Ганзориг, Ганхуяг, Даваасүрэн гишүүн, Жаргалан гишүүн, Замира гишүүн Зулпхар гишүүн, Сарнай гишүүн, Тэмүүлэн гишүүн, Ундрэм сайд. Цэнгүүн гишүүн, Шижир гишүүн, Энхтүвшин гишүүн. Одонгийн Цогтгэрэл гишүүн. Ирцэд орсон гишүүд танхим цуглая.

Дарааллаад 4 санал хураалт явуулах гээд байна. Түр хороон дээр байгаа гишүүдийг орж ирж санал хураалтад орохыг урьж байна. Тэр сонсголынхныг. Энхбаяр сайд хурааа. Хураалаа шүү санал. Санал хураалаа. Их Хурлын гишүүд бол хичээж байна. Тэгээд Энхбаяр сайд аа хураалаа. Евразийн эдийн засгийн холбооны энэ түр хэлэлцээр дээр Их Хурлын тогтоол гаргая гэсэн Ариунзаяа гишүүний санал дэмжигдсэн. Тэгэхээр Их хурлын тогтоолын төслийг ирэх 7 хоногт батална тэгнэ. Зарчмын зөрүүтэй санал дэмжигдвэл тогтоолоор холбогдох чиглэлүүдийг энэ гишүүдийн гаргаад байгаа саналуудыг өгөөд сайжруулаад явъя аа. Тэгээд Онцгой албан татварын хуулиа ч ярья. Тэр квот тогтоох асуудлаа ч чиглэл өгье. Дотоодын зах зээлээ ч хамгаалъя, экспортоо ч нэмэгдүүлъя гээд ингээд нэлээд нээлттэй хэлэлцлээ шүү дээ. Энэ чинь үе үеийн сайд нар, үе үеийн Засгийн газар хичээж ажилласан.

Манай Гантөмөр сайдын үед бол бараг энэ чинь 700 бүтээгдэхүүнээс буурч 360 руу орж хэлэлцээр их сайн явагдсан юм байна лээ. Тэгээд дараа нь гарын үсэг зурсан. Ингээд Энхбаяр сайд энэ хэлэлцээрээ хэрэгжүүлнэ. ХХАА-н сайдаар ажиллаж байсан хүн энэ төслийг хариуцаж байгаа учраас энэ хэлэлцээрийг баталсны дараа бол бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг бол маш сайн хангана аа тэр бол эргэлзээгүй. Тэгээд Энхбаяр сайд өөрөө бэлтгэл ажлыг хангана тэгээд уул уурхайн бус экспорт нэмэгдүүлэхэд Энхбаяр сайд гардан одоо цүйцэтгэнэ. Эхлээд санал хураалтад дахин бэлтгэе.

Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулна аа. Гишүүд анхааралтай. Бүртгэлийн санал хураалт.

Алдаржавхлан гишүүн.

Сая хоцорсон байна. Д.Энхтүвшин гишүүн, Сайнзориг гишүүн, Болормаа гишүүн. Жамбалын Ганбаатар гишүүн. Би Ардын намын бүлгийнхнийг хэлж байгаа шүү. Евразийн эдийн засгийн холбоог бүлгээрээ дэмжсэн шүү. Бүлгийнхээ улс төрийн шийдвэрийг дагавал дагаарай. Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийн урилгаар Хэнтий аймгийн Баянмөнх сумын МАН-ын гишүүд социал демократ МЗХ-ны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд ажил амьдралд нь энэ аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Алдаржавхлан гишүүн та санал хураалтад оролцоогүй юу? Сая. Ганбаатар гишүүн байхгүй байгаа юм байна. Ганбаатар гишүүн орж ирэх байх. Даваасүрэн

гишүүн орж ирээгүй байна. Ундрэм сайд хаана байна? Дамдинням сайд, Ганхуяг сайд Ундрэм сайдыг олж ир ээ. Ганхуяг гишүүн олж ир ээ. Энхтүвшин гишүүн хаана байна. Соронзонболд гишүүн Энхтүвшин гишүүнийг дууд.

Ирэх 7 хоногт ч гэсэн хууль эцэслэн батлах санал хураалтууд явагдана аа тэгээд гишүүд хариуцлагатай чуулганы хуралдаандаа. Энхтүвшин гишүүн ирлээ. Эхлүүлье нэг бүртгэлийн санал хураалт явуулъя. Тэгээд араас нь шууд санал хураалт бүртгэлийн санал хураалт.

Энхбаяр сайд санал хураалт явууллаа шүү. Монгол Улс болон эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 68 гишүүн дэмжиж, 84 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул худалдааны түр хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Байнгын хорооноос гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Их Хурлын тогтоол баталж, тодорхой асуудлуудаар чиглэл өгнө.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Монгол Улс болон эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталсантай холбогдуулан хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол гаргах санал гаргасан.

Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа.

Санал хураалт. 63 гишүүн дэмжиж, 75.9 хувиар санал дэмжигдлээ.

Евразийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах санал хураалтаар нийт гишүүдийн олонх нь тус хэлэлцээрийг дэмжсэн байна.

Ингээд мөн Их Хурлын тогтоол батлах зарчмын зөрүүтэй санал мөн дэмжигдлээ.

Батчимэг гишүүн, Мөнхбаясгалан гишүүн нарыг нэмье. Дэмжсэнээр тооцож байна. Монгол Улсын Засгийн газар Жадамбын Энхбаяр сайд, Эдийн засаг, хөгжлийн яам ажлын хэсгийнхэнд баяр хүргэе.

Худалдааны түр хэлэлцээр байгуулагдсан тул бэлтгэл ажлыг хангуулж, уул уурхайн бус экспортыг дэмжих инфляцыг хэрэглээний сагсанд байгаа тодорхой бүтээгдэхүүний үнийг бууруулах бодлогууд амжилттай хэрэгжих нөхцөл бололцоо

тавигдаж байна. Ингээд та бүхнийг хичээж ажиллахыг хүсье ээ. Гишүүд ажлын хэсэгт талархлаа.

10.28 цаг

Дараагийн асуудалд оръё.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Үргэлжлүүлэн хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т заасны дагуу зарчмын зөрүүтэй санал хураалгая.

1.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

11 дүгээр зүйл хууль хүчин төгөлдөр болох 11.1. энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо санал хураалт.

62 гишүүн дэмжиж 73.8 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд үг хэлсэнгүй.

Ингээд зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн батлах тухай бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.30 цаг

Дараагийн асуудалд оръё. **“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Энэ асуудал дээр Нямтайширын Номтойбаяр гишүүн саналаа хэлсэн. Тэгээд редакцаар энэ саналуудыг тусгая. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

61 гишүүн дэмжиж 71.8 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье Засгийн газар 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл баталсантай холбогдуулж авах зарим арга хэмжээний тогтоолын төслийг хэрэгжүүлж ажиллахыг хүсье.

10.32 цаг

Дараагийн асуудалд оръё.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

66 гишүүн дэмжиж, 77.6 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Тогтоолын төсөл баталсантай холбогдуулж салбар болгонд байгаа хяналт шалгалтын давхардлыг арилгах, төсөв мөнгө нэмэгдүүлэхгүйгээр орон тоо нэмэгдүүлэхгүйгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх бүтцэд салбарын хяналтуудыг нэгтгэж ирэх жил мэдээллийн технологийг ашиглаж наад ажлын давхардлаа арилгах, наад олон хяналт шалгалтаа бууруулах нэг сувгаар хяналт шалгалтаа хийх ажлыг эрчимжүүлэх чиглэлийг Засгийн газарт өгч байна.

1 дүгээр сарын 1-ний дотор бэлтгэл ажлыг хангуулна. Хаврын чуулганаар Хяналт шалгалтын хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж иргэдийнхээ эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг хангахад манлайлал үзүүлж ажиллахыг хүсье ээ. Тэгээд салбарын хяналт болон зөвлөн туслах биш 8 байгууллагаас нэг байгууллага дээр улиралд бараг 8-аас 10 шалгалт ирдэг болчихсон энэ давхардлаа бууруулахыг хүсье.

Улсын Их Хурлын гишүүдэд талархлаа.

10.33 цаг

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх БОХХАА-н байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Таныг индэрт урья.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 12 дугаар сарын дөр 4, 5-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н Байнгын хороонд шилжүүлсэн.

БОХХАА-н Байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно оо.

Байнгын хороон хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг малын индексжүүлсэн даатгалд ган зудаас гадна бусад төрлийн эрсдлийг хамруулах талаар Гамшгийн эрсдэлийн санг байгуулах асуудлыг батлагдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой эсэх Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар малын аж МАА-н даатгалын салбар дахь төрийн оролцоог тодорхойлж малын зүй бус хорогдлын эрсдэлийн тодорхой хувийг төр хариуцах эсэх мөн даатгалын компаниуд эрсдэлээ давхар даатгуулж байгаа талаар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбар болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай БОХХАА-н Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Үүний дараа 2 хууль эцэслэн батална шүү. Гишүүд танхимд бэлэн байна уу? Ажлын хэсгийг танилцуулъя. Үндэсний статистикийн хорооны Нэгдсэн статистикийн газрын дарга Цагааны Тэгшжаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Батбаатарын Амарбаясгалан, ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Батмөнхийн Жавхлант Үндэсний давхар даатгал ХК-ийн эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан Пүрэвлхагвын Шинэзул.

Ажлын хэсгийг та бүхэнд танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Мөнхбат гишүүнээр тасаллаа. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Бат-Эрдэнэ гишүүн нэрээ татаж байна. Жудгийн Баярмаа гишүүн нэрээ татаж байна. Нэрээ татсан уу та? Баярмаа гишүүн үг хэлэх үү? Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Гишүүддээ өглөөний мэндийг хүргэе.

Малчдын хувьд нэлээн анхаарал хандуулдаг орон нутгийн иргэдийн хурал, уулзалтууд, малчдын багийн уулзалтууд дээр нэлээн яригддаг ийм хуулийн төсөл байгаа. Өнөөдөр ингээд эцэслэн батлагдах санал орж ирж байна аа.

Үүнтэй холбогдолтой тодорхой мэдээллүүдийг цэгцтэй өгөх үүднээс хэд хэдэн асуултуудыг тодруулъя аа.

Үндсэндээ Засгийн газраас орж ирсэн саналын дагуу 2-оос 3 өөрчлөлтийг оруулж байгаа юм байна. Хамгийн эхний өөрчлөлт нь босго үзүүлэлтийг аймгаар авдаг байсныг сумаар авдаг болгож байгаа юм байна аа. Ингэснээрээ хэчнээн сум дээр ямар хэмжээтэй болох вэ гэдгийг нэлээн дэлгэрэнгүй малчдад танилцуулах нь зөв байх 6 хувь гэж заасан энэхүү босго үзүүлэлтийг 5 нэмэх хасах гэхээр зарим сумдууд дээр 4 болох юм байна.

Зарим сумдууд дээр бол одоо бас 5 болж тодорхой түвшинд буурах ийм алхам хийгдэх нь ээ. Нөхөн олговор авах малчдын тоо 1-ээс 2 хувиар буурч байгаатай холбогдолтой ямар хэмжээнд нэмэгдэх вэ? Тодорхой бас малчдын тоо нэмэгдэх учиртай. Өмнөх жилүүдэд зудын нэлээн хүнд цаг үед малчид хэрвээ 4 хувийн босготой байсан бол хэдий хэмжээний нөхөн олговрыг авах ийм зөрүү тооцоолол гаргавал үр дүн нь харагдах байх аа.

Тэгэхээр ийм тодорхой мэдээллээр энэ 6 хувийг 4 хувь руу буулгаж байгаа талаарх мэдээллийг дэлгэрэнгүй юу өгөөч ээ гэж хүсэх байна аа.

Хоёр дахь нь аль хагас жилийн мал тооллогын дүн гараад малын хорогдлын тоон мэдээлэл гарсны дараа 7, 8 сар, 9 сар бараг 10 сар уу дөхүүлж байж нөхөн олговроо авдаг байсан асуудлыг тухайн үед нь авдаг болгож байгаа бас нэг ийм эерэг өөрчлөлт орж ирж байна аа.

Тэгэхээр энэ оноос эхлээд энэ асуудлууд ямар хэмжээтэй хэрэгжих вэ? Яг хорогдсон малаа ямар байдлаар тоолуулж хаана хандаж яаж энэ нөхөн олговроо авах вэ гэдэг дээр нэлээн дэлгэрэнгүй мэдээллийг өгөөд хуулийн хэрэгжилтийг илүү сайжруулах талаас нь мэдээлэл өгөх нь зөв байх аа гэж бодож байна.

Гурав дахь орж ирж байгаа өөрчлөлт бол хэдийгээр хуулиар заавал даатгуулах асуудлыг нь хориглож байгаа боловчиг нөгөө хөнгөлөлт зээл тусламжууд авах шалгуур үзүүлэлтүүд дээр энэ асуудлууд байсаар байгаа. Тэгэхээр энэ бол яах вэ хуулиар шийдээгүй боловчиг малчид бол заавал даатгуулахтай холбогдолтой асуудал нь үргэлжилсэн хэвээр явах болов уу гэж харж

байна аа. Яах вэ малчдын хүлээлт, яг ярьж байгаа хүсэж байгаа энэ агуулгын түвшинд өөрчлөлтүүд орж чадахгүй байгаа ийм асуудал яригдаад үлдэж байна аа.

Тэгэхээр энэ зүй бус хорогдлыг бууруулах уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй МАА-н салбарыг бий болгох чиглэлээр цаашдаа энэхүү хуулиас гадна тодорхой бодож байгаа бодлого чиглэлийн тухай бид ярих ийм асуудлууд үүсэж байна. Байнгын хороон дээр зарим гишүүд, бүүр ялангуяа АН-ын маань зарим гишүүд зүй бус хорогдлоор малаа алдсан тохиолдолд төр тодорхой хувийг нь даах тухай хүртэл ийм санал энэ тэр гаргаж байна лээ.

Тэгэхээр уул нь бол төр хорогдсоны дараа биш хорогдохоос нь өмнөх энэ асуудалд нь гол анхаарлаа хандуулаад нөгөө эхлүүлсэн шинэ хоршоо, хөдөлгөөн, бусад ХАА-н хөдөлгөөнүүдийн энэ үр шимийг илүү сайжруулах чиглэл дээр анхаарлаа хандуулаад явах талын ийм бодлогыг баримтлах ёстой юм аа. Малчдад нэг удаагийн тусламж эс үгүй бол хорогдсоны дараах энэ тусламж гэхээс илүүтэй хорогдуулахгүй байх, даван туулах, өөрсдийн чадамжийг сайжруулах чиглэлийн энэ бодлого хөтөлбөрийг цаашдаа хэрэгжүүлээд явах нь зөв юм аа. Тэгэхээр иймэрхүү зөрөөтэй ийм мэдээлэлтэй байгаа гишүүд маань цаашдаа анхаарна биз ээ. Ийм асуултуудыг асууя аа.

Н.Учрал: Идэрбат хэн хариулах вэ? Жавхлант захирал 4 дүгээр микрофон.

Б.Жавхлант: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Үндэсний давхар даатгал компанийн гүйцэтгэх захирал Жавхлант. Босго үзүүлэлт өөрчлөгдсөөр нийтдээ 4 хувийн босго үзүүлэлттэй сум 120, 5 хувийн босго үзүүлэлттэй сум 156, 6 хувийн босго үзүүлэлттэй сум 59 болж байгаа.

Ингээд энийг 2023-2024 оны зудын хохиролтой ингэж адилтгаж тооцох юм бол хохирол маань ойролцоогоор 20-25 хувиар өсөх ийм урьдчилсан тооцоололтой. Хэрвээ бид нар малын хохирлыг 25 хувиар дээш гэж тооцох юм бол энэ маань нийт хохирлын хэмжээ 86 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлөхөөр ийм урьдчилсан тооцоо гарч байгаа.

Өөрөөр хэлбэл хохирлын хэмжээ, даатгалын компанид нөхөн төлж байгаа хохирлын хэмжээ даруй 64, 65 тэрбум төгрөгөөр өсөхөөр ийм тооцоолол урьдчилсан тооцоолол гарсан байгаа. Хэрвээ хууль батлагдсан тохиолдолд урьдчилсан байдлаар нөхөн төлбөрийн тооцоог болохоор зэрэг ҮСХ-оос гаргасан хагас жилийн мал тооллогын түүвэр судалгаагаар гарсан дүнгээс өмнөх тоонд үндэслэн нөхөн төлбөрийг олгохоор ингэж хуулийн төсөлд тусгасан. Одоогийн байдлаар бол улирал тутам ҮСХ-оос нөгөө том малын зүй бус хорогдлын тоог гаргаж байгаа.

Ингээд тооцох юм бол бид нар техникийн хувьд сар болгон гаргах боломжтой юм байна лээ. Ингэх юм бол бид нар хэрвээ тухайн сум, орон нутагт малын том малын зүй бус хорогдлын хэмжээ босго үзүүлэлтээсээ давсан тохиолдолд тухайн орон нутгийн хүсэлтийг үндэслэж нөхөн төлбөрийг урьдчилан олгох бололцоотой гэж харж байгаа. Ер нь цаашдаа бол даатгалын малын индексжүүлсэн даатгалын тухай тогтолцоог энэ дахин сайжруулах тал дээр бид нар ажиллаж байгаа. Ялангуяа ажлын хэсгийн гишүүдийн зүгээс бол маш их ажил хэрэгч саналууд гарсан.

Тухайлбал гамшгийн өмнөх эрсдэлийн санхүүжилтийг яаж бий болгох вэ гэсэн тал дээр бол энэ ажил хэрэгч санал гаргаад хуулийн төслийг бас боловсруулаад зохих судалгаанууд нь хийгдээд явж байгаа болно оо. Баярлалаа.

Н.Учрал: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Тэгэхээр энэ жилээс эхлээд сар болгон юм уу, улирал болгон, малын хорогдлынхоо тоог статистик дээр үндэслээд нөхөн олговроо аваад явах энэ боломжийг малчид олгож эхлэх ийм хуулийн төслийг бид нар батлах гэж байна аа.

Тэгэхээр хэрэгжилтийг нь илүү сайжруулаад тодорхой бас үр дүнг нь тэр сар тутамд нь гаргаад явах тал руу нь шахах чиглэлийг бас цаашдаа анхаараад ингээд явах нь зөв байх аа гэж бодож байна. Их Хурлын 15 гишүүн хамтраад Засгийн газарт бас нэг тодорхой суурь асуудлаар нь энэ малын даатгалтай холбогдолтой асуудлыг өөрчилж өө гээд ингээд хуулийн төсөл санаачлаад өгсөн байна лээ. Ажлын хэсгийн дарга Идэрбат гишүүн бас энэ талаар мэдээлэл Байнгын хороон дээр танилцуулсан.

Тэгэхээр энийг яг ямар шалтгаанаар буцаасан, тодорхой энэ асуудлыг сууриар нь шийдэх гэж байгаа энэ даатгалын тогтолцоо энэ сангуудыг бий болгох гээд бас нэлээн асуудлууд дурдсан юм байна лээ. Тэгэхээр энэ талаар уул нь Засгийн газраас уул нь мэдээлэл авахыг хүсэж байна аа. Хүмүүс байвал хариулж өгөөч ээ.

Н.Учрал: Тийм Жавхлан захирал хариулах уу.

Б.Жавхлант: Гамшгийн эрсдэлийн өмнөх санхүүжилтийн тогтолцоог бий болгох талаар бол Улсын Их Хурлын 11 гишүүн тодорхой хуулийн төсөл санаачлаад ингээд судалгааны ажлууд хийгдэж байгаа. Ялангуяа одоо даатгалын тогтолцоо бол гамшгийн эрсдэлийн дараах санхүүжилт бол гамшгийн эрсдэлийн өмнөх буюу энэ шинэ санаачилж байгаа хуулийн төслийн дагуу бол гамшиг болохоос өмнөх хохирлыг нөхөн төлөх энэ санхүүгийн тогтолцоог бий болгох тал дээр бол ажлын хэсэг болон энэ мэргэжлийн хүмүүс маань зохих судалгаа тооцооллын ажлыг хийж байгаа.

Ялангуяа зудын эрсдэлд нэрвэмтгий бүс нутгууд дээр ямар хүчин зүйлийн нөлөөллийн улмаас энэ даатгалын буюу энэ зудын хохирол их гараад байгаа юм бэ? Нөлөөлөл нь хаана байгаа юм бэ? Хүчин зүйл нь юу байх вэ? Хөшүүрэг нь юу байх вэ гэдэг дээр зохих судалгаа, тооцоо шинжилгээнүүд хийгдэж байгаа. Энэхүү судалгаа, тооцоо шинжилгээний ажлыг өнөөдрийн байдлаар НҮБ-ын ХХААБ болон.

Н.Учрал: Энэ Жавхлан захирал шүүмж сайн хүлээж авч маш сайн хариулдаг болсон байна шүү. Тоотой тодорхой, ойлгомжтой. Тэгээд ингээд хариулаад байвал ажлаа мэддэг хүн хүмүүст зөв мэдээлэл өгч байна. Баярлалаа.

Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль хэрэгжээд явж байгаа.

Тэгээд өнөөдөр бас энэ Улсын Их Хурал дээр энэ асуудал хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэгдэж байна. 6 хувийн босготой байсныг бууруулж байгаа юм байна. Тэгээд энэ хууль бас яг амьдрал дээр бодитой үр дүн өгдөггүй юм аа. Хүн даатгалтай гээд гамшиг болоод малаа тэр чигээр нь алдчихаад байгаа малчид материал юм хумаа бүрдүүлээд өгөхөөр тухайн сумаар нь, аймгаар нь нийтэд нь авч үзэж байж энэ асуудалд хамруулна аа гэдэг ийм зүйл яригддаг.

Тэгэхээр энэ хуулийн үр дүнг ер нь ингээд бууруулчихаад байгаа юм. Тэгэхээр энэ ажлын хэсгээс асууя. Өнгөрсөн хугацаанд яг энэ он оноор нь нэг сүүлийн 3 жилийнхийг, яг хэдэн аймгийн, хэдэн сумын, хэдэн малчин энэ индексжүүлсэн даатгалаас бас хувь авч энэ учирсан хохирлоо барагдуулсан бэ гэдэг нэг тоог хэлээд өгөөч ээ. Ийм асуудал байна.

Хоёрдугаарт энэ малчдын асуудал өөрөө анхаарлын төвд орохгүй болохоо больсон. Одоо бид нар малаа Үндсэн хуулиараа төрийн хамгаалалтад байна гэдэг. Хөдөө мал маллаж байгаа хүмүүсийн амьдрал ахуй улам л хүнд болоод байна. Орлого багасаж байна. Нөхцөл хүндэрч байна. Малчдын нийгмийн асуудал малчдын залуу халааг бэлтгэх дээрээс нь бүүр хүнд асуудал энэ залуу малчин эрэгтэйчүүдийн гэр бүлийн асуудал гээд ингээд маш олон асуудлууд хүндэрч байна аа. Тэгэхээр энэ малын даатгалыг ганцхан энэ индексжүүлсэн даатгалаар хязгаарлах биш ер нь энэ малын даатгал руу энэ хувийн хэвшлийг хэрхэн оруулах вэ?

Дээрээс нь энэ малчдын нийгмийн асуудлыг нэлээн анхаарч үзэх цаг нь болжээ. Тэгэхгүй бол бид хэд хэдхэн жилийн дараа хөдөө мал маллах малчингүй болох гэж байна. Залуу малчид байхгүй болох гэж байна. Тэгэхээр энэ асуудал дээр нь нэгэнт энэ малын даатгал ярьж байгаа үе дээр нь цогцоор нь ярьсан нь зөв болов уу гэж.

Дээрээс нь нэг тийм цаг үеийн асуудал ялангуяа энэ бензин, дизель түлшний асуудал бас хүнд байна аа. Одоо яг энэ цас зуд хүндэрчихсэн байгаа аймгууд өвлийн хүйтэн болчихсон байгаа өвөлжөөндөө бууж байгаа идэш ууш өвс тоосоо нааш нь цааш нь зөөх улсууд дээр энэ унаад явдаг портер бонгоных нь бензин түлшний асуудал маш хүндэрчихсэн байна.

Тэгэхээр энэ асуудлыг ч гэсэн бид хэд ойрын хугацаанд гаргаж шийдэл болгохгүй бол одоо ингээд 9 эхлээд маш хүнд болно. Өнгөрсөн зун ер нь гандуу байдалд орчихсон. Тэгэхээр энэ асуудал дээр нэлээн анхаарч өгөөч ээ. Ялангуяа энэ салбарын яам. Бензин тос орж ирж байна, орж ирсэн бензин тос эндээ тараагдаад л юун нөгөө нөөцлөх тараагдаад л ингээд дуусаж байна.

Хөдөө орон нутаг руу бол хүрэхгүй байна. Тэгэхээр энэ асуудал дээр бас нэг анхаармаар байна аа. Салбарын яамныхан яг тэр хөдөө орон нутагт хээр бензин түлшгүй хаягдчихсан байгаа машинуудын эзэн шиг л сэтгэл гаргаж сэтгэж байж энэ асуудалд хандахгүй бол Улаанбаатарт яах вэ хүмүүс нийтийн тээврээр зорчоод таксигаар зорчиж болох байх. Хөдөө орон нутагт бол асуудал хүнд байгаа шүү. Тэгэхээр энэ ташрамд энэ асуудлыг анхааруулаад хэлчихье ээ. Тэгээд тэр тоо хэмжээн дээрээ хариултаа авъя.

Н.Учрал: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон. Жавхлант.

Б.Жавхлант: Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 оноос хойш хэрэгжиж эхэлснээс эхлээд нийтдээ 36 орчим тэрбум төгрөгийн хураамжийг малчин иргэдээс цуглуулж авсан. Нийтдээ 29.4 тэрбум төгрөгийг малчин иргэдэд буцааж олгосон нийт том тоо байдаг. Ялангуяа сүүлийн 3 жилийн хугацаанд 2023 онд бол 14 мянган малчин өрхөд 4.2 тэрбум төгрөгийг, 2024 онд 22 мянган малчин өрхөд 16.8 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн олгосон байгаа. Эндээс дурдаад аваад үзэх юм бол 2023 онд хамгийн өндөр нөхөн төлбөрийг Төв аймгийн Баянцогт сумын малчин 15 сая төгрөг. 2024 онд хамгийн өндөр нөхөн төлбөрийг Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын малчин 86 сая төгрөгийн нөхөн төлбөр хүлээн авсан ийм тооцооллууд байдаг аа.

Хоёрдугаарт нь одоогийн малын индексжүүлсэн даатгалын тогтолцоо бол төр хувийн хэвшил дээр хамтарсан түншлэлээр хэрэгждэг ийм тогтолцоо шүү. Даатгалын хувийн даатгалын компаниуд малын индексжүүлсэн даатгалыг борлуулалтыг хийдэг, эрсдэлээ үүрдэг. Харин давхар даатгалыг нь төрийн эзэмшлийн үндэсний давхар даатгал компани хариуцан хийдэг ээ гэж хариулъя аа. Баярлалаа.

Н.Учрал: Идэрбат. Гишүүн хариулна.

Ц.Идэрбат: Туваан гишүүний 2 дахь асуултад хариулъя.

Ер нь яах вэ энэ даатгалын хуулиар бүх асуудал шийдэгдчихгүй. Гэхдээ ер нь яах вэ ХАА-д тулгамдаад байгаа ялангуяа энэ залуу малчин гээд л олон асуудлууд байгаа гэдгийг та хэд бэлхнээ мэдэж байгаа. Ер нь яах вэ зүгээр яг амьдрал дээр очоод малчидтай уулзахад бид нэг их төрөөс олон юм гуйгаад байх юм алга. Малын гаралтай түүхий эдийн бараа бүтээгдэхүүний маань үнийг л тавиад өгчихвөл гэж, нэг жоохон өөд нь дээш нь татаад өгчихвөл гэж ийм зүйлийг хүсдэг. Тэгээд өнөөдрийн Их Хурлаар хэлэлцэгдсэн энэ Евразийн энэ хэлэлцээр би ялангуяа Монголын ХАА-н салбар тэр дундаа малчдын хүсэж байгаа тэр малын гаралтай бараа бүтээгдэхүүний үнэ өсөх ийм зүйл явагдаж эхэллээ гэж ингэж би өөдрөгөөр харж байгаа гэдгийг би хэлье ээ гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Н.Учрал: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Та бүгдэд өглөөний мэнд хүргэе. Энэ малын индексжүүлсэн даатгалын хуулийг өөрчлөлт хийх нь бол манай малчдад бол нэлээн нэмэр болсон ийм чухал хууль. Тэгээд энэ хуулийн ажлын хэсгийг манай Идэрбат гишүүн ахлаад явж байгаад би их баяртай байгаа юм. Идэрээ гишүүн бол аймаг орон нутагт ажиллаж байсан, аймгийн Засаг даргаар ажиллаж байсан амьдралд ойрхон хүмүүсийн нэг ээ гэж ингэж боддог. Тэгээд ганц, хоёр тодруулах юмнууд байна. Нөхөн олговрыг олгохдоо тухайн сумын нийт хорогдсон малын 6 хувь гэж хуучин байсан. Энэ бол яг амьдрал дээрээ малчдад нөхөн олговор төдийлөн очдоггүй байсан.

Энийг 5 дээр нэмэх хасах нэг болгож байгаа юм байна. Тэгээд ямар сумдууд нь хэчнээн тооны малтай, ямар сумдууд нь хэчнээн малчидтай сумдууд нь 4 болоод ямар ямар нь 5 болоод, ямар нь зургаа дээр үлдэх вэ? Энэн дээр Идэрбат гишүүн хариулаад өгөөч ээ гэж 1 дүгээрт хэлэх байна.

Хоёрдугаарт нөгөө талдаа бид нар даатгалын компаниудаа бодохгүй бол бас болохгүй. Энэн дээр даатгалын компаниудтай хэлэлцүүлэгт оролцуулсан юм уу, аль эсвэл тэд нартай ямар нэг судалгаа мэдээллийн юмнууд байна уу гэдэг нэг юмыг асуух гэсэн юм.

Хэтэрхий доошоо буулгачхаад даатгалын компани олдохгүй тэр ойлгомжтой. Тэгэхээр зэрэг энийг тэр жин панг нь тааруулна гэдэг шиг яаж зохицуулалтуудыг хийсэн бэ гэдэг дээр нэг хариулт аваад тэгээд эргэж тодруулъя аа.

Н.Учрал: Идэрбат гишүүн хариулна.

Ц.Идэрбат: Мөнхбат гишүүний асуултад хариулъя аа.

Яах вэ одоо тэгээд даатгалын маань энэ хууль нэг жоохон өөрчлөгдөөд яах вэ одоо байгаагаасаа эрх зүйн орчин нэг жоохон сайжирч байгаа. Ажлын хэсэг дээр бол Засгийн газраас оруулж ирсэн төсөл дээр бол уян хатан байлгана аа гэдэг ийм үгтэй орж ирсэн заалттай. Ажлын хэсэг дээр яриад бол бид 6 хувь гэж ингэж хатуу тогтоосон энэ заалтыг бид ядаж 4 хувь руу оруулах бололцоог судал аа гэдгийг дэд ажлын хэсэгтээ өгөөд, тэгээд дэд ажлын хэсэг маань яг энэ төр, хувийн хэвшил, энэ даатгалын хувийн хэвшилтэй хамтарч байгаа энэ холбоогоороо нэлээдгүй сайн судалгаа хийгээд 4 болгох ямар ч бололцоогүй байна аа гэдэг ийм зүйлийг оруулж ирсэн. Тэгээд бид бол тал талаас нь ярьж байгаад 5 дээр нэмж хасах нэг буюу одоо байгаа 6 хувь гэдэг нь бол энэ хувь дээшээ 6-аас дээшээ гарах ямар ч бололцоогүй болгоно.

Харин доошоогоо ингээд 4, 5 гээд ингээд доошоогоо явна аа гээд эрх зүйн орчныг нь арай л сайжруулж байгаа нэг ийм зүйл байгаа. Ингээд сая сумдуудынх нь хамрагдах тоог хэлсэн. Ямар сумдууд нь яаж хамрагдах вэ гэхээр нөгөө хууль дээр байгаа 4 үзүүлэлт байгаа юм. Даатгалд хамрагдсан хорогдол эд нар гээд нэг 4 гол зүйл заалтууд байгаа. Энэндээ хамрагдаж чадсан даатгалын хэм хэмжээ, малчин өрхийн тоо, зүй бус хорогдлын тоо гээд энэ 4 хүчин зүйлийг үндэслэж 4 байх уу, 5 байх уу гэдгийг тогтоох ийм зүйл байгаа гэдгийг би танд хэлье ээ.

Дараагийн асуудал нь бол тэр хэтэрхий доошоо орчихвол болохгүй ээ гэдэгтэй санал нэг байгаа. Үнэхээр одоо энэ яг юу гэдэг юм жолоочийн албан журмын даатгалыг даатгахын төлөө энэ даатгалын компаниуд чинь өдөр шөнөгүй ийм маркетинг сурталчилгаа хийж байна шүү дээ. Тэр бол албан журмынх. Тийм ээ аль нь их даатгах вэ гээд. Орон нутагт автомашины үзлэг хийгдэхэд тэр суман дээр хийгдэж байгаа тэр үзлэгийн тэгээд л машиныг даатгахын төлөө л эд нар ингээд 5, 6, 7 агентууд нь суучихсан л нааш цааш нь чангаагаад л ингээд л суучихдаг. Яг малыг чинь даатгая гээд ингэхээр малын МАА маань өөрөө маш тийм эрсдэлтэй хүнд нөхцөлд байдаг учраас төрийн ямар нэгэн дэмжлэггүйгээр давхар даатгалын тогтолцоогүйгээр явахгүй юм билээ.

Тэгэхээр бид ингээд нэг төрөөс доош нь болго гэдэг ийм зүйлийг хамаагүй хэлж чадахгүй юм билээ. Болохгүй боломжгүй юм билээ. Харин гэхдээ цаашдаа энэ МАА-н салбарт үүсдэг гамшгийг бид зөвхөн зудын эрсдэл гэж хармааргүй юм билээ. Тэр зуднаас гадна ган гачиг, үер ус, малын халдварт өвчин гээд маш олон хүчин зүйлүүд зурвасхан гардаг юмнууд ч байгаа шүү дээ. Ийм зүйлүүд байгаа. Энийг нь өшөө цаашаа сайжруулаад явах нь зүйтэй юм билээ. Аймгаар байсныг нь сум болгож байгаа. Яг ноднин өвөл малчидтай очоод уулзахад бол газар дээр нь очоод

уулзахад Өмнөдэлгэр сумын жишээ нь манай Хэнтий аймгийн Чандмань бригадынхан багаар нь баймаар байна гээд л ингээд л ярьдаг. Манайх сумдууд чинь том газар нутагтай учраас зарим баг нь зудтай байдаг, зарим нь зудгүй байдаг.

Үүнээс болоод нөгөө сумынхаа дүнгээр, аймгийнхаа дүнгээр 6 хувьдаа хүрдэггүй эд нар гээд олон.

Н.Учрал: Банзрагчийн Түвшин гишүүн.

Б.Түвшин: Та бүхэндээ өглөөний мэндийг хүргэе ээ.

Энэ хуулийг ерөнхийдөө үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Яагаад гэвэл малчдын даатгалд хамаарагдах эрсдэлийн цар хүрээг нэмэгдэж оруулж байгаа. Нөгөө талдаа орон нутгийн бүсчлэлийн хэмжээг багасгах байдлаар нөхөн төлбөр олгох боломжийг нь нэмэгдүүлж байгаа гэсэн ийм агуулга байгаа. Гэхдээ энэ дотор нэг ийм 2, 3 асуудал байгаад байгаа юм л даа. Төр ерөөсөө энэ малчдынхаа даатгалд яаж оролцдог юм бэ гэхлээр нэг бол даатгалын хураамжийг нь төлж өгдөг. Үгүй бол тэр эрсдэлийг нь бууруулахад нь төр өөрөө оролцдог.

Өнөөдөр манай төрийн оролцож байгаа хэлбэр бол ТӨК-ийн хэлбэрээр ингээд давхар даатгалын компани ТӨК байгуулаад тэгээд энэ маань өөрөө эрсдэл дээр суурилсан бүтээгдэхүүн гаргаад тэгээд энэ бүтээгдэхүүнүүдийг нь малчид худалдаж авах байдлаар оролцож байгаа нь өөрөө яг төрийн бүтэн оролцоог хязгаарлаж байна аа гэж би хувьдаа үзэж байгаа.

Үнэхээр төр малчдаа дэмжье гэж байгаа бол энэ хураамж дээр нь оролцох ёстой. Энэ эрсдэл дээр суурилсан даатгалын компанийн давхар даатгалын компанийн байдлаар явж байгаа гэдэг чинь цаанаа бол уг нь эрсдэлийг бизнес болгож хувиргаж байгаа давуу талтай юм шиг боловч энэ эрсдэл нь өөрөө ихэвчлэн давагдашгүй байдлын буюу их том хэмжээний эрсдэл байдаг учраас төр энэ дээр томоохон хэмжээний хохирол гарсан үед гарцаагүй оролцох боломжтой шаардлагатай. Тэгээд энийг 1 дүгээрт яаж шийдэх вэ?

Хоёрдугаар асуудал. Малчны тухай хуулийн 12.3.5-д нэмэлт, өөрчлөлт оруулаад тэгээд тэр хуулийн 12.5, 12.6-д заасан хөнгөлөлттэй зээлүүдийг малчдыг дэмжих зорилгоор олгодог хөнгөлөлттэй зээлүүдийг олгоход энэ даатгалд заавал хамруулсан байх ёстой. Энэ даатгалд хамруулаагүй байх юм бол тэр хөнгөлөлттэй зээлийг олгохгүй ээ гэдэг ийм шаардлага орж ирж байгаа нь энэ даатгалыг албан журмын даатгал шиг болгож байна. Энэ нь өөрөө бас малчдын төлбөрийн чадварт нөлөөлөх үү? Энийг бол би жоохон шүүмжлэлтэйгээр хандаж байна. Тэр албан журмын даатгал шиг байлгах нь байтугай энэ даатгалын хураамж дээр нь төр оролцох ёстой энэ үзэл баримтлал өөрөө даатгал, компани, хэлбэр төр өөрөө даатгалын компани хэлбэрээр энд оролцож байгаа энэ суурьтайгаа, үндэслэлтэйгээ зөрчилдөж байгаа юм биш үү гэсэн нэг ийм асуулт байна. Тэгээд дээрээс нь ер нь энэ малчдын тухай хуульд өөрчлөлт оруулах хэсгийг нь ер нь хасчихвал яасан юм бэ гэдэг ийм санал байна.

Н.Учрал: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн хариулна.

Ц.Идэрбат: Эхний асуулт эрсдэлийг бууруулах тал дээр төр оролцох ёстой гэдэгтэй бол санал нэг байгаа. Та бидний боловсруулаад Засгийн газраас санал

авахаа өргөн барьсан хууль дээр бол яг энэ зүйл заалт маань байгаа. Бид гамшиг болохын өмнө сэргийлж чадах юм бол энэ асуудал бас цаашаа явна аа гэж л хохирол багатай туулна аа гэдэг энэ л үндсэн зарчим дээрээ байгаа. Ажлын хэсгийн хувьд бол Засгийн газраас өргөн барьсан 3 үндсэн зүйл заалтын хүрээнд л энэ асуудал явж байгаа. Би түрүүнд хэлсэн ер нь бол цаашдаа энэ МАА-н салбарын эрсдэлийг бид бууруулах, хууль эрх зүйн орчныг өшөө сайн сайжруулах ёстой.

Өнөөдрийн энэ малын индексжүүлсэн даатгалын хууль хэрэгжээд 11 жил болж байна. Мөн дээрээс нь одоо өнөөдрийн энэ өөрчлөлт орсноор багахан дэмжлэг болно л гэж ингэж харж байгаа. Яг цогц утгаар нь харах юм бол энэ ХАА-н даатгал тэр дундаа МАА-н даатгалыг маш олон талаас нь харах ёстой юм билээ гэж ингэж боддог.

Төр тодорхой хэмжээнд оролцох ёстой гээд. Одоо жишээ нь 2023, 2024 оны энэ гамшгийн асуудал чинь Монгол ер нь эдийн засгийн үнэлгээгээрээ бол 1.6 их наяд төгрөгийн хохирлыг Монгол Улсын эдийн засагт малчдад учруулсан ийм л айхтар зүйл байгаа. Тэгэхээр энэний эсрэг бид гамшгийн эрсдэлийг бууруулах тал дээр ганцхан зуд гэдэг энэ хүчин зүйлийг харахаасаа илүүтэйгээр харах ёстой. Нөгөө талдаа та өөрөө бол яг энэ салбарын эдийн засагч хүн. Энэ даатгалын салбарын эрх зүйн орчныг өшөө сайжруулах ёстой гэдэг дээр би 100 хувь санал нэг байгаа. Энэ хуулийг боловсруулах явцад ч өшөө тод харагдлаа. Амьдрал дээр яг малчидтай уулзаад явж байхад ч гэсэн яг л энэ асуудлыг ярьдаг юм аа гэдгийг хэлье.

Дараагийнх нь таны 2 дахь асуулт бол тэр малчдыг бараг албан журмын юм шиг даатгалд хамруулах энэ зүйл заалт байна аа гээд. Тэгээд ажлын хэсэг Засгийн газраас энэ ялангуяа төрөөс үзүүлж байгаа хөнгөлөлттэй зээл тусламжид малчин хүн хамрагдахаар болох юм бол малын индексжүүлсэн даатгалд зайлшгүй хамрагдах ёстой гэсэн зүйл орж ирсэн. Ажлын хэсэг энэн дээр бол олон талаас нь ярьсан. Ярьж байгаад энийг хууль санаачлагчид нь буцаах саналтай байгаа.

Тэгэхээр энэ удаа хуулийн өөрчлөлтөд бол тэр хөнгөлөлттэй зээл авахын тулд даатгалд хамрагдах ёстой гэдэг энэ зүйл заалт байхгүй болж байгаа. Яах вэ арилжааны банкнууд эд нар бол янз янзын нөхцөлүүд тавьдаг. Ядаж төр тухайн хүн амжилтаа үнэлүүлэх байдаг юм уу, өөр төрийн ямар нэгэн үйлчилгээ авахад малчин хүнээс тэр даатгалын заавал хамрагдах ёстой эд нар гэдэг ийм зүйл заалтуудаа, ер нь энэ журмуудаа хасчихмаар юм билээ гэж би бодож байгаа. Жишээ нь сумын аварга болохын төлөө тэгээд энэ чинь Монгол Улсад 330 сум байгаа. Жилд нэг сумаас 10 сумын аварга төрдөг байлаа гэхэд л ердөө автоматаар энэ чинь 3 мянган хүнийг даатгуулчхаж байгаа байхгүй юу.

Тийм тэгэхээр энийг больчихмоор юм билээ.

Н.Учрал: Мэндчилгээ дэвшүүлье. Тэмүүлэл дартс Мастерс клубийн багш, дасгалжуулагч тамирчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд спортын өндөр амжилт хүсье ээ.

Банзрагчийн Түвшин гишүүн тодруулна.

Б.Түвшин: Тэгвэл сая Идэрбат гишүүний хэлснээр бол энэ Малчдын тухай хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа заалтаа бол хасаж байгаа юм байна аа. Энэ

тохиолдолд энэ даатгал өөрөө сайн дурын даатгал гэдгээрээ үлдэнэ ээ. Тэгвэл энийг бол дэмжих боломжтой. Ер нь дараагийн алхам нь бол төрийн даатгал ялангуяа энэ малын эрсдэлд орох нь өөр хэлбэрээр орох юм шүү. Хөнгөлөлтийг нь, хийх эрсдэлийг нь бүтэн даах энэ тэр гээд арай өөр бодлого байдлаар орох учраас энэ даатгалын компани хэлбэрээр энэ эрсдэлд оролцож байгаа асуудал дээр дараа дараагийн алхам дээр бол анхаарах хэрэгтэй гэж ингэж үзэж байна. Тэгээд энэ орж ирж байгаа хуулийг саяын тэр малчны тухай хуульд орсон өөрчлөлтийг нь хасах байдлаар нь дэмжиж байгаагаа илэрхийлье ээ.

Н.Учрал: Банзрагчийн Түвшин гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, үг хэлж дууслаа. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар БОХХАА-н байнгын хороонд шилжүүлээ.

11.05 цаг

Дараагийн асуудалд оръё.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Нийт 2 төсөл гишүүд танхимд цуглая. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг Байнгын хороод бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Гишүүд танхим цуглая. Дамдинням сайд Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн баталлаа шүү, санал хураалт явууллаа.

Тэр малын индексжүүлсэн даатгалын хууль эцэслэн баталъя. Бадамсүрэн сайд. Хуулийн төслүүдийн эцэслэн батлах хувилбарыг Байнгын хороод бэлтгэн гишүүдэд тараасан байна. Одоо ер нь гишүүдэд нэг их тараахаа болино. Энэ цаасаар. Энэ дэлгэц дээр чинь документ дотор орчихсон байгаа биз.

Хэлэлцэх асуудал чинь ингээд дарааллаараа гарчихсан байгаа биз? Ирц чинь ингээд олон нийтэд ил байгаа биз. Ман 68-52, Ан-42-28, ХҮН 8-8.

Энэ документ дотор энэ яагаад ороогүй юм энэ асуудал. Тэрнээс биш оруулаад эхэлчихсэн. Ирц дотор байна. Одоо ингээд энэ дэлгэц ингээд ашигладаггүй дэлгэцийг ашиглана. Оны өмнө энэ парламент.мн дээр хиймэл оюуны шинжилгээ гээд булан ажиллуулж эхэлж байгаа шүү. Их Хурлын гишүүд, Засгийн газар хууль барихдаа тэр парламент.мн дээр ороод хуулиа аплөөд хийгээд үзвэл хүний эрхийг зөрчиж байгаа бүх заалтууд, улс төрийн эрх, эрх эрх чөлөөг зөрчиж байгаа заалтууд, эдийн засгийн эрх чөлөөг зөрчиж байгаа заалтууд, Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа заалтууд гарч ирнэ.

Цаашдаа Их хурал, Үндсэн хуульд тусгагдсан эрх, эрх чөлөөтэй холбоотой заалтуудыг зөрчсөн хуулийг хүлээж авахгүй. Тэгэхээр субъектив байдлаар биш тэрийг эй ай дүгнэнэ. Тэгэхээр хууль барихаасаа өмнө парламент.мн дээр оруулж хэвших хэрэгтэй. Оны өмнө ашиглалтад оруулна. Эрх зүйн дүн шинжилгээ бол тэгж л хийж эхэлнэ. Тэрнээс одоо нөгөө танил тал хөөцөлддөг референтүүд рүү залгадаг миний хуулийг хурдан оруулаач, тов тогтоож өгөөч гэдэг юм байхгүй болно оо.

Тийм учраас парламент.мн дээр хандах хэрэгтэй.

Дамдинням сайд аа санал хураалаа шүү. Нөгөө сонсголынхон та чинь сонсголд орж гэрчээр дуудагдаагүй юм уу? Аан нөгөө сонсгол дээр байгаа гишүүдийг орж ирж санал хураалтад оролцуулах уу? Энэ чинь 64 хүрэх ёстой шүү дээ. Санал хураалтад бэлдүүлье тэгэх үү? Санал хураалтад бэлтгэе.

Бэлэн 36, бэлэн бус энэ чинь 56 ороогүй байгаад байх юм сая дарж амжаагүй тиймээ? Шинэчлэхээр нэмэгдээд хэд орж байна. 56 болсон байна. Дамдинням. Сайд аа тэр хэн хаана байна? Бадамсүрэн Бадамсүрэн сайд энэ чинь

Малын индексжүүлсэн даатгалын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах гэж байгаа.

Тэгэхээр 2 сайд хууль чинь батлагдах гэж байна. Энэ чинь 64 хүрэхгүй бол батлагдахгүй ингээд эцсийн хэлэлцүүлэг хийсэн нь хамаагүй болно шүү дээ тийм биз? Урд талын эгнээнийхэн байхгүй байна? Хаана байна? Өнөөдөр энэ Баттулга гишүүн хүртэл ирчихсэн байна. Та нар харж байгаа биз. Тэр хүмүүс хаана байна? Дамдинням сайд.

Үгүй ээ таны хуулийг батлах гэж байна шүү дээ. Таны Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль шүү лээ. Бүлгийн дарга нар манай энэ бүлгийн дарга чөлөөтэй байгаа. Цогтгэрэл дарга. Ер нь энэ АН-ын бүлэг хангалттай байгаа. Ирцэд маш идэвхтэй байгаа. Сая Бейсен гишүүн надад их хариуцлагатай үг хэлж байна шүү дээ. Ахмадууд ингээд туршлагатай хүмүүс ингээд суугаад байхад залуучууд хаана байна гэж гэж Бейсен гишүүн хэлж байна. Үнэн л дээ. Энэ залуучуудыгаа дууд аа энэ ахмадууд ингээд хариуцлагатай суугаад л байна шүү дээ гэж хэлж байна.

АН-ын бүлэг ирц байгаа, ХҮН нам 100 хувь байгаа. Манайх нөгөө сонсгол болоод байна л даа. Энэ ОТ-н сонсгол зохион байгуулагдаад. Тэнд нөгөө гэрчээр дуудагдсан хүмүүсээс шууд асуултууд асуугдаад яваад байгаа учраас ингээд ирц ингээд ийм байдалтай байна. Тэр сонсгол чинь олон нийтэд нээлттэй ийм сонсгол болж байна. Шууд санал хураалаа.

Хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг Байнгын хороод бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Энэ чинь Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2 хууль. Энэ чинь нэг Дамдинням сайдын ганцаарангийн ч хууль биш шүү. Засгийн газар кабинетаараа оруулж ирээд нэн яаралтай горимоор хэлэлцэж байгаа шүү дээ. Энэ улс орны нэн тулгамдсан асуудлыг шийдэх гээд л өргөн барьсан хууль. Жадамбын Энхбаяр сайд сая хэлэлцээр батлуулах гээд л. Энүүгээр чинь юу болов?

Баатархүү гишүүн ирсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар ЧД-ийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. ЧД-ийнхээ иргэдэд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Баатархүү гишүүний урилгаар манай дүүргийн иргэд ирсэн байна аа. Баатархүү гишүүн идэвхтэй санаачилгатай сайн ажиллаж байгаа.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

Тэгээд яах вэ? Ирцээр л санал хураая. Төхөөрөмж ажиллахгүй байгаа юм уу? Бэлтгэхэд оролцоогүй юу. Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Бүгдэнд нь өглөөний мэнд хүргэе. Тэгээд сая ирцдээ хараахан юу санал хураалтынхаа ирцэд орж амжсангүй. Улаан асчихлаа. Төхөөрөмж гацаад. Тэгэхээр дахин санал явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна аа. Баярлалаа.

Н.Учрал: Мөнхсоёл гишүүн нөгөө санал хураалтад бэлтгэх ирцэд ороогүй байсан байна. Тийм учраас техник ажиллаагүй. Тэр санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн Мөнхсоёл гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

61 гишүүн дэмжиж, 66.3 хувийн саналаар Мөнхсоёл гишүүний горимын санал дэмжигдлээ.

Түр хороог дуудаад байна шүү дээ. Тэгээд яах вэ Түр хорооны сонсгол зохион байгуулагдаж байгаа учраас олон гишүүд сонсгол дээр байна. Түүнийг ойлгох хэрэгтэй. Энэ ирцэд орчхоод гарчихсан байгаа гишүүдийг танхимд урья.

Бадамсүрэн сайд, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Баярбаатар, Лувсанжамц, Мөнхбаатар гишүүн, Номтойбаяр гишүүн, Одбаяр гишүүн, Очирбат гишүүн, Сайнзориг гишүүн, Туваан сайд яасан. Дамдины Цогтбаатар гишүүн, Цэнгүүн гишүүн, Шижир гишүүн ирцэд орчихсон мөртөө байхгүй байгаад байна.

Хаашаа юм? Сонсгол руу ороод 5 гишүүн байгаа. Тэгээд 5 минут завсарлалчихвал санал хураалтад оролцуулчихмаар байна. Үгүй ээ үгүй энэ сонсгол дээр, сонсгол дээр. Дамдинням сайд ороод ирэх үү?

Нэг ирцийн санал хураалт явуулъя. Гишүүд хариуцлагатай байя. Ирцийн санал хураалт.

Ирцийн санал хураалт.

Алдараа дарга орж амжсангүй. Ирцийн санал хураалт.

Бүлгийн дэд дарга, Отгонбаяр, Ариунзаяа, Алдаржавхлан гишүүн нар. Бүлгийн дэд дарга нар. Их Хурлын дэд дарга. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг.

Сонсголд байгаа гишүүд ороод ирсэн үү? Сонсголоос гишүүд орж ирж байна. Туваан сайд ороод ирлээ. Ингээд ирц бүртгэлийн санал хураалт нэг явуулчихъя. Бүртгэлийн санал хураалт.

69 гишүүн дэмжиж, энэ бүртгэл 75 хувь нь ирцэд бүртгэлээ баталгаажуулсан байна. Баярлалаа. Сайд нар орж ирсэн байна. Баярлалаа.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

69 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

73 гишүүн дэмжиж 79.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт баяр хүргэе.

Хууль тогтоомжоо хэрэгжүүлж, хариуцлагатай ажиллахыг хүсье ээ Дамдинням сайд. Амжилт хүсье.

11.34 цаг

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр танилцуулна аа. Отгонбаяр гишүүнийг индэрт урьж байна.

Мэндчилгээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сэддоржийн урилгаар Өмнөговь аймгийн ЗДТГ-ын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Өмнөговь аймгийнхаа ЗДТГ-ын төрийн албан хаагч та бүхэндээ ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье ээ.

У.Отгонбаяр: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчилсэн найруулгыг баталж 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн билээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу шууд болон төлөөллийн байгууллагаар уламжлан нутгийн нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй гэж зааснаар шат шатын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн орон нутгийн нийт иргэд сонгогчдын төлөөллийн байгууллага юм аа.

Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, төлөөллийн байгууллагаараа дамжуулан нутгийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох эрхийг хуульчилж өгсөн атлаа шат шатын иргэдийн төлөөлөгч нарын хуульд заасан үндэслэл, журам нэрийн дор эрх зүйн байдлын хувьд ялгамжтай байдал үүсгэж байгаа нь төлөөллийн байгууллагаараа дамжуулан нутгийн удирдах ёсны үйл ажиллагаанд оролцох иргэдийн эрх оролцоог ялгаатай түвшинд хүргэж байна аа.

Иймд:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт сумын ИТХ-ын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно гэж заасан дээрх зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлж, хувь хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна аа.

Монгол Улсын хэмжээнд боловсон хүчний тоо эрс багасаж төрийн бүх шатын байгууллага, түүнчлэн төсвийн болон орон нутгийн өмчит компани, ААНБ-д ажиллах боловсон хүчний дутагдал үүсэж байгаа бөгөөд уг асуудлыг бодлогын түвшинд цогцоор нь шийдвэрлэх зайлшгүй шаардлага үүсэж байна аа.

Хөдөө орон нутаг болон алслагдсан сум дүүрэгт ажиллах боловсон хүчний дутагдлыг нөхөх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, харьяалагдаж буй ИТХ-ын төлөөлөгч нарын тодорхой хувийг төрийн захиргааны албан хаагч байхаар хуульд өөрчлөлт оруулж Үндсэн хуульд заасан хуулийн өмнө тэгш эрх эрхтэй байх зарчмын шаардлагыг хангах, хууль зүй, нийгэм, эдийн эдийн засгийн чухал ач холбогдолтой юм аа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Н.Учрал: Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна. Индэрт урья.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүдээс 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 35.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа явууллаа. Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр хуулийн төслийг танилцуулахдаа, аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдох цаашлаад төлөөлөгчөөр ажиллах хүсэл сонирхолтой иргэдийн тоо буурсан. Одоо ажиллаж байгаа иргэдийн төлөөлөгч нар төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусмагц дахин сонгогдохоор нэр дэвшихгүй байх, мөн бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө төлөөлөгчөөс огцрох хүсэлтээ илэрхийлэх явдал цөөнгүй гарах болсон төдийгүй улсын хэмжээнд ажиллах боловсон хүчний тоо хэмжээ эрс буурч төрийн бүх шатын байгууллага төсвийн болон орон нутгийн өмчит компани ААНБ-д ажиллах хүний нөөцийн дутагдал орон нутгийн түвшинд бодитой үүсэж байгаа нь тус хуулийн төслийг боловсруулах үндэслэл болсныг дурдсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Г.Уянхишиг, С.Зулпхар, Ц.Сандаг-Очир нар асуулт асууж, хариулт авлаа. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд улсын хэмжээнд 330 сумд хүн ам бодитоор цөөрч хүй элгэний зохион байгуулалтын хэлбэртэй болсон энэ үед иргэдийн төлөөлөгч, төрийн захиргааны албан хаагч байх зохистой хувийг нухацтай ярилцах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ орон нутагт иргэдийн хурлыг чадавхжуулж хурлын шийдвэр гаргах чадавх сайжирдаг шатлан дэвших боломжийг нэмэгдүүлдэг уг зохицуулалтыг үзэл баримтлалын хувьд дэмжиж буйгаа илэрхийлээд цаашид төрийн албан хаагч төрийн албанаас гарч орон нутгийн сонгуульд өрсөлдөн сонгогдоогүй тохиолдолд төрийн албанд буцаж ажиллах боломжийг судлан үзэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар уг төслийг дэмжихийн зэрэгцээ цаашид төрийн албаны тухай хууль болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг нийцүүлэх, түүнчлэн орон нутагт ялгавартай байдлыг үүсгэж буй Төрийн хэмнэлтийн тухай хуулийг эргэж харах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн тодорхой хувь нь тод төрийн захиргааны албан хаагч байж болох бодит хэрэгцээ шаардлага тулгамдаж байгаа талаар тус төслийг дэмжихээ илэрхийлж, цаашид Төрийн албаны тухай хуулийн холбогдох зохицуулалтын нийцлийг хангах нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно оо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 35.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж хариулт авна аа. Доржзовдын Энхтуяа гишүүн.

Д.Энхтуяа: Энэ Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль 2020 онд батлагдсан. Одоо яг оруулж ирж байгаа энэ 38.6 дахь энэ заалт бол 2024 оны орон нутгийн сонгуулиас хойш хэрэгжиж эхэлсэн. Энэ нь юу юм гэхээр сумын ИТХ-ын 3-ны 1 хувь нь төрийн захиргааны жинхэнэ албан хаагч байж болно гэсэн ийм зүйл заалт байгаа.

Тэгэхээр энэ зүйл заалтыг бол өөрчлөхөөр оруулж ирж байгаа юм байна аа. Сая бол илтгэгч хууль санаачлагч хэлэхдээ ер нь бол ажиллах хүчний хомсдол гэсэн ийм шалтгааныг хэлж байна л даа. Тэгэхээр яг энэ шалтгааны улмаас энэ 2020 онд батлагдсан энэ хуулиар сумын иргэдийн хурлын төлөөлөгчдийн 3-ны 1 нь төрийн захиргааны жинхэнэ албан хаагч байна аа гээд заалт оруулж өгсөн юм аа. Одоо яг ингээд сум, аймаг, нийслэл гэж ингэж нэмж оруулж ирж байгаа юм байна аа. Би бол 2020 онд Нийслэлийн төлөөлөгчөөр ажиллаж байхад Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн 45 төлөөлөгч байлаа гэхэд ер нь бол 45-уулаа төрийн өмчит ААН-ийн дарга болоод явчихдаг. Гэтэл энэ хуулийн 35 дугаар зүйлд ИТХ бол 35.1.15-д бол хурлын шийдвэрийг хэрэгжүүлж Засаг даргынхаа үйл ажиллагаанд хяналт тавина аа. Засаг даргыгаа томилно үйл ажиллагаанд нь хяналт тавина. Болохгүй болбол одоо огцруулах ийм зүйл заалттай байгаа. Харамсалтай нь одоо ингээд 50 хувь нь төрийн захиргааны жинхэнэ алба хаагч болчихоор нөгөө Засаг даргатайгаа эргээд хариуцлага тооцох ямар ч боломжгүй болчихдог юм аа. Жишээ нь нийслэлийн иргэдийн хуралд одоо бол 45 төлөөлөгчийн 40 нь энэ ТӨК-удын захирал байж байгаа.

Гэтэл нөгөө сонгочихсон Засаг даргадаа хяналт тавиад хариуцлага тооцох ямар ч механизм байхгүй байгаа. Эргээд Засаг даргынхаа доор орчихоор Засаг даргадаа загнуулаад үйл ажиллагаа нь ямар ч бие биеийгээ хянах боломжгүй ингээд явж байгаа. 2020 онд энэ хуулийг батлах гэж байхад хэлж байсан Засаг даргаар ажиллаж байсан Амарсайхан дарга хэлж байсан. Энийг бол хуульчлаад иргэдийн Хурлын Төлөөлөгч нь төлөөлөгчөө хийгээд, Засаг даргаа томилоод, ажилд нь хяналт тавиад хариуцлага тооцоод огцруулаад ингэж явах ёстой. Энийг ингэж өөрчилнө өө гэсэн боловч ингээд тухайн үед олонхоороо энэ хуулийг ингэж баталсан юм аа. Тэгэхээр одоо ингээд аймаг нийслэл гэж оруулж ирж байгаа нь энэ нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээнд халдсан ийм зүйл заалт биш үү. Та ямар одоо судалгаан дээр үндэслээд ингээд яг энэ жишээлбэл Нийслэлийн иргэдийн хурлыг жишээлбэл яриад байна л даа би. Сум дээр ойлгомжтой. Хүн амын

тоо бол маш цөөхөн учраас бас ийм зохицуулалт байж болох юм аа гэдэг үүднээс энэ хуулийг тухайн үед ингэж оруулж байсан юм аа. Тэгэхээр ямар судалгаан дээр үндэслээд өнөөдөр Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн 50 хувь нь ийм захиргааны албан хаагч, төрийн алба агч байж болно гэсэн ийм судалгаан дээр үндэслэсэн юм бэ? Өнөөдөр бол 1.7 сая хүн амьдарч байгаа Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын үйл ажиллагаа бол яг энэ нэгжийнхээ хуулиар захирагдах энэ хариуцлага тооцох энэ механизм бол байхгүй үгүй болчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол энэ буруу зүйл заалт орж ирж байна уу гэж миний хувьд харж байгаа юм. Тэгэхээр та бас судалгаан дээр үндэслээд энэ хуулийг санаачилсан байх. Тэгээд таны энэ судалгааны дүгнэлтийг сонсьё.

Н.Учрал: Отгонбаяр гишүүн хариулна.

У.Отгонбаяр: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Сая энэ бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын энэ хуулийн өргөжүүлж байгаа нь гол ач холбогдол нь нутгийн удирдах ёсны удирдах өөрөө ёсны байгууллагын чадавхыг ний нуугүй хэлэхэд нэмэгдүүлж байгаа юм. Одоо жишээ нь та сая нийслэлийг ярьж байна л даа. Нийслэлийн ТАЗ-өөс өгсөн надаа судалгаагаар нийслэлийн 45 төлөөлөгчийн 35 төрийн албан хаагч буюу төрийн үйлчилгээ улс төрийн алба хашиж байгаа. Энд бол нэг ч төрийн захиргааны албан хаагч байхгүй. Бид бүхэн илүү төрийн захиргааны тодорхой хувийг нь төрийн захиргааны алба хашдаг энэ чиглэл рүү нь л явуулж байгаа юм. Яагаад гэвэл одоо аймаг, нийслэл, дүүрэгт дэвших хүн ний нуугүй хэлэхэд бас ховор байдаг. Яагаад гэвэл төрийн захиргааны алба хаших боломжийг нь өшөө бүүр хаачхаж байгаа байхгүй юу.

Тийм учраас тухайн иргэдийн хурлын төлөөлөгч нарын 50 хүртэлх хувийг төрийн захиргааны алба хаах энэ боломжоор нээж байгаа юм. Энэ маань өөрөө нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавхыг улам бэхжүүлж сайжруулах юм. Салбар салбарын төлөөллүүд төрийн захиргаанд ажиллаж төрийн захиргааны байгууллагад ажиллах энэ боломж үүд хаалгыг л илүү нээлттэй өргөн болгож өгөх энэ л боломж бүрдэж байгаа юм аа гэдгийг дуулгая. Энэ ганц нийслэлийн асуудал биш. Жишээ нь нийслэл дээр нэг ч түрүүн би хэлсэн нэг ч төлөөлөгч төрийн захиргаанд ажиллаагүй. Дандаа төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн үйлчилгээ, улс төрийн алба хашиж байгаа ийм л статистик тоон үзүүлэлт байгаа юм аа.

Тийм учраас энэ энэ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бодлогын эсрэг зүйл огтоосоо биш ээ гэдгийг би дуулгая. Баярлалаа.

Н.Учрал: Тодруулах уу? Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: Тэгээд яах вэ өөрчлөлтөөр бол сумын Иргэдийн Хурлын асуудал ярьж байсан бол та аймгийн, нийслэлийнхэн ингээд ярьж байна тиймээ? Тэгэхээр нийслэлийн 45 төлөөлөгчийн 50 хувь нь төрийн жинхэнэ захиргааны албан хаагч болох юм байна аа. Тэгэхээр бол бас таны саяын ярьсан тайлбар бол хөндөгдөх нь гэж ойлголоо. Тэгвэл Их Хурлыг яагаад оруулж болохгүй байгаа юм. Их Хурлыг оруул оруулаад Их Хурлын гишүүдийн 50 хувь нь Засгийн газрын гишүүн байж болно. Мөн Их Хурлын гишүүдийн 50 хувь нь төрийн захиргааны жинхэнэ албан хаагч байж болно гэж оруулбал ямар вэ? Та энэ дээр хариулт өгөөч.

Н.Учрал: Отгонбаяр гишүүн.

У.Отгонбаяр: Энэ нэгжийн тухай хуульд энэ Их Хурлын асуудал ер нь хөндөгдөөгүй ээ. Тийм учраас яг энэ чиглэлээр манай хууль санаачлагчид ажиллаагүй. Тийм учраас би энэ дээр тодорхой хариулт хэлж мэдэхгүй байна. Ний нуугүй хэлэхэд. Нийслэл, аймаг, дүүрэг гэж байгаа. Тусгайлан авч үзсэн учраас энэ чиглэл рүү түлхүү хандаж байгаа гэдгийг дуулгая аа.

Н.Учрал: Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Энэ 2008 онд орсон Төрийн албаны тухай хуулиар төрийн жинхэнэ албан хаагч улс төрөөс ангид байх ёстой гэдэг ерөнхий агуулга орсон байдаг. Тэгэхээр одоо энэхүү оруулж байгаа энэ сумын, дүүргийн, аймгийн, нийслэлийн ИТХ-ын 50 хувь нь төрийн захиргааны ажил хийнэ гэдэг ийм боломжийг олгочихоор нөгөө энэ хуультайгаа нэлээн зөрчилдөх асуудал үүсэх үү гээд энэ бодлоготойгоо нэлээн зөрөлдөж байна уу даа гээд нэг асуулт байна.

Хоёрт болохоор яг энэ өөрчлөлт орсноор аймаг, дүүрэг, сумд дээр нөгөө төрийн захиргааны албан хаагчдын шилжилт хөдөлгөөн дээр нэлээн асуудал гарах юм биш биз дээ гэсэн ийм асуултууд байна.

Н.Учрал: Отгонбаяр гишүүн.

У.Отгонбаяр: Соронзонболд гишүүний асуултад хариулъя аа.

Хэрвээ энэ нэгжийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хэрвээ батлагдвал, батлагдаад гарвал бид бүхний төсөөлж байгаагаар 6 сарын 1-ээс 2026 оны 6 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх юм. Тэр хүртэл одоо төрийн албан дээр Төрийн албаны тухай хуульд дээр заагдсан тодорхой зөрчлүүдийг арилгах, засаж залруулах, нэмэлт оруулах энэ ажлууд ингээд үндсэндээ энэ 12 сарын энэ намрын чуулганаас хийгдээд явах юм аа.

Тийм учраас энэ маань хоорондын зөрчил арилаад явах энэ боломж бүрдэх юм. Дараагийнх нь асуудал энэ хууль батлагдангуут л тэгээд л сум, аймаг, дүүрэг, нийслэлийн төлөөлөгчдийн 50 хувь нь шууд автоматаар төрийн захиргааны албан хаагч болоод явчихгүй ээ. Энэ чинь тухайн албан дээрээ тухайн ажлын байран дээр тавигдсан тусгай шаардлага байгаа. Ажилласан жил, мэргэжил, мэргэшсэн байдал гээд энэ шаардлагыг хангаад тухайн ажлын байран дээр ажилтан хүн ажиллах энэ боломж бололцоо нь бүрдвэл тэнд ажиллах тэгээд дээрээс нь шалгалтын асуудал байна. Төрийн албаны ерөнхий шалгалт, тусгай шалгалтуудыг өгч тэнцсэн нөхцөлд л тухайн албан дээр ажиллах энэ боломж бүрдэнэ ээ. Тэрнээс биш хууль батлагдаад л маргааш нь бөөн шилжилт хөдөлгөөн хийгдээд байх зүйл огтоосоо байхгүй ээ гэдгийг дуулгая аа. Баярлалаа.

Н.Учрал: Алтаншагай гишүүн.

Н.Алтаншагай: Өдрийн мэнд хүргэе. Хуулийн төслийг агуулгын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ анхаарах хэдэн зүйлүүд байгаа юм. Тоо хэмжээ хувь хэмжээн дээр нь бас онцгойлон анхаарах. 2009 оны 1 сарын 1-ээс энэ улс төрийн намаас энэ төрийн албан хаагч ангид байх гэсэн энэ агуулгатай хууль батлагдаад явсан. Тэгээд амьдрал баян юм болохоор энэ сум орон нутагт яг энэ намаас дэвшиж

байгаа боловсон хүчний асуудал дээр аль ч намууд асуудал үүссэн байгаа. Бүх намууд. Тэгэхээр энэ дээрээ онцгойлон анхаарах мөн төрийн албанд болон хувийн хэвшилд ажиллаж байсан хүмүүс маань яг ялангуяа энэ төрийн албанд ажиллаж байсан хүмүүс энэ улс төрийн энэ сонгуульт аймаг сум дүүргийн иргэдийн хуралд өрсөлдөхөөрөө яг төрийн албаараа давхар хашиж болохгүй ажлын байраар бас хангагдах нөхцөл байдал тааруу гэсэн ийм гомдол саналууд нэлээн гарч ирсэн.

Тэгэхээр энэ дээр одоо агуулгын хувьд тэр тоо хувь хэмжээн дээр нь онцгойлон анхаарч засаж оруулах нь зөв байх. Аймаг нийслэлийн хувьд бол одоо бас 50 хүртэл гэдэг бол хэтийдсэн тоо байх. Энэ дээр хувь хэмжээг нь бууруулах мөн хуулийн төсөл дээр орж ирсэн байна лээ. Мэргэшсэн яг тухайн ажил албан дээр төрийн захиргаан дээр мэргэшсэн мөн шаардлага хангасан байх гэсэн энэ нь шалгуур нь зөв байх. Агуулгын хувьд дэмжиж байгаа. Тэр тооны хувь хэмжээн дээр нь бууруулах дээр зөв байх аа гэсэн ийм саналтай байгаа. Баярлалаа.

Н.Учрал: Алтаншагай гишүүн санал хэллээ.

Мөнхсоёл гишүүн байхгүй байна. Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ хуулийн өөрчлөлтийг дэмжиж байгаа юм аа. Тэгэхдээ 1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль дээр нэг анхаармаар юм байгаа юм. Орон нутгийн иргэдийн хурлын нэр хүнд нь буучихсан. Хуучин иргэдийн Хурлын тэргүүлэгчид гээд байсан. Тэрийг зөвлөл болгочихсон. Саяын ярьж байгаа төрийн албанд томилж байгаа улсуудыг өндөр шалгууртай. Тэр чинь төсвийн ерөнхийлөн захирагч нар томилогдох гээд байгаа шүү дээ. Тэргүүлэгч дээр оруулж байж төрийн албаны шалгалт тусгай шалгалт өгсөн үү гэж тэгж байж хянадаг байсан. Одоо зарим Засаг дарга нар бол шууд дээшээгээ явуулчихдаг. Тэгээд шаардлага хангахгүй бол дараа нь дахин солих асуудал гарч байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ талын асуудал дээр анхаармаар юм. Орон нутгийн Иргэдийн Хурлын нэр хүндийг яахгүй бол одоо төсөв батлуулахдаа Их Хуралтай адилхан зарим батлуулах юмыг иргэдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулдаг байсан байхгүй юу. Одоо энэ зарим Засаг дарга нар дураараа дургиж байгаа асуудал бай байгаа шүү төсвийн захирагч нар.

Тийм учраас энэ талын асуудал дээр Отгонбаяр гишүүн анхаараад шийдэхгүй бол бас хуулийн төсөлд оруулах нь зөв байх гэж бодож байна.

Хоёр дахь нэг санал байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн юун дээр нутгийн өөрөө удирдах ёсон дээр жишээлбэл тусгай хамгаалалттай газрууд нэг аймгийн дотор байгаа тусгай хамгаалалттай газрыг нөгөө аймгийн тусгай хамгаалалттай газарт өгчихдөг. Тэгээд тусгай хамгаалалттай газрын захиргаа гээд баахан орон тоо нэмчихсэн.

Тухайн аймагт нь байгаль орчны тусгай хамгаалалттай газрын захиргаа нь байж байхад дахиад нэг тусгай хамгаалалттай газрын захиргаа бий болдог. Тэгээд орон нутагт өгүүлэх талын асуудал дээр тэгээд анхаарахгүй бол тийм бүтэц хоорондоо тэлээд төсвийн хэтрэлтийн асуудал нөлөөлж байгаа асуудал байгаа байхгүй юу. Энийг анхаарна уу гэдгийг хэлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Санал хэллээ Б.Бейсен гишүүн санал хэлсэн тиймээ. Бат-Эрдэнэ гишүүн байхгүй байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа энэ хуулийг хэлэлцэхийг зарчмын хувьд дэмжиж байна. Яах вэ зүгээр оруулж ирж байгаа хуулийн төсөл дээр бол олон хувилбарууд ярих бололцоо харагдаад байгаа юм. Тийм учраас хэлэлцэхийг дэмжиж байна. Мэдээж 2 талтай. Энэ эрсдэлүүдийг ч гэсэн бодолцоод нэг хэлэлцүүлгийн явцад хийгээд сайжруулах бололцоо харагдаж байна аа гэж би зүгээр хувьдаа бодож байгаа учраас хэлэлцэхийг дэмжиж байна.

Энэ хуулийн төслүүдийг зүгээр хараад байхаар бид нарт үнэхээр тулгамдаад байгаа төрийн албаны реформ яригдахаас өөр аргагүй байна аа гэдэг зүйлийг л хэлж байна. Сонгуулийн хууль тогтоомжийг сайжруулах асуудал яригдахаас өөр аргагүй байна аа гэдэг зүйлийг л илтгээд байна. Тэгэхээр би юу ярих гэж байна гэхээр ер нь зүгээр заавал орон нутгийн түвшинд ажиллаж байж энэ яам, тамгын газарт ажилладаг бас нэг ерөнхий ийм шалгуур байж байж боловсон хүчний урсгалыг доороос нь дээшээ ингэж бэлтгэж гаргаж ирэх энэ бодлого руугаа явах цаг болж.

Тэгэхээр энийг зүгээр цааш цаашдаа уялдуулж ярилцах ёстой. Ер нь зүгээр яах вэ бодит байдал дээрээ сумын түвшинд бараг дэвших хүн олдохгүй эргээд яг ажил албатай хүмүүс нь ажлаа өгөөд сонгуульд оролцох боломжгүй болчихоод байгаа энэ бол үнэн. Тэгээд бараг хамгийн ах дүү олонтой нь л нэгийгээ дэвшүүлчихдэг. Иймэрхүү л байдлаар явж байгаа л даа. Тэгээд сүүлдээ энэ ах дүү нарын бараг хурал болж л таараад байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэ өөрөө эргээд ингээд Монгол төрийн шийдвэр тэр орон нутгийн анхан шатан дээр очиж хэрэгжих үү үгүй юу тэрэн дээрээс иргэдийнхээ санал хүсэлтийг аваад яг дээд шатын байгууллагадаа гаргаж ирэх үү, үгүй юу гэдэг дээр бас асуудлууд үүсэж байгаа үнэн. Тэгээд энэ чинь ерөөсөө л 2, 3 ах дүү олонтой хүмүүсийн бараг хэрүүлийн талбар болчихдог юм байна лээ шүү дээ зарим сумын хурал чинь.

Тэгэхээр энийг ингээд шийдэх энэ оролдлогуудыг бид нар дэмжинэ ээ.

Хоёрдугаарт яах вэ зүгээр ингээд орон нутгийн сонгуульд ороход бас ингээд төрийн, сумын түвшинд ингээд зөвшөөрч байгаа боловч энийг зөвхөн төрийн захиргаагаар биш уг нь төрийн үйлчилгээг хамруулах бодолцвол яадаг юм гэж зүгээр бодол байна. Энийг зүгээр бас хэлэлцүүлгийн явцад ингээд анхааръя.

Хоёрдугаарт энэ орон нутгийн сонгуулийг ер нь зөвхөн сум дүүргийн түвшинд хийвэл яадаг юм бэ гэдэг зүйл байна. Сум дүүргээсээ одоо юу гэдэг юм сонгогдоод. Тэрэн дээрээсээ дахиад нэг төлөөлөгчөө аймаг руугаа нийслэл рүүгээ илгээдэг. Жишээ нь би нийслэл дээрээ ярья л даа. Нийслэлийн 9 дүүргийн сонгууль яваад нийслэлийн 45 төлөөлөгчид яг оногдож байгаа квот квотоороо Сонгинохайрханаас нь СХД-ийнхээ хэмжээнд сонгогдсон төлөөлөгчдөөс арвыгаа сонгож санал авсан хувь хэмжээгээрээ нийслэл рүүгээ илгээдэг. Баянзүрх 10-ыг ч байдаг юм уу. Ингээд Чингэлтэй, Сүхбаатар нь хэд хэд ч байдаг юм. Ийм байдлаараа яваад хэмнэхээсээ

гадна боловсон хүчний асуудлуудыг болон яг энэ уялдаатай байдлаар орон нутгийн бодлого хэрэгжих энэ бололцоо бүрдээд байгаа юм.

Тэгэхээр ер нь зүгээр цаашдаа энэ сонгуулийн болоод төрийн албаны реформыг зайлшгүй хийх цаг болжээ.

Дээрээс нь энэ төрийн захиргааны гэж ярих уу эсвэл орон нутгийн захиргааны гээд бид нар ер нь зүгээр энэ төрийн албаны хуулийн энэ ангилал эдгээр албан хаагчид тавигдаж байгаа шаардлагыг яг бодитой болгомоор байна. Яг яам, тамгын газарт ажилладаг шаардлагыг жоохон жишээ нь орон нутагт тавих ямар ч бололцоогүй байхгүй юу. Энийг бид хэд бодитой хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байгаа юм. Харин яам, тамгын газарт ажиллах хүн заавал орон нутагт ажилладаг байх ч гэдэг юм уу. Энэ ажил амьдралыг мэдэж суралцаж дээшээ гардаг тэр зарчмыг хэвшүүлэх бодлого болгох тал дээр анхаарах ёстой. Тэгээд яах вэ энэ саналуудыг хэлэлцээд явах нь зөв байх. Тэгээд үйлчилгээний албан хаагчдыг ер нь зүгээр бодолцвол яах вэ?

Н.Учрал: Отгонбаяр гишүүн хариулъя.

У.Отгонбаяр: Сайнзориг гишүүнтэй яг санал нэг байна аа. Энэ бол яг ний нуугүй хэлэхэд сонгуулийн болон төрийн албаны шинэчлэлийн эхлэл ээ. Энэ яах аргагүй олон зүйл дээр санал нэгдэж байна. Цаашдаа энэ хууль маань батлагдвал олон зүйлийн эхлэл болох ийм боломж бүрдэнэ ээ гэж үзэж байгаа. Яах вэ энэ дээр одоо төрийн үйлчилгээ бол нэлээдгүй төрийн үйлчилгээнд нэлээдгүй ажиллаж байгаа. Хамгийн гол нь төрийн үйлчилгээний төсвийн ерөнхийлөн захирагч энэнд хамаарахгүй байгаа юм.

Тийм учраас бас энэ боломжийг хэлэлцүүлгийн явцад бид бүхэн ажлын хэсэг дээр ярилцъя аа гэж бодож байна. Давхар мөн түрүүн Алтаншагай гишүүн ярьж байна. Энэ тооны асуудал дээр яах вэ? Бид нар хуулийн төсөл дээр 50 хүртэлх гээд оруулчихсан байгаа юм. Энийг хэлэлцүүлгийн шатанд бид бүхэн ярилцана аа. Сая ТББХ-н дээр мөн ялгаагүй энэ тоон дээр гишүүд нэлээдгүй санал хэлсэн.

Тийм учраас энэ хэлэлцүүлгийн явцад тоо болон төрийн үйлчилгээний төсвийн ерөнхийлөн захирагч бас энэнд хамаарах уу, үгүй юу эд нар гээд асуудлуудыг хэлэлцүүлгийн шатад ярилцъя аа гэж бодож байна.

Н.Учрал: Сайнзориг гишүүн тодруулна.

П.Сайнзориг: Хууль санаачлагчийн хувьд уян хатан хандъя гэж байгаад талархаж байна аа. Тэгээд хэдүүлээ тал талаас нь ярья. Яг энэ дээрээс уг нь дараа дараагийн нэг зөв ойлголт реформоо чиглүүлээд явмаар байгаа юм аа. Тэгээд яах вэ? Зүгээр энэ орон нутгийн түвшинд явагдаж байгаа сонгуульд орохын тулд жишээ нь ТҮ-ийнхэн заавал ажлаа өгөх ч гэдэг юм уу ийм шаардлага тавиад тэнд ингээд багш нар ажлаа өгч чаддаггүй ч байдаг юм уу ер нь голцуу л багш нар байгаа шүү дээ. Багш, эмч нар. Нэг талдаа хэдүүлээ бас энэ улс төрөөс ангид байя гээд байгаа боловч орон нутгийнхаа түвшинд шийдэж байгаа зүйлүүд чинь нэг их тийм оролцоотой байх талаас нь дэмжих тэр хандлагыг нь орон нутгийн түвшиндээ амьдарч байгаа хүмүүст олгомоор юм шиг байгаа юм.

Аймаг нийслэл дээр арай өөр байдлаар ч гэдэг юм уу. Яг ингээд нэг зүйлийг нэг ийм уутанд хийх биш онцлогт нь тааруулсан байдлаар цаашдаа жоохон харвал яадаг юм бэ? Тэгээд яг орон нутгийн сонгуульд дэвших хүн байхгүй. Тэгээд одоо ах дүү олонтой хэдэн хүмүүс нь дэвшдэг. Яах вэ гарч ирэнгүүтээ тусгай шаардлага хангаж байвал төрийн захиргааны албан хаагч болчих бололцоотой гэдэг. Ийм нэг ийм хоёрдмол яваад байгааг ерөнхийдөө.

Н.Учрал: Санал хэллээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Энэ чухал асуудал. Энэ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулахаар санал орж ирсэн юм байна. Тэгээд энэ асуудал дээр гишүүн болгон нухацтай оролцохгүй бол өмнөх гишүүдийн бас асууж байгаа асуулт, саналтай дүйцэхүйц санаа нэг зүйлүүд байна. Энэ асуудал яагаад орж ирж байна вэ гэхээр мэдээж сонгуулийн тогтолцоо сонгуульд оролцож байгаа байдал, мөн нөгөө талдаа Төрийн албаны тухай хуулийг шинэчлэх шаардлагууд байгааг ямар нэгэн хэмжээгээр илэрхийлж байна аа. Гэхдээ энэ хуульд өөрчлөлт оруулж ирэх гэж байгаа зарим саналтай бол үнэхээрийн санал нийлэхгүй байна. Нутгийн өөрөө удирдлагын байгууллагын бүтэц зорилго нь шал өөр. Өөрөөр хэлэх юм бол тухайн одоо нутаг, аймаг, нийслэл, сум хороонд ИТХ чинь эргээд засгийн дарга тэр засгийнхаа үйл ажиллагаанд төсвийн зарцуулалтад хяналт тавих үүрэгтэй иргэдээ төлөөлж, гэтэл өөрсдөө дотор нь ороод явчихаар энэ өөрөө бас ашиг сонирхлын зөрчилтэй болно шүү дээ. Тэр утгаараа буруу гэсэн ийм саналтай байгаа юм.

Нөгөө талдаа өмнөх гишүүд ч хэлж байна. Орон нутгийн түвшинд дан ялангуяа сумын түвшинд хэцүү. Олон жилийн тэртээгээс энэ сум орон нутагтайгаа энэ хэтийдсэн улс төржилт намчирхлыг яаж бүгдээрээ зөв зүйтэй голдиролд нь оруулах вэ гэдэг ийм асуудал яригдсаар байгаа. Төгс шийдэл бол олдоогүй байгаа. Мөн хэрэвзээ энэ хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа бол энэ дээр бид нар юуг харах ёстой вэ гэхээр нөгөө зарим орон нутгийг шинэчлэн зохион байгуулах өөрөөр хэлэх юм бол төсвийн зарцуулалттай холбоотойгоор бид нар мэдэж байгаа шүү дээ.

Зарим сумд сургууль эсвэл эмнэлэг нь яг хэрэгцээт байдлаасаа илүү, нэг ангид 30 хүүхдийн ширээ байлаа гээд 10 хүүхэд сууж байх жишээтэй. Гэтэл Улаанбаатар хотод нэг партны ард 3 хүүхэд сууж байгаа. 3 ээлжээр хичээллэж байгаа гээд асуудлууд бид нар нөгөө төсвийн зарцуулалтаа илүү оновчтой илүү өгөөжтэй болох гэхээр энэ Засаг захиргааныхаа нэгжийн тухай хуульд захирагддаг зүйлүүд байдаг. Төрийн албаны тухай хууль дээр меритийн зарчим тэр олон жил ажилласан шаардлага энэ тэрүүд дээр эргэж харах зүйлүүд байдаг. Нэгэнт орчихсон бол насаараа чанаргүй ч бай, чадамж муу ч бай оршоод сууж байдаг. Гадаад, дотоод сургууль төгсөөд маш чадамжтай, маш шинэлэг, санаачилгатай тийм хөдөлмөрч хүмүүс залуучууд орох гэхээр нөгөө жил нь тээг болоод байдаг. Урамшуулах энэ тогтолцоо нь аягүй зөвхөн жил дээр дөрөөлчихсөн гэх мэт ийм том том асуудлуудыг эргэж нухацтай харах ёстой. Магадгүй хэлэлцэхээр дэмжигдвэл энэ ажлын хэсэгт нь ороод бас ажиллах сонирхол байна. Маш сайн өөрчлөлт орох ёстой, тэгэхгүй өөрчлөх гэж байгаад нөгөө нүд нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохлов гэдэг болчих вий гэж санаа зовоод ингээд үг хэлчихье л гэж бодлоо. Баярлалаа.

Н.Учрал: Энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль батлагдсанаар аймаг, дүүрэг, сумын

иргэдийн хурлын төлөөлөгч нарын 3-ны 1 нь ажил эрхлэх бололцоотой болно гэж ойлгож байгаа шүү дээ.

Суманд, дүүрэгт нэр дэвших нэр дэвшигч наргүй болсон. Ингээд иргэдийн хуралд сонгогддог. Тэгээд гарч ирээд ажил алба эрхлэх бололцоо хуулиар хориотой. Тийм учраас энэ иргэдийн Хурлын Төлөөлөгч нар маань давхар ажил алба хашдаг болохгүй бол энэ хүмүүс яаж амьдрах вэ.

Дээрээс нь хамгийн шилдгүүд нь тухайн сумынхаа тухайн дүүргийнхээ ард түмний итгэлийг авсан шилдгүүд нь сонгогдчихоод байгаа шүү дээ. Тэгээд тэд маань ажил эрхлэх бололцоогүй. Иргэдийн Хурал бол ямар нэгэн урамшуулал одоо авахаа больчихсон юм байна лээ. Юу ч байхгүй болчихсон юм байна лээ. Тэгээд хуучин 2012-2016 онд намайг энэ тэр Баянзүрхийн төлөөлөгч байхад нэг жилд гээд нэг урамшуулал өгөөд тэрүүгээрээ тойрогтоо ажилла гэдэг байсан. Одоо бол больсон юм байна. Тэгэхээр яг энэ өөрчлөлтийг хийж байгаа байх гэж энэ хуулийг ойлгож байгаа шүү дээ.

Отгонбаяр гишүүн та хариулах уу? Мөнхсоёл гишүүнийх дээр байр сууриа хэлэх үү? Санал хэлсэн үү? Тийм гишүүд шиг энэ чинь зарим тойргоос олон сонгогчтой нийслэлийн тойргууд хүртэл байгаа шүү дээ. Хувийн салбарт ажиллаж болно. Төрийн алба хийж болохгүй.

Пүрэвийн Батчимэг гишүүн үг хэлнэ ээ.

П.Батчимэг: Өнөөдөр энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль гээд хуулийнхаа хувьд үнэхээр цар хүрээний хувьд маш том хууль л даа. Монгол Улсын Үндсэн хуулийн дараа бараг орохоор ийм хууль байгаа юм.

Тэгэхээр өнөөдрийн энэ танхимд энэ хуулийг хэлэлцэх эсэх асуудал дээр Отгонбаяр гишүүний санаачилсан энэ хуулийн төслийг гишүүд маань мэдэхгүй ингээд их цөөхөн ач холбогдол өгөхгүй байгаа юм шиг ингэж хэлэлцэж эхэлж байгаад маш их харамсаж байна. Хуулийн төслийг боловсруулах болсон хууль зүйн үндэслэлийг байнга хууль санаачлагч нар дурддаг.

Тэгэхээр энэ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дээр энэ сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 3-ны 1 хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно гээд ингээд бүүр заагаад өгчихсөн байгаа юм. Тэгэхээр энэ зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх энэ зарчмыг зөрчиж байна аа гээд хууль санаачлагч үндэслээд тайлбарлачихсан байгаа юм.

Хэрэв та энэ үндэслэлийг үнэхээр энэ хууль зүйн үндэслэлд энэ Үндсэн хуулийг зөрчиж байна аа гээд энэ 3-ны 1 хувь хүртэлх хувийг үзэж байгаа юм бол та яг энэ заалтаа бариад ер нь ҮХЦ-д хандаж болох байсан биш үү? Энэ дээр нэг асуултад та нэг хариулаад, 2 дээр энэ хуулийн төслийг боловсруулах зайлшгүй ийм шаардлага байгаа юм байна.

Тэгэхээр энэ аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөөр ажиллах ийм хүсэл сонирхолтой иргэдийн тоо сүүлийн үед маш их буурсан. Боловсон хүчний дутагдалд орсон гээд та тайлбарласан байна л даа.

Тэгэхээр энэ сумыг орхиод энэ 50 мянгаас 100 хүнтэй аймгууд 100 мянгаас 300, 400 мянган хүн амтай энэ нийслэл хотын дүүргүүд тэгээд 1 сая хүн амтай нийслэл Улаанбаатар хотын ИТХ-ын төлөөлөгчөөр ажиллах ийм хүнгүй болчихсон гэж үзвэл хэр их итгэл үнэмшилтэй байх юм? Ямар тооцоо судалгаа үндэслэж ийм практик шаардлага байна аа гээд үзсэн юм оо. Эсвэл өнөөдөр аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа энэ төрийн жинхэнэ албан хаагч болох төрийн захиргааны албан хаагчдыг иргэдийн төлөөлөгчдийн хурал руу, хурлын төлөөлөгч болгох гэсэн ийм улс төрийн албан тушаалтан болгох тийм бодлого яваад байгаа юм болов уу? Энэ дээр та нэг хариулт өгөөч?

Н.Учрал: Алдаржавхлан гишүүн хариулна.

Ж.Алдаржавхлан: Батчимэг гишүүн чухал асуудал хөндөж байна. Сая Их Хурлын дарга ч үгэндээ түрүүн хэлсэн. Одоо бол сум дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгч болох юм бол 1 дүгээрт ажил хийж болохгүй.

Хоёрт цалин байхгүй, 3-т урамшуулал байхгүй. Тэгээд бүх талаар ингээд ажил хийх бололцоогүй болчихож байгаа юм. Хэрвээ энэ байдал цаашдаа үргэлжлэх юм бол зөвхөн мөнгөтэй хүн л сум, дүүргийн иргэдийн Хуралд гарч суух, жирийн төрийн албан хаагч, жирийн багш, эмч, салбараа төлөөлж тэр хуралд суух ямар ч бололцоогүй болох юм байна лээ. Ажил хийж болохгүй, цалин байхгүй, урамшуулал байхгүй. Бүх юмыг хорьчихож байгаа байхгүй юу.

Тийм учраас бид нар суманд ялангуяа сум, дүүрэгт энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд тодорхой хэмжээний улсууд нь төрийн алба хаших нь зүйтэй байна аа л гэж үзсэн юм. Энэ амьдралаас гарч ирсэн ялангуяа сум орон нутагт үнэхээрийн хүнд байгаа гэж та хэд мэдэж байгаа. Тэгэхгүй бол дэвших хүн олдохоо байсан, гуйж дэвшүүлдэг болсон байна лээ улс төрийн намууд. Ер нь орон нутагт тийм байдал үүссэнийг бүгдээрээ сайн мэдэж байгаа учраас ядаж хуучин байснаар нь энэ тодорхой хувийг нь төрийн алба хашуулах нь зүйтэй гэж үз үзэж байгаа.

Ер нь зүгээр цаашдаа энэ түрүүн Сайнзориг гишүүн хэлсэн. Сум дүүргийн иргэдийн Хурлыг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Хурлыг нэгтгэж сум аймгийн иргэдийн Хурлын доороос нь сонгодог болгохгүй бол тэр доошоо сум руу хүн очиж өрсөлдөхөө больчихоод байгаа юм. Дээр нь их хуралтай учраас. Энэ Үндсэн хуулийн ямар ч заалттай харшлахгүй болохоор юм байна лээ. Энийг бид бид нар санаачилгаар ярилцаж байгаа.

Н.Учрал: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би асуулт биш дэмжиж үг хэлж байгаа юм аа. Яах вэ энэ хууль бол бас нийгмийн гэх юм уу орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас ийм захиалгатай хууль байгаа. Ардын нам, Ардчилсан нам аль ч байсан бүх шатын ИТХ-ын төлөөлөгч нарын 8031 хүн байна. Бүх шатны ИТХ-д улсын хэмжээнд энэний 6922 нь суманд байна. Сумын иргэдийн хурал 330 суманд. Ингээд нийслэлд 45, аймагт 751, дүүрэгт 313 төлөөлөгч нар байна.

Тэгэхээр одоо мөрдөгдөж байгаа нэгжийн хуулиар 6922 буюу сумын иргэдийн Хурлын Төлөөлөгч нарыг нэгжийн хуулиар төрийн захиргааны албан тушаалтан нь

30 хувь нь хийж болно гэсэн ийм зөвшөөрсөн хуулийн заалттай. Харин цаана нь үлдэж байгаа 3 шатын буюу аймаг, нийслэл, дүүрэгт 1109 хүн байгаа юм. Энэ 1109 хүнийг хориглочихсон ийм нэгжийн хуулийн зүйл заалт хэрэгжиж байгаа. Энэ 1109 хүний тодорхой 30-аас 50 хувийг нь төрийн захиргааны албан хаагч байж болно гэсэн ийм хуулийн заалт л байгаа юм. Энэ бас цоо шинэ хууль биш. Өмнө нь байсан гэдгийг та бүхэн мэднэ. Ингээд хориглосон заалтаар сүүлийн 3 удаагийн сонгууль явагдсан. Ингээд 3 удаагийн 12 жил яваад ирэхээр бас энэ хуулийн гажиг харагдаж байгаа юм аа. Орон нутагт бас хүний нөөцийн хомсдол гэдэг юм уу орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавх хэрхэн яаж байна вэ, яаж суларсан байна вэ? Сонгуульд нэр дэвшигч нар нь ямаршуухан бүрэлдэхүүнээс бүрдэж байна вэ гэдэг олон асуудлуудыг хөндөж байгаа учраас энэ 12 жилийн дараа орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын төлөөлөгч нар орон нутгаас энэ асуудлуудыг маш их хүчтэй тавьж байгаа. Энэ хуульд өөрчлөлт оруулж өг. Сумын зөвшөөрчхөөд аймаг, нийслэл, дүүргийг нь хориглочихсон байгаад байх юм аа.

Тийм учраас энэ ингэснээрээ өөрөө энэ 1109 хүний төрийн захиргааны албан тушаалд байх бололцоог нь нээж өгснөөрөө энэ өөрөө Үндсэн хуулиар олгогдсон хүний улс төрийн эрх буюу сонгох сонгогдох эрхийг хангаж өгч байгаа ийм хууль гэж ингэж ойлгож болно.

Тийм учраас энэ хуулийг бас цаашдаа зүгээр өнөөдөр Отгонбаяр нарын гишүүдийн өргөн барьсан хууль бол 50 хувь гэж байгаа юм. 50 хувийг би бол зүгээр ажлын хэсэг хэлэлцүүлгийн шатанд хувь юмыг нь ярьж бууруулж болох 20-30 хувийн хооронд байхад болохгүй юм байхгүй ээ гэж үзэж байгаа юм.

Нөгөө талаар Отгонбаяр нарын гишүүдийн хуулийн зөвхөн төрийн захиргааны алба хааж болно гэдгийг нээж өгч байгаа. Тэгвэл төрийн үйлчилгээ нь бас үлдчих гээд байгаа юм. Өнөөдөр төрийн үйлчилгээний удирдах албан тушаал бас орон нутгийн сонгуульд нэр дэвшиж болохгүй болчихоод байгаа юм. Тэгсэн хэрнээ доод албан тушаалтнууд нь болохоор багш, эмч нар нь нэр дэвшиж болоод байгаа.

Тийм учраас тэр хүн байгууллагын удирдлага гэдэг юм уу төсвийн ерөнхийлөн захирагч байснаараа сонгогдох эрхээ хязгаарлуулаад байгаа. Тийм учраас би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр энэ хуульд бас төрийн үйлчилгээний удирдах албан тушаал хийж байгаа улсуудад нээгээд өгчих ийм бололцоо боломж хэлэлцүүлгийн шатад гарна шүү гэдгийг бас хэлье.

Нөгөө талаар гишүүдээс бас гарч байгаа саналууд дээр хяналт тэнцлийн асуудал яригдаад байгаа юм аа. Засаг даргадаа хяналт тавих ёстой гээд. Нэг талаар зөв боловч нөгөө талаар төрийн ОНӨҮГ-ын байгууллагын даргын ажлыг хийх бололцоо боломж төлөөлөгч нарт байгаа. Нөгөө талаар төрийн захиргааны байгууллагад арай дөнгүүрүүд нь ажил хийж байгаа. Тэнд орон нутгийн сумын бодлого тодорхойлж байгаа. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулж байгаа. Энэ нөхдүүд маань орон нутгийнхаа өөрөө удирдах ёсны байгууллагад.

Н.Учрал: Сандагаа гишүүн нэг минут.

Ц.Сандаг-Очир: Тийм учраас энэ нөхдүүд маань тэртээ тэргүй хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулж, сумынхаа аймгийнхаа дүүргийнхээ бодлогыг боловсруулж ингэж байгаа улсууд маань өөрөө удирдах ёсныхоо байгууллагын үйл

ажиллагаанд бодлого тодорхойлох хэмжээнд ороод ажиллаад явахад бас болохгүй юм байхгүй. Хууль батлагдсанаар шууд нэг баахан төлөөлөгч нар ТЗ болохгүй. ТЗ болно гэж байгаа бол одоогийн Төрийн албаны хуулиар мөрдөгдөж байгаа бүх тэр төрийн албаныхаа сонгон шалгаруулалтад ороод төрийн албаны ерөнхий шалгалт, тусгай шалгалтдаа ороод шаардлага хангасан улсуудад тэр ТЗ хангах нөхцөл бололцоо нь бүрдэнэ. Тэрнээс шаардлага хангаагүй улсуудыг шууд төлөөлөгч гэдгээр нь шууд төрийн захиргааны албанд гэдэг юм уу төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалд томилох тэр бололцоо болно. Тэр худлаа.

Тэгэхгүйгээр шууд тэр төрийн албаныхаа хуулийн хэрэгжилтийг хангаж явах ёстой шүү гэдгийг давхар хэлье ээ.

Н.Учрал: Мандхай гишүүн.

М.Мандхай: Миний хувьд бол Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа шаардлага өөрчлөлт оруулах болсон шаардлагын энэ зорилтыг ойлгож хүлээж авч байгаа. Гэхдээ бас мэдээж энэ хууль дээр бас анхаарах асуудлууд байгаа гэж харж байна. Тэр нь юу вэ гэхээр Иргэдийн төлөөлөгчийн хурал өөрөө иргэдийн төлөөллийн байгууллага.

Гэтэл энэ төрийн захиргааны албан хаагчдын хувийг 50 хувь болгож нэмснээр энэ өөрөө иргэдийн төлөөлөгчийн хурал нь гүйцэтгэх засаглалын буюу Засаг даргын тамгын газар энэ төлөөлөл давамгайлсан байгууллага болох ийм эрсдэлтэй гэж харагдаж байна. Тэгэхээр энэ өөрөө энэ хуулийн үндсэн зорилтыг өөрөө алдагдуулж байгаа юм биш үү? Шийдвэр гаргалтын энэ чанарыг сайжруулах ёстой, түрүүн Сандаг-Очир гишүүн хэлж байна. Ер нь энэ чинь бас нэг хяналттай байх ёстой. Энэ процесс өөрөө алдагдах ийм эрсдэл байгаа юм биш үү гэж харах гээд байгаа юм. Жишээлбэл төрийн албан хаагчдын хувийг 50 хувь болгохоос өөр ийм ардчилсан ч гэдэг юм уу, илүү хяналттай хувилбарыг яагаад бас хэлэлцэж болоогүй юм бэ? Энэ одоо жишээлбэл та бүхэн энэ өөрчлөлтийг төрийн албан хаагчдын туршлага мэргэжлийн мэдлэгийг ашиглах зорилготой гэж нэг тайлбар дээрээ оруулсан байгаа. Гэхдээ эдний ажлын байрны онцлогоос хамаараад ажил дээрээ жишээлбэл, даргатайгаа, Засаг даргатайгаа, иргэдийн хуралд даргатайгаа ч гэдэг юм уу зөрчилдөхөөс айгаад зөвхөн даргадаа таалагдах ийм шийдвэрийг гаргахгүй байх баталгаа байгаа юу гэдгийг тодруулж асууя гэж бодож байна.

Нөгөө талаар иргэний оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ? Ингээд төрийн албан хаагчдын 50 хувьд орох боломжийг нь нээгээд өгөхөөр нөгөө иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, жирийн иргэдийн ийм төлөөлөл сонгогдох боломжийг нь илүү энэ зохицуулалтаараа хумьж өгч байгаа юм биш үү гэдэг асуултыг асууя. Тэгээд тодруулга авъя.

Н.Учрал: Отгонбаяр гишүүн хариулна.

У.Отгонбаяр: Мандхай гишүүний асуултад хариулъя аа.

ТББ, иргэний нийгмийн төлөөллийн сонгох сонгогдох эрхийг энүүгээр хөндөөгүй ээ. Тэд маань сонгох сонгогдох эрх нь нээлттэй байгаа гэж асуултад хариулъя.

Дараагийн асуулт манай гишүүдийн зарим гишүүдээс гарч байгаа хяналтын механизм алдагдах энэ хяналтгүй болох асуудал хөндөгдөж ярьж байгаа. Энийг бид бүхэн бодоогүй биш бодож үзсэн. Жишээ нь аймгийн иргэдийн хурал 30-аас 35 эс үгүй бол 40 төлөөлөгчтэй иргэдийн Хурлын 50 хувь буюу 20 шууд Тамгын газарт ажиллах гэж байгаа зүйл огтоосоо биш. Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны удирдах албан тушаалтныг төлөөлөгч ажилд орох гэж байна аа. Та наад албанаасаа чөлөөлөгдөөд орондоо энэ аймгийн дүүргийн иргэдийн Хурлын төлөөлөгчийг ажиллана аа гэдэг тийм шаардлага тавигдахгүй ээ. Тухайн ажлын байран дээр орон гараад Төрийн албаны тухай хуульд ямар зохицуулалттай вэ, яг тэрүүгээр явах юм. Ерөнхий шалгалтаа өгнө, тусгай шалгалтаа өгнө. Тухайн ажлын байран дээр тавигдаж байгаа шаардлага нь хангагдаад тухайн ажлын байр нээлттэй зарлагдсан нөхцөлд тухайн орон нутгийн төлөөлөгч тухайн ажлын байран дээр өрсөлдөх энэ боломжийг л ний нуугүй хэлэхэд нээж байгаа юм.

Тэрнээс биш заавал ч үгүй 3-ны 1 нь 50 хувь нь төрийн захиргааны алба хаших ёстой гэдэг зүйл огтоосоо биш шүү гэдгийг дуулгамаар байна аа. Тэгээд та бүгдийн хэлж байгаа ярьж байгаа саналуудыг ажлын хэсэг дээр ярьж хэлэлцэж цаашдаа боломжтой саналуудыг нь энэ хуульд хуулийн өөрчлөлтөд тусгаад явна аа гэдгийг албан ёсоор хэлье ээ. Баярлалаа та бүгдэд.

Н.Учрал: Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууна.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бол Монгол Улсын үндсэн хуулийн дараа орох төр, засаг захиргаа, нутгийн удирдах байгууллага яаж ажиллах вэ гэдгийг шийдсэн хамгийн том хууль аа гэж бодож байна. Монгол Улсад бол маш олон хууль, хуулийн нэмэлт өөрчлөлтийг Улсын Их Хурал хийж байна аа. Энэ чухал хуулийг Улсын Их Хурал энэ парламент Отгонбаяр гишүүн ээ анхаараад нэг удаа хийвэл яасан юм бэ? Гишүүд Үндсэн хуультай адилхан үйлчлэлтэй ийм хуулийг хэсэг бүлгээрээ хэсэг заалтыг өөрчлөлт оруулж ирэх нь зарчмын хувьд буруу гэж би бодож байна. АН-ын бүлэг өөр Улсын Их Хурлын гишүүд төлөөлөгчөөр ажиллаж байсан хүмүүс нэгжийн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр санаанууд байгаа.

Тийм учраас Отгонбаяр гишүүн үнэхээр энэ хуулиа явуулъя аа гэж бодож байгаа бол энэ удаа татаж аваад томоохон шиг ажлын хэсэгтэйгээр энэ дүүргийн иргэдийн хурал, Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн саналыг аваад ингэж явах хэрэгтэй гэж бодож байна.

Хэрвээ энэ хуулийг ингэж явуулах юм би дэмжихгүй ээ. Төрийн албан хаагч мерит зарчмаараа төрийн албанд ажиллах тэр орон зайг төлөөлөгч нар эзэлнэ. Намын нэрээр орж ирсэн хүмүүс төлөөлөгч очиж ажиллаад төрийн албанд ажиллах тэр 50 хувийн орон зай ажиллах боломжийг нь булааж авах гэж байна шүү дээ. Харин үүний оронд орон нутагтаа төрийн албан хаагчийг ажиллуулах цалингийн бодлого, төрийн албаны реформ, төрд шинээр авьяастнууд орох энэ боломжийг нь нээе л дээ. Энийг Төрийн албаныхаа хуультай нийцүүлж зэрэгцүүлж хэлэлцүүлье л дээ.

Өнөөдөр юу болох гэж байна вэ гэхээр суманд шууд улс төржилт бий болох гэж байна. Хамгийн их улс төржилт байдаг газар бол сум. Одоо цаашдаа бол сумын

олонх болсон нам, сумын эмнэлгийг, сумын сургуулийг, эмнэлэгт хэвтэж байгаа хүмүүсээ улаан цэнхрээр нь ялгадаг ийм сонин тогтолцоо руу явах гэж байна шүү дээ. Мэргэшсэн төрийн алба гэдэг энэ Үндсэн хуулийнхаа үзэл санаанаас ухрах гэж байна шүү дээ. Төлөөлөгч бол 2 дугаарт хяналтаа тавьдаг. Сандаг-Очир гишүүн хэлээд байна. Цалингүй болсон тухай ярьж байна. Нийслэлийн иргэдийн хурал тогтмол хуралддаг. Аймаг, сум, бусад хурлууд тогтмол хуралдаад байх шаардлага байдаггүй. Хамгийн чухал асуудал төсвийн асуудал, газар зохион байгуулалтын асуудлаараа хуралддаг.

Гуравдугаарт ямар философийн алдаа байна вэ гэхээр ажилтай болгохын тулд та нарыг дэвшүүлнэ ээ гэдэг юм явж байна шүү дээ. Улс төрийн намаар дамжсан төлөөлөгч нарыг төрийн албанд ажлын байртай болгохын тулд та нар нэр дэвшээч ээ гэдэг ийм сэдэлжүүлэлт өгнө өө гэсэн утгатай зүйл ярьж байна шүү дээ? Энэ өөрөө буруу юм аа. Харин энэ иргэдийн хурлынхныг дүүргийнх нь нийслэл рүүгээ, сумынх нь аймаг руугаа явдаг том хэмжээгээр нь харж нэгжийн хуульдаа нэгмөсөн сайжруулалт хийгээд явбал яасан юм бэ гэдэг ийм саналтай байна аа.

Тийм учраас энэ дээр хаана хаанаа хэдүүлээ нэг уужуу хандаад би энэ Сайнзориг гишүүний саналтай санал нэг байна. Энийгээ татаж аваад тэгээд Отгонбаяр гишүүн өөрөө ахал л даа. Тэгээд энд маш олон хүмүүс санал хэлнэ. Ингээд явбал яасан юм? Том хэлэлцүүлэг хийе л дээ. Монгол Улсын Үндсэн хуулийн дараа орохуйц хэмжээний том хууль шүү. Энэ хуулийг зүйл, заалтаар нь цэглэдэг ажлыг энэ Улсын Их Хурлын дарга цаашдаа цаашдаа анхаараарай гэж хэлье ээ. Баярлалаа.

Н.Учрал: ТББХ-ны дарга Сандаг-Очир гишүүн хариулна.

Ц.Сандаг-Очир: Баатархүү гишүүний хэлсэн санал дээр санал нийлж байгаа ч зүйл байна. Нийлэхгүй байгаа зүйл байна аа% Шууд суманд 50 хувийг бүрдүүлээд улс төржүүлэх энэ хуулиараа мөрдөгдөж байгаа хуулиараа сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн 3-ны 1 нь төрийн захиргааны албан тушаалтай байж болно гэсэн заалт хэрэгжиж байгаа шүү дээ Баатархүү дарга аа. Хэрэгжиж байгаа өнөөдрийг хүртэл. Харин дүүрэг нь, аймаг нь, нийслэл нь орхигдчихсон байгаа юм, хязгаарлагдчихсан байгаа юм.

Тийм учраас тэр 1100 031 хүнээс 1109 хүн нь хязгаарлагдсан байгаа энэ аймаг, нийслэл, дүүргийн төлөөлөгч нарын бололцоо боломжийг нь сонгогдох эрхийг нь нээх төрийн захиргааны байгууллагад ажиллах бололцоог нь нээх ийм л хууль байгаа юм. Тэгээд өнөөдөр мөрдөгдөж байгаа хуулиараа сумын Иргэдийн Хурлын төлөөлөгч нарын 3-ны 1 нь ТЗ байж болно гэсэн үндсэн хууль хэрэгжиж байгаа ч гэсэн өнөөдөр 330 суманд нэг их улс төржилт яваад л улс төрийг улс төржүүлээд л, иргэдийн хурал, хурлын дарга, Засаг дарга нарыг хяналт тэнцлийг нь алдагдуулаад байгаа юм ерөөсөө байхгүй байгаа шүү дээ.

Тийм учраас энэ хуулийг бас энэ талаас нь харвал ингэж мушгиж ингэж байж болохгүй ээ. Зүгээр О.Амгаланбаатар нарын гишүүдийн нэгжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль өргөн баригдсан байна лээ. Гэхдээ одоогоор хэлэлцэх эсэх нь хийгдээгүй байна. Энэ хуулийн заалтад бас яг энэ агуулгаар энэ заалт яваа.

Тийм учраас би бол энэ АН, Ардын намын гишүүд аль аль нь дэмжиж байгаа юм байна аа. Тэгээд Отгонбаяр нарын гишүүд бол аль 6 сард өргөн барьсан хууль. Тэгээд өнөөдрийг хүртэл хэлэлцүүлэхгүй хойшлуулж явсаар байгаад ингээд энэ намрын чуулгандаа багтаагаад энэ хуулиа хэлэлцүүлчихье ээ гээд өөрөө асуудлаа өргөн барьсан хуулийн хүрээндээ ингээд хэлэлцүүлж байгаа учраас энэ хуулийг нь хэлэлцүүлээд явж байна. Амгаланбаатар нарын гишүүдийн өргөн барьсан хууль сая 11 сарын сүүлчээр өргөн баригдсан байгаа. Тэгэхдээ тэр хуульд маш олон заалтуудыг хөндсөн байна лээ. Зөрчилтэй ч зүйл заалтууд байна. Дэмжээд явах асуудлууд ч байгааг үгүйсгэхгүй ээ гэдгийг хэлье.

Тийм учраас ер нь хүний сонгох сонгогдох эрхийг нээх, аливаа иргэн аль ч шатны сонгуульд нэр дэвших эрхтэй. Аль ч одоо байгууллагад ажиллах эрхтэй. Тэгээд төлөөлөгчөөр сонгогдсон хүн болгоныг төрийн захиргааны байгууллагад ажиллана гэдэг ингэж бас мушгиж гуйвуулж болохгүй. Тэр дотор чинь төрийн байгууллагад ажиллаагүй, төрийн захиргааны байгууллагад ажиллаагүй хүн бол төрийн захиргааны албан тушаал хаших эрхгүй шүү дээ хуулиараа, нэг талаар.

Ингээд л хориотой болчихно. Ажилласан жил нь хүрэхгүй бол бас хориотой. Ерөнхий шалгалт өгөөгүй бол бас хориотой. Тусгай шалгалт өгөөгүй бол бас хориотой. Тийм учраас нөгөөдөх төрийн албаныхаа хуулиар энэ бүх шалгуур шаардлагаа хангасан улсууд нь төрийн захиргааны байгууллагад ажиллах эрх нь үүснэ гээд хязгаарлачхаж байгаа юм.

Тэгэхээр хүн болгоныг, төлөөлөгч болгоныг 50 хувьд хуульд орж ирснээр нь 50 хувиар нь мерит зарчмаар яваад төрийн албан хаагчдын ажлыг булаах гэж байна гэж ингэж ойлгож ерөөсөө болохгүй ээ. Тийм учраас тэр шалгуур шаардлагаа хангаж байгаа улсууд нь.

Н.Учрал: Цэндийн Баатархүү гишүүн тодруулна.

Ц.Баатархүү: Тэгээд энэ хууль дээр Их Хурлын гишүүд ухамсартай тал талаас нь хараасай л гэж би бодоод байгаа юм. Энэ парламент энэ хууль дээр нэгмөсөн сайн хэлэлцүүлэг хийж судалгаа шинжилгээтэй л хандъя л даа. Бусад улсад бол төлөөлөгч төрийн албанд орох эрх нь нээлттэй байдаг. Гэхдээ төлөөлөгчийнхөө мандатыг өгдөг. Иргэдээс сонгогдсон мандатаа өгөөд төрийн албанд ордог. Одоо бол ямар мессеж явах гэж байна вэ гэвэл Монгол Улсын бүх сумд байгаа төрийн албан хаагчдын 50 хувийг төлөөлөгч нар чинь дээрэмдэж орж ирэх гэж байна шүү. Та нарын ажлын байрыг булаах гэж байна шүү гэдэг ийм мессеж ийм агуулга явах эрсдэлтэй.

Тийм учраас энэ төлөөлөгч гэдэг бол төсвийн хяналтыг тавьдаг, төсвөө баталдаг, Засаг даргадаа хяналт тавьдаг. Гэтэл Засаг даргынхаа удирдлагад ажиллах юм бол наад орон нутгийн төсөв чинь ямар ч хяналтгүй болно оо. Ийм учраас энэ дээрээ уужуу хандаасай гэдэг саналыг хэлье ээ. Баярлалаа.

Н.Учрал: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Баатархүү гишүүнд хандаж хэлэхэд энэ хуулийн өөрчлөлтийг 8 гишүүн санаачилж өргөн барьж байгаа. Энэнд аль аль намын төлөөллүүд буюу жишээ нь Ардын Намын бүлгийн 4 дэд дарга, АН-ын бүлгийн 3 дэд даргын 2 нь энд нэр нь хэдий байгаа боловч Тэмүүжин гишүүн гарын үсэг тухайн үед зурж чадаагүй.

Лодойсамбуу гишүүн, Жаргалан гишүүн нар энэ дээр дэмжиж хамт энэ хуулийн өөрчлөлтийг хийж байгаа. Тийм учраас би энэ АН-ын бүлгийг энийг дэмжиж байгаа гэж ойлгож байгаа. Яагаад гэвэл өнгөрсөн хавар даргын зөвлөлийн хурал дээр аль аль намууд, ХҮН нам, АН, Ардын нам, Үндэсний эвсэл, Ногоон нам гээд бүгд энэн дээр санал нэгдэж энэ хуулийн өөрчлөлтийг хийе ээ гэдэг дээр санал нэгдэж энэ хуулийн өөрчлөлт эхэлсэн юм аа гэдгийг.

Н.Учрал: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бол зайлшгүй шинэчлэх ёстой ийм хууль. Энэ хуулийг шинэчилж нэмэлт, өөрчлөлт оруулъя гэдэг дээр санал нэг байгаа. Тэгэхдээ Отгонбаяр гишүүн нарын энэ өргөн барьж байгаа энэ хуулийн хэлэлцүүлгүүд ямар хэмжээнд явсан аль аль талууд нь одоо яг адилхан байр суурьтай байна уу үгүй юу гэдэгт жоохон эргэлзээтэй байна. Амгаланбаатар гишүүн тэргүүтэй хэдэн хүмүүс дахиад хууль өргөн барьчихсан байгаа.

Манай Сандаг-Очир гишүүн ч гэсэн тэрэн дотор хамт өргөн барилцсан. Манай АН дээр мөн энэ хуулийг одоо нэмэлт, өөрчлөлт хийх энэ хуулийг сайжруулах тухай бас ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тэгэхээр энэ болгоноо бүгдийг нь хэдүүлээ нэгтгээд саяын Баатархүү гишүүний хэлээд байгаатай адилхан сайн хэлэлцүүлгүүд зохион байгуулаад аль аль талдаа бүх асуудлуудаа шингээж чадах юм бол энэ хууль өөрөө сайн хууль болно.

Тэгэхээрээ зэрэг энэ хуулиа Отгонбаяр нарын гишүүдийг буцаагаад татчихвал яадаг юм бэ. Хэдүүлээ хэлэлцүүлгүүдээ нэгтгэе ээ. Хамтраад дахиад сууцгааяаа гэдэг ийм саналыг хэлэх гээд байгаа юм. Олон юман дээр бид нар санал нэг байгаа. Жишээ нь одоо энэ аймгийн Засаг дарга, аймгийн одоо дунд шатын засаг захиргааны нэгжүүд өөрснөө хэвтээ тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага байгаа. Үүнд бол Засгийн газрын гишүүд дуртай байхгүй байх мэдээж.

Одоо бол ерөөсөө аймаг дээр юу болоод байна гэхээр зэрэг баахан босоо тогтолцоотой агентлагийн дарга нартай болчихсон. Түүнийг нь Засаг дарга нь хариуцлага тооцож чаддаггүй болохоор зэрэг мөрийн хөтөлбөр нь ч явдаггүй, үр дүнгийн биелэлт нь ч тааруухан гардаг. Нэг ийм л байдалтай болчихоод байгаа юм.

Дээрээс нь одоо яг үнэндээ суманд бол мэдлэгтэй чадвартай хүн гэхээсээ илүүтэй ах дүү олонтой хүнийг дэвшүүлдэг л болсон шүү дээ одоо сүүлийн үед. Намууд тэрнийхээ хойноос хөөцөлддөг. Хэн нь олон ах дүүтэй вэ гэдгийг судалдаг л болсон шүү дээ манай анхан шатны намууд. Тэгэхээрээ энүүгээр бол 50 хувь нь юу вэ зүгээр тэгэхдээ бол тэр 30 хувьд нь байлгах энэ төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний албан тушаалуудыг давхар хашиж болох энэ механизмыг эд нар оруулах бол зөв гэж бодоод байгаа юм.

Тэгээд тэр хэвтээ тогтолцоотой болгох гэдэг бол маш чухал асуудал. Засаг дарга, сум аймгийн Засаг дарга нар нь өөрснөө боловсон хүчнээ томилоод тэгээд өөрсдөө хариуцлагаа хүлээдэг, өөрсдөө бас бодож санаж байгаа ажил хэргээ ажил хэрэг болгодог нэг ийм байх бол өнөөдрийн бид нарын энэ анхан, дунд шатад зайлшгүй хийх ёстой ийм тулгамдсан асуудал болоод байгаа нь мөн.

Тэгэхээр юу хэлэх гээд байгаа юм гэхээр зэрэг хэдүүлээ энэ дээрээ аль аль талуудаас, намуудаасаа оруулъя. Саяын Жаргалан гишүүн, манай Лодойсамбуу гишүүн эд нар таны наад өргөн барьж байгаа хуулийн хэсэгт орсон юм байна. Манай бүлэг дээр байгуулагдсан ажлын хэсэг дээр энэ тухай асуудлууд ерөөсөө хөндөгдөөгүй яригдаагүй байгаа. Тэгэхээр зэрэг энэ болгоныгоо хэдүүлээ нэгтгэж авч байгаад бүх санаануудаа тусгаад хэлэлцүүлгүүдээ сайн зохион байгуулаад ингэж л чадвал хэдүүлээ сайн хууль гаргаж чадна аа л гэж ингэж хэлэх гээд байна.

Н.Учрал: Санал хэллээ. Банзрагчийн Түвшин гишүүн байхгүй байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс нэрс ирүүлсэн. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Индэрт хэлэх юм байна. Сайнзориг гишүүн индэрт. Дараа нь Жаргалсайхан гишүүн 2 дугаар индэрт үг хэлнэ.

Нэгдүгээр индэрт Сайнзориг гишүүн үг хэлнэ ээ.

П.Сайнзориг: Уг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгааг энэ индэр дээрээс хэлж байна. Бас дэмжих хэд хэдэн шалтгаан байна аа. Бид хэд цаашдаа энэ орон нутгийн түвшинд энэ улс төржилтийг багасгах гэдэг нэг өнцөг яригддаг бол нөгөө талдаа бас орон нутгийн түвшинд яаж боловсон хүчнийг байршуулж бүтээмжтэй байх вэ? Орон нутгийн түвшинд асуудлаа хэрхэн яаж шийддэг байх вэ гэдэг зүйлийг бас зайлшгүй ярих ёстой. Тэрнээс биш яг улс төржилтөөс ангид байх ёстой ч гэдэг юм уу ийм зүйлүүдээр хавтгайд нь хаахаар сум дүүргийн түвшинд яг чадалтай ур чадвартай ийм залуучууд дэвшихгүй байна аа. Энэ ажил албаа өгчхөөд энэ орон нутгийн сонгуульд орж сум орон нутгийнхаа ч гэдэг юм уу дүүргийнхээ түвшинд хүчин зүтгэхэд эрсдэл үүсэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр уг асуудлыг нь бид нар бас нэг тэнцвэртэйгээр хэлэлцэж дараа дараагийн шийдлийг гаргах ёстой гэдэг үүднээс уг хуулийн төслийг хэлэлцье. Гишүүдийн гаргаж байгаа саналуудыг бас тал талаас нь ярилцах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ асуудлаас дэвшүүлж байгаа нэг асуудлыг би юу гэж харж байгаа вэ гэхээр Орон нутгийн сонгуулийн тухай хууль тогтоомжийг сайжруулах ёстой юм байна аа. Тогтолцооны хувьд нь ярих ёстой юм байна аа. Тухайлбал, сум, дүүргийн түвшинд сонгуулиа явуулаад суманд эзэлсэн эсвэл дүүрэгт авсан суудлынх нь тоогоор нийслэл рүүгээ болон аймаг руугаа төлөөлөгчөө илгээх байдлаар энэ орон нутгийн сонгуулийг хэмнэлттэй. Тэгээд дээрээс нь боловсон хүчний энэ олдохгүй байгаа нөхцөл байдлыг шийдсэн. Тэгээд яг сум аймаг нь ч байдаг юм уу, эсвэл дүүрэг, нийслэл нь бодлогын уялдаатай ажиллах яг тэр дүүргээсээ сонгосон төлөөлөгч нь нийслэл дээрээ төлөөлж очиж байгаагийн хувьд бас яг шийдвэрээ гаргуулдаг, дүүргийнхээ асуудлыг ярьдаг энэтэйгээ холбоотой холбогдох шийдвэрийг нь гаргуулдаг энэ нөхцөл байдлыг дэмжсэн энэ сонгуулийн реформыг хийх ёстой гэж үзэж байна.

Дараагийн нэг асуудал ерөнхийдөө энэ төрийн албанд зайлшгүй шинэчлэх шаардлагууд байна аа. Төрийн албаны ангиллаасаа эхлээд бодох хэрэгтэй байна.

Бид хэд энэ төрийн захиргаа гэж үзээд байгаа боловч яг орон нутгийн захиргаанд ажиллаж байгаа хүмүүс дээр бас тавигдах шаардлага өөр өөр баймаар байна. Тэгэхгүй ингээд яам агентлагт ажиллаж байгаа хүмүүс дээр тавьдаг шаардлагыг тавьчхаад орон нутагт хүн олдохгүй байна гэдэг зүйлүүд явахаар их төвөгтэй хүндрэлтэй байгаа шүү гэдэг зүйлийг хэлье. Тэгээд бүх зүйлүүдийг төрийн захиргаа юм уу орон нутгийн захиргаа болох гээд байх биш аль болохоор тусгай шаардлага нь оновчтой бөгөөд ил тод байх ур чадварыг яг суурилсан тэр зарчим руу ангилал руу энэ төрийн албаны реформыг хийх ёстой гэж үзэж байгаа.

Тэгээд ер нь бол харин эсрэгээрээ яам агентлагт ажиллах гэж байгаа хүмүүс бол заавал орон нутгийн түвшинд ажилласан байх тодорхой хугацаанд тодорхой түвшинд ийм шаардлагыг харин төрийн албаны тухай хуульд хийж өгөх зайлшгүй шаардлагууд байгаа юм аа. Тэгээд уг хуулийн төслийг хэлэлцье. Зөвхөн юу гэдэг юм сонгогдсон этгээд төрийн захиргааны албан тушаалд ажиллах тэр асуудал дээр квотыг нь нээж өгөх гэж байгаа болохоос биш шууд хавтгайд нь томилох гэж байгаа эд биш байна.

Хоёрдугаарт энэ орон нутгийн сонгууль болохоос өмнө харин тодорхой түвшинд төрийн үйлчилгээ болон төрийн захиргаад ажиллаж байгаа хүмүүс орон нутгийнхаа түвшинд иргэдээ төлөөлөх тэр бололцоог нь олгоё оо. Тэгээд олон гишүүд яг л бодит үнэнийг хэлж байна. Ах дүү олонтой нь л сумын түвшинд явж байна. Дүүргийн түвшинд ч гэсэн яг үнэндээ хэлэхэд дэвших залуучууд л их хомсдоо. Тэгэхээр энэ асуудлуудаа бид хэд зөв шийдэж байж төрийн хууль тогтоомж орон нутгийн түвшинд анхан шатын түвшинд хэрэгждэг байх. Эргээд орон нутаг бас асуудлаа тэр яам агентлагийн түвшинд биш тэр доороо шийддэг тэр хүний нөөцийн ур чадвар мэдлэг тэнд очих тэр бололцоог нээх байдлаар хэдүүлээ явъя аа. Тэгээд юм болгоныг бас яг нэг уутанд хийж зүтгүүлэх биш онцлог онцлогт нь тааруулж шийдэх ийм сорилт бол.

Н.Учрал: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн 1 дүгээр индэрт урья.

Д.Жаргалсайхан: Энэ хуулийг бол дэмжихгүй байгаа. Яагаад вэ гэхээр бол Үндсэн хуулийн 16.10 дээр төрийн зарим төрлийн албан хаагчийг намын гишүүнээс түдгэлзүүлж болно гэчихсэн байгаа юм. Тийм ч учраас Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа, нэгжийн тухай хуулиудад өөрчлөлт орсон. Тэгээд ер нь орон нутгуудад сая гишүүд хэлж байна. Улс төржилтөөс төрийн албыг бас нэг ангид байлгая. Төрийн алба маань ард иргэддээ хэн нэгнийг ялгаварлан гадуурхахгүйгээр үйлчилдэг байя, тэгээд дээрээс нь төсвийн хөрөнгийг улс төр рүү оруулахгүй байя.

Төсвийн энэ унаа машиныг оруулахгүй байя. Сонгуулиар бас эрх мэдэлтэй энэ албан тушаалтнууд, ажилтнууд давуу эрх эдлэхийг хориглоё гэсэн ийм үндэслэл шаардлагуудаас болж энэ Төрийн албаны тухай хууль, нэгжийн тухай хуулиудад өөрчлөлт орсон юм. Гэсэн ч өнөөдөр бидний хувьд л нэг эргэж буцсан бүр уруудсан, доройтсон заалтыг ингээд яриад сууж байгаа нь харамсалтай байна.

Тийм учраас бидний хувьд энэ хуулийг эргүүлэн татаач ээ. Энэ хууль дээрээ эргэж харъя аа. Бидний хувьд бол тэр орон нутагт байгаа, дээрээс томилгоотой, тэгээд дээрээс нь юу гэдэг юм орон нутгийнхаа удирдлага, бодлого, үйл ажиллагааг дэмждэггүй, үүнтэй зөрчилддөг ийм томилгоонууд дээр хэдүүлээ харин орон нутагт нь эрхийг нь өгвөл яасан юм бэ гэсэн ийм саналыг бид нар бол санал болгож байна. Тэр ч үүднээсээ АН-ын нэр бүхий гишүүд хуулийн төсөлтэй холбоотой

өөрчлөлтүүдтэй холбоотой өөрчлөлт гаргаад явж байгаа. Тийм учраас хуулиа эргүүлэн татаад хуулийн санал санаачилгуудаа нэгтгэвэл яасан юм бэ гэсэн ийм саналыг бол Улсын Их Хурлын гишүүний зүгээс бол санал болгож байна аа.

Тийм учраас хуулийн төслийг дэмжихгүй байна аа. Санаачилсан гишүүдийг буцааж татахыг хүсэж байна. Баярлалаа.

Н.Учрал: Жаргалсайхан гишүүнд баярлалаа.

Мэндчилгээ танилцуулъя. Хэнтий аймгийн Өндөрхаан хотын ерөнхий боловсролын 1995 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Эрхэм хүндэт Хан Хэнтийчүүд 1995 оны төгсөгчид та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Гишүүд үг хэлж дууслаа. Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулах ёстой.

Санал хураалтыг дараагийн хууль тогтоолын төслүүдтэй хамтад нь санал хураая.

12.44 цаг

Дараагийн асуудал орно оо.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна. Индэрт урья.

П.Батчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүнээс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд байгуулсан гэрээ, хэлэлцээр, түүний бэлтгэл ажил, ААН хоорондын хамтын ажиллагааны гэрээ, баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор Хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаж Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаар нь Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын гишүүдээс санаачилж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын төслийн хүрээ хязгаараас ялгагдах өөрчлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Хянан шалгах түр хороо байгуулах шалтгаан үндэслэл болон коксжих, сул коксжих эрчим хүчний нүүрсний үнэ болон борлуулалтын хэмжээнд нь гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэж байгаа эсэхийг шалгах эсэх талаар асуулт асууж хариулт авсан.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Хянан шалгах түр хороо байгуулахгүйгээр Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар дугаар тогтоолын хүрээнд байгуулагдсан гэрээг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаараа авч хэлэлцээд шаардлагатай бол Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй талаар санал хэллээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг баримтлан тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд харшилсан эсэх талаар санал хураалт явуулах үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 64.7 хувь нь Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Асуулт асууж, үг хэлэх.

Пүрэвжавын Сайнзориг гишүүнээр, Даваагийн Цогтбаатар гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Засгийн газрын гишүүд танхимд танхимд ирж хариулах шаардлагатай бол хариулаарай. Мэдээж түр хороо санаачилсан Баярмаа нарын гишүүд асуултад хариулна.

Мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Сайнбуянгийн Амарсайхан нарын урилгаар Багахангай дүүргийн бизнес эрхлэгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа.

Багахангай дүүргийнхээ бизнес эрхлэгч та бүхэнд ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье ээ.

Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонслоо.

Тэгэхээр асуулт байгаа юм. Энэ ер нь түр хороо байгуулах асуудал уул уурхайтай холбоотой чиглэлээр нэлээн явагдаад байгаа. Энэ гэрээ бол Харбины гэж тодотголтой явсан гэрээ бол арай өвөрмөц юм аа. Энэ чинь 3-ыг цогцоор нь гэдэг ерөнхий зарчимтай. 3 асуудлыг нэг гэрээгээр зохицуулах чигтэй ийм гэрээ байгуулагдчихсан. Тэгэхээр зэрэг одоо бол энэ дээр төмөр зам хил холболтын төмөр замын асуудал байгаа тийм ээ. Энэ гэрээний аль нэг тал дээр нь уурхайн амнаас нүүрс экспортлох асуудлаар холбогдуулаад Түр хороо байгуулах гэж байгаа юм байна гэж ойлгосон.

Энийг бид нар хэлэлцээд явахад энэ маань хил холболтын төмөр замд ер нь яаж тэрний явцад яаж нөлөөлөх юм бол. Энэ дээр одоо үзэж судалсан ийм зүйл юу байна вэ гэж ингэж асуумаар байна. Яах вэ ер нь энэнийг тойроод зөндөө л юм яригдаж байгаа. Ялангуяа одоо тэр 20 жилийн 20 хүртэл сая жилд 20 хүртэл сая тонн нүүрсийг 16 жилийн хугацаатай экспортолно гээд үнийг нь ер нь нэг 50 орчим доллароор тонныг нь тогтоочихсон байж байгаа юм. Тэгээд энэ бол нэлээн маргаан дагуулсан үнэ бага байна гэж их яригддаг. Тэгээд энэ асуудал дээр ярьж болох боловч нөгөө үлдсэн 2 асуудалдаа эргээд ямар нөлөө үзүүлдэг бол гэсэн энэ асуултыг л санаачлагч нараас асуумаар байна.

Н.Учрал: Жудгийн Баярмаа гишүүн хариулна.

Ж.Баярмаа: Маш тодорхой асуулт асуусанд баярлалаа.

Нэгдүгээрт зөв. Ер нь бол яг юу руу илүү түлхүү чиглэх вэ гэвэл үнэ. Үнэ рүү илүү түлхүү чиглэнэ. Яагаад гэвэл ер нь анхнаасаа шүгэл үлээгдэхдээ энэ үнийг маш багаар тогтоосон байна аа гэдэг л ийм л юм яригдаж байгаа юм. 50-аас 60 долларын хооронд гээд. Тэгээд явцын дунд юу үүссэн бэ гэвэл энэ олон удаагийн гэрээ хэлэлцээний явцад биржийн үнээр худалдан борлуулах талыг буюу энэ саналыг маань айлын тал хүлээн зөвшөөрлөө гэсэн илтгэх хуудас гэх юм уу тухайн үеийн ЭТТ-н БЭТ Ганбатаас ЗГХЭГ руу явсан байдаг юм. Өөрөөр хэлбэл биржийн үнээр тухайн үед мэдээж биржийн үнэ хэд байх нь тусдаа асуудал. Тэр тухайн тэр үнэд нь тохируулж 5 хувийн хөнгөлөлттэйгөөр худалдаж болох ийм боломж байсаар атал яагаад ийм тогтмол буюу 50-аас 60 долларын хооронд тогтоочхов гэдэг асуудлыг л хянаж шалгах гээд байгаа.

Тэгэхдээ энэний хяналт шалгалтын үр дүн бол хил холболттой бол ямар ч хамаагүй. Төмөр замын хил холболт бол түүгээрээ тусдаа дахиад гэрээгээр явж байгаа гэж ойлгож байгаа. 3-ыг цогцоор гэдэг чинь нэг нь төмөр замын хил холболтын гэрээ, нэг нь нүүрс худалдан худалдан авах гэрээ, нөгөөдөх нь нөгөө хүчин чадлыг нэмэгдүүлэх гээд ийм 3 тусдаа гэрээнүүд байгаа. Тэгэхдээ нүүрстэй хамааруулж энэ хил холболт руу нөлөө үзүүлнэ гэж бодохгүй байгаа. Яагаад гэвэл миний ойлгож байгаагаар хил холболтын ажлыг мөн БНХАУ-ын компаниар хийлгэхээр тохирсон. Гэхдээ Монгол Улсын Засгийн газар буюу өөрөөр хэлбэл ЭТТ маань өөрөө мөнгөө төлөөд хийлгэж байгаа. Мөнгөө төлөөд хийлгэж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн бартер юм уу тийм зүйл байхгүй учраас энэ бол хоорондоо ямар нэгэн бие биетэйгээ уялдаж зогсох эсвэл явах тийм боломж нөхцөл харагдахгүй байгаа. Тусдаа учраас гэрээ нь 3 тусдаа. Магадгүй бартераар тэ

нүүрсээр энэ ажлыг хөлсийг нь төлнө өө гэсэн байсансан бол магадгүй хямдаар тогтоох шаардлагатай гэж үзэж болох юм тиймээ? Гэтэл мөнгийг нь төлөөд хил холболтоо хийлгэж байгаа юу? Хийлгэж байгаа. Тэгэхээр тэрэн дээр асуудал алга. Нөгөө талдаа нөгөө нүүрсний маань үнэ яагаад ийм хямдаар тогтоогдчихов гэдэг л асуудлыг хянан шалгаж байгаа.

Тэгээд ташрамд хэлэхэд яах вэ энэ уул уурхайтай холбоотой хяналт шалгалтууд их хийгдэж байна гэдэг яриа сүүлийн үед гарлаа. Та энийг хөндөх шиг боллоо. Одоо хийхээс өөр замгүй л болчихоод байна л даа харамсалтай нь. Одоо нэг дуртайдаа Хянан шалгах хороо байгуулаад л хийгээд байгаа гэж би бодохгүй байна. Нэн ялангуяа нүүрс бол өмнөх энэ оффтейк гэрээнүүд дандаа асуудал дагуулж байсан. Дандаа хулгай л байсан, үнэн. Бүүр эхнээсээ хүмүүс яасан ял авсан шүү дээ. Бид нар үнэнтэйгээ нүүр тулах хэрэгтэй. Тэгээд 44 их наядын нүүрсний хулгай гэдэг яриа гарсан уу гарсан. Тэр нүүрс чинь өөрөө маш их асуудал дагуулаад хулгай дагуулаад байдаг учир аль болох ил тод байх ёстой.

Хэрвээ ил тод бус байвал хянаж шалгаххаас өөр зам байхгүй. Яагаад гэвэл Улсын Их Хурлын 2 үндсэн чиг үүргийн нэг бол хууль батлахаас гадна баталсан хууль тогтоомж, баталсан тогтоолуудын шийдвэр буюу тэр бүх тогтоомжуудын хэрэгжилт ямар байгаа вэ гэдгийг хянан шалгах үүрэгтэй. Энэ хянан шалгах үүргийн нэг механизм бол энэ түр хороо байгуулах. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиараа.

Тэр ил тод байхгүй байгаа учраас хянаж шалгаххаас өөр зам алга л гэж үзэж байгаа. Баярлалаа.

Н.Учрал: Энэ асуудал дээр гишүүд нэлээн тооцоо судалгаатай ярих хэрэгтэй. Мэдээж 2014 онд Монгол Улс БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх хамтарсан тунхаглал батлагдаж байсан. Энэ тунхаглалд энэ хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, эрдэс баялаг, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа гээд ер нь 2008 оноос хойш энэ хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр үе үеийн Засгийн газар ажиллаж ирсэн. Ингээд 3-ыг цогцоор нь хэрэгжүүлэх чиглэлээр БНХАУ-ын Засгийн газар Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, Монгол Улсын Засгийн газар хооронд хамтын ажиллагааг өнгөрсөн хугацаанд өрнүүлж Их хурлын тогтоолоор баталсан үндэсний аюулгүй байдлын зөвлөмжтэй. Ингээд хуулийн хүрээнд процессын процедур нь бол хуулийн хүрээнд илүү ил тод нээлттэй явагдсан.

Тэгэхээр олборлох салбар бол ил тод нээлттэй байх ёстой. Тэгж байж энэ авлига ашиг сонирхлоос ангид байна. Тийм ч учраас энэ Хянан шалгах түр хороо байгуулж энэ нь үүнтэй холбоотой асуудлуудыг шалгая аа гээд Их хурлын гишүүд өөрсдийнхөө бүрэн эрхийн хүрээнд түр хороог санаачилсан байгаа.

Тэгэхээр бид бол хуулийнхаа хүрээнд хэлэлцэх үүрэгтэй Их Хурал. Ингээд нээлттэй хэлэлцэж байна. Энэ 2 улсын хоорондын гадаад харилцаа хамтын ажиллагааны асуудал учраас мэдээлэл дутуу ярих нь бол зохимжгүй байгаа юм аа.

Тийм учраас яг ийм тодорхой чиглэлүүдээр сая Рэгдэл гишүүн шиг асуултуудаа асуугаад Түр хороо санаачлагч тодорхой мэдээллүүдийг өгөөд явбал

иргэд олон нийтэд зөв мэдээлэл хүргэнэ. Ингээд энэ төсөлтэй холбогдуулаад Дэлгэрсайхан сайд нэмэлт тодруулга өгье.

Одоо бас энэ төмөр замын бүтээн байгуулалтын ажил ямар шатад явж байна гэдэг талаар мэдээлэл өгье. Дэлгэрсайхан гишүүний микрофоныг.

Б.Дэлгэрсайхан: Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Тэгээд энэ Харбины гэрээтэй холбоотой Хянан шалгах түр хороо байгуулна гэж. Яах вэ зүгээр энэ дээр бол нэг ийм юм байгаа юм Баярмаа гишүүн ээ. Ер нь бол сая Их Хурлын даргын хэлдгээр Түр хороо байгуулж шалгах нь Улсын Их Хурал болон гишүүдийн бүрэн эрхийн асуудал аа. Тэгэхдээ энэ 2 орны харилцааны асуудал болоод цаашилбал бид цаашдаа нүүрсээ яаж борлуулах юм, нүүрснийхээ борлуулалтыг яаж нэмэгдүүлэх юм гэдэг асуудалтай шууд холбогдож байгаа юм.

Нэгдүгээрт бол бид энэ хууль, эрх зүйн хувьд өнгөрсөн хугацаанд 30 гаруй тогтоол шийдвэр Улсын Их Хурлын Таван тогтоол Аюулгүйн зөвлөлийн 2 зөвлөмж Засгийн газрын 45 тогтоол шийдвэр гаргаж байсан. Энэ гэрээнээс өмнө шүү. Тийм учраас төмөр зам.

Н.Учрал: Дэлгэрсайхан гишүүнд нэмэлт минут өгье.

Б.Дэлгэрсайхан: Тийм учраас бол төмөр зам байгуулах ингээд зөвшөөрөл 5 удаа олгогдоод, 4 удаа цуцлагдсан байдаг юм. Тийм учраас цаашдаа би юу ярих гэж байна вэ гэхээр зэрэг Түр хороо байгуулж болно оо. Тэгэхдээ энэ үнэ ханштай ханшны асуудал ярьж байх шиг байна. Тэгэхлээр зэрэг анх энэ төмөр замын холболтын асуудлаар энэ Харбины гэрээнд миний бие анхнаасаа оролцсон Засгийн газрын гишүүний хувьд бол. Энийг бид өөрсдөө гуйж байгуулсан. Тэрнээс Хятадын тал холбоё гэж гуйгаагүй 1 дүгээрт. Бид нар ньюансуудаа сайн бодох хэрэгтэй.

Хоёрдугаарт бол бид нарыг та нар ингээд та нүүрсээ ингээд бид нар заръя гэсэн болохоос биш тэд нар та нар нүүрсээ бид нарт ингээд өгөөч ээ гэсэн юм ерөөсөө байхгүй. Таны хэлдгээр төмөр замын олголтыг бол ЭТТ-н мөнгөө гаргаад тендер зарлаад худалдан авахаас ингээд хийж байгаа нь үнэн. Гэхдээ бид нүүрснийхээ аль болохоор олборлолтыг сайжруулж, экспортоо нэмэгдүүлэх гэж 1 дүгээр шатын ажлаа хийж байгаа юм.

Хоёр дахь шатын ажил бол мэдээж экспорт. Экспорт ганцхан хөршөөс хамааралтай. Бид нар ингээд үнэ их ярьдаг. Би зүгээр үнийн асуудлыг ЭТТ чухам ямар үнээр хийсэн гэдгийг ярих байх. Тэгэхдээ үнийн аливаа нийлүүлэлт эрэлт нийлүүлэлтээсээ хамаараад үнийг худалдан авагч өөрөө тогтоодог эд. Та бол зах зээлийн нийгэмд амьдраад бид ингээд 20, 30 жил болж байна. Энэ Хятад улс тэр дундаа өнөөдөр энэ хил холболтын ажлыг зохион байгуулж байгаа цаанаасаа ингээд төмөр зам тавиад ороод ирсэн Чайна Энержи гэдэг компани бол өөрөө БНХАУ дотроо.

Н.Учрал: 13 цаг болсон байна. Өдрийн цайны завсарлага.

14 цагаас чуулган үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

Н.Учрал: Үдээс хойш чуулганы нэгдсэн хуралдаан эхэлж байна.

Түрүүн Дэлгэрсайхан сайд хариулж байсан. Дэлгэрсайхан сайдад микрофон өгье.

Б.Дэлгэрсайхан: Үдээс өмнөх хуралдаан дээр ярьж байсан зүйлээ үргэлжлүүлээд ярья аа. Ер нь бол Баярмаа гишүүний энэ хяналтын хороо байгуулахтай холбогдуулаад урьдчилаад би мэдээлэл өгөх нь зүйтэй гэж үзэж энэ тайлбаруудыг хийж байгаа юм. Бидний хийсэн Харбинд хийсэн гэрээгээр бол энэ хил холболтын төмөр зам болон нүүрсний экспорт нүүрсийг олборлох гэдэг энэ 3 зүйл хоорондоо салшгүй холбоотой. Тэгээд манай зарим гишүүд бол ингээд хил холболт хийх нь зөв. Гэхдээ нүүрсний экспорт бол ийм байна энэ тэр гээд ярьж байгаа юм. Зүгээр энийг үгүйсгэх юм байхгүй. Тэгэхдээ зарим гишүүдийн буруу мэдээллээс болоод нүүрсийг их бага үнээр аваад бид их бага үнээр зараад байгаа юм шиг ийм нийгэмд ойлголт төрүүлж байгаа юм. Өмнө нь олон Хятадын төрийн өмчтэй хэд хэдэн компани Чалко, Жай Ю тэгээд л хувийн компаниудаас Иком энэ тэр гээд олон компаниуд энэ нүүрсний гэрээгээр Эрдэнэс Тавантолгойгоос нүүрс авч байсан. Тэгээд урд Чайна Энержитэй хийх анхны гэрээний үед яригдаж байсан зүйл юу гэхлээр зэрэг бид энэ манай энэ төрийн өмчит болон энэ Хятадын хувийн компаниуд авч байгаа энэ хөнгөлөлттэй үнээр л нүүрсийг чинь авъя аа. Тэгээд энэ хил холболтын асуудлаа ярья.

Дээр нь бид нар бол 10 жилийн 10-аас 16 жилийн хугацаан дахь урдаасаа барьж ирсэн энэ төмөр замын маш их алдагдлаа та нараас нэхэмжлэхгүй ээ гэдэг ийм болзол тавьж байж энэ гэрээ хийгдсэн. Бид бол зүгээр суугаагүй.

Хоёр талаасаа бас аль алиндаа нэлээдгүй болзол тавьж харилцан ярилцаж тэр битгий хэл энэ гэрээг 3 жилийн хугацаанд 55 удаа уулзсан байдаг юм. Миний бие 56 дахь уулзалтаас орсон. Тэгээд энэ гэрээг анх ажлын хэсэг байгуулагдаад яахад Эрдэс баялгийн сайд Туваан ахлаад миний бие ажлын хэсгийн дэд даргаар Засгийн газрын хурлаар томилогдоод тэгээд ингээд ажилласан хүний хувьд өнөөдөр бас ингээд энэ засагт ажиллаж тэгээд энийг үргэлжлүүлээд цаашаа хийж байгаа хүний хувьд бол хамгийн сайн мэдээлэлтэй тэгээд энэ бол 2 Засгийн газрын хооронд хийсэн гэрээний асуудал аа.

Тэрнээс аль нэг компанитай хийж байгаа гэрээ биш шүү гэдгийг бас энэ ташрамд хэлье ээ. Тэгээд цаашаа бол боомтуудад холбогдох асуудал бол энэ түрүүний нүүрсний миний хэлдэг нүүрсний экспорт болон олборлолтыг нэмэгдүүлэх энэ 2 гэрээтэйгээ салшгүй холбогдолтой. Тэгээд сүүлийн үед, сошиал янз бүрийн.

Н.Учрал: Пүрэвжавын Сайнзориг гишүүн байхгүй байна. Даваагийн Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ер нь бол манай Монгол Улс нууж болох бүх юмаа нуугаад ард иргэдээсээ нуугаад байх шаардлагагүй юмнуудыг бол маш их нууж байгаа. Нэг нь энэ Оюу толгойн гэрээ хэлэлцээр гээд энэ чинь бид нар төдийгөөс өдий болтол нууц байсан учраас л баахан юман дээр маргаж байгаа. Ил байсан бол хэн ч маргахгүй засаж сайжруулаад явчих боломж нь байсан. Яг үүнтэй адилхан энэ хил холболтын асуудлыг нуугаад байгаа учраас л нууц байгаа асуудлыг ил болгож ярилцъя л гэдэг

нэг ийм асуудал яригдаад байх шиг байгаа юм. Тэгээд энэ сайд сая Зам, тээврийн сайд бол жоохон хариуцлагагүй юм яриад байх шиг байна аа энэ манай нүүрсийг авъя гэж гуйгаагүй ээ гээд. Авъя гэж гуйгаад хэдэн жил болж байгаа л компани гэж ойлгоод байгаа шүү дээ. Нэрийг нь хэлэхгүйгээр. Тэгээд ер нь гэрээ хийхдээ энэ бүх боомтоо холбоно гэж ярьсан. Шивээ хүрэн, Сэхээ, Гашуун сухайт, Ганц мод, Ханги мандал, Бичигт, Зүүн хатавч гээд. Тэгээд энэ чинь бол ганцхан асуудал нь яригдаад байна. Энэ бусад хилийн боомтуудын чинь асуудал хэзээ яригдах юм бэ? Хэзээ холбох юм бэ? Энэ дээр нэг тайлбар энэ Зам, тээврийн сайдаас асууя.

Тэгээд энэ орон нутаг Баянхонгор аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа Сейк ресорс гээд нэг дураараа компани байгаа. Дэлгэрсайхан сайд мэдэж байж магадгүй. Мэдэхгүй ч байж магадгүй. Тэгэхдээ яагаад мэдэх ёстой вэ гэхээр ЗТЯ-наас 2025 оны 11 сарын 24-нд 75435 дугаартай нөгөө албан бичиг нь оччихсон. Уг нь Сэйк Ресорс гэдэг компани Баянхонгор аймаг, Баянхонгор аймгийн иргэд, Шинэжинст сумын иргэдтэй харилцан тохиролцохдоо нүүрс зөөх хатуу хучилттай авто замыг Шивээ хүрэн боомт руу тавьж байгаад нүүрсээ зөөнө. Хатуу хучилттай нүүрс тээврийн зам тавьж байгаад зөөнө гэсэн чинь одоо болохоор танай яам нэг газрын дарга нөхөр Мөнхнасан гэдэг газрын дарга зүгээр шууд орон нутгийн замаар Тавантолгойн алдааг давтах гээд замгүйгээр орон нутгийн замыг эвдээд тэнд байгаа байгаль орчныг сүйрүүлээд ихэвчлэн тэнд чинь байгалийн тусгай хамгаалалттай говийн дархан цаазтай газар байгаа. Тэр дархан цаазтай тусгай хамгаалалттай газрыг үл харгалзаад шууд нүүрсийг чинь зөөх зөвшөөрлийг өгчхөөд байна. Энэ болохгүй бол та мэдэж байна уу мэдэхгүй байна уу? Мэдэхгүй бол энийг бүүр АТГ-т өгч шалгуулахгүй бол сумаас нь ирээд байгаа албан бичиг байна. Нэг компанитай холбогдчихсон компанийнх нь хувьцаа эзэмшигч нь гадна дотнын хүмүүс байгаа байх. Гэхдээ сум нь хүртэл энэ үйл ажиллагааг чинь бид нар сумын ард иргэдэд ямар ч ашиггүйгээр байгаль орчныг сүйтгээд говийн цаазтай газар нутгийг сүйтгэж зөөх гээд байгаа энэ асуудлыг болиулах чиглэлд нь хамтарч ажиллаад өгөөч ээ гээд байгаа. Энэ дээр энэ сайдаас албан ёсных нь байр суурийг сонсоод тэгээд тодруулъя.

Н.Учрал: Дэлгэрсайхан сайд хариулна.

Б.Дэлгэрсайхан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Ер нь бол энэ гэрээг ялангуяа энэ Харбины гэрээг нуусан юм байхгүй ээ. Энэ нэг Харбины гэрээ бол Улсын Их Хурлаар 2 удаа орж ирсэн манай Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ мэдэж байгаа. Энд сууж байгаа гишүүд өнөөдөр бүгдээрээ хамт сууж байгаад баталсан. Тэр үед бол хамтарсан Засгийн газар байсан АН, манай намын хамтарсан Засгийн газар байсан. Эрдэс баялгийн сайд маань бас АН-ын сайд байсан.

Тийм учраас энэ гэрээнд ямар нэгэн нууц зүйл байхгүй шүү гэдгийг албан ёсоор хэлье. Дээр нь энэ гэрээг дагаж хэлэлцээр байгуулагдсан. Энэ хэлэлцээр дээр бол сая таны асуудаг бусад боомтуудыг жишээлбэл Ганц мод-Гашуун сухайтын боомтын төмөр замын хил холболтын барилгын ажил эхэлмэгц бусад боомтуудын асуудлыг ярьж шийднэ ээ гэдэг ийм заалт албан ёсоор орсон байгаа. Энэ хэлэлцээр нь өөрөө энэ Их Хурлаар баталсан гэрээний салшгүй нэг хэсэг. Тийм учраас таны асууж байгаа Сэхээ, Шивээ хүрэн болон Ханги Мандал, Бичигт, Зүүн Хатавч энэ боомтууд мөн ялгаагүй төмөр замаар ингээд холбогдоод явна аа. Энэ 4 төмөр замаар холбогдож байж бид нарын тэр хүсээд байгаа бид нар ярьж

тооцоолоод гаргасан 165 сая тонн нүүрс гарах ийм боломжтой. Өнөөдөр ганц боомтоор дөнгөж жишээлбэл Гашуун сухайт боомтоор дөнгөж л 41 сая тонн л өнөөдрийн байдлаар гарч байна. Он дуусах үед 45 хүрэх болов уу гэж бид тооцож байгаа. Мөн Сэхээ, Шивээ хүрэн боомтоор 20-оос 30 сая тонн гарч байна. Мөн Хангимандалын боомтоор 10 гаруй сая тонн нүүрс гарч байна.

Тэгэхээр бид аль болохоор энэ боомтуудаар гарч байгаа нүүрснийхээ хэмжээг нэмэгдүүлэхийн төлөө урд хөрштэйгөө байнгын ярьж байгаа. Саяын таны асуусан Сейк ресорс компанийн хувьд бол манай яамнаас 2025 оны 9 сард зөвшөөрөл авсан нь үнэн. Зам тавина аа гэдэг. Энэ замын ажлаа бол маш богино хугацаанд энэ доод бүтцийн ажлаа хийчихлээ гэдэг ийм юм хийсэн. Бид өнөөдөр ингээд өвлийн хүйтэн болсон учраас дэд бүтцийн хучилтын ажлыг арай хийж амжихгүй байна. Тэгэхдээ бид нар энэ доод бүтцийн хийсэн ажлынхаа суурин дээр замаар тээвэр хийе ээ гэдэг хүсэлт ирүүлсэн. Энэний дагуу бол ЗТЯ-аас ажлын хэсэг гараад энэ доод бүтцийн ажлын хэсэг нь хийгдсэн байна аа гээд 4-өөс 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч газар дээр нь ажиллаад сум орон нутгийн Засаг дарга болон аймгийн Засаг дарга нартай уулзаж энэ ажлын хэсэг дүгнэлтээ гаргасан.

Энэ дүгнэлтийг үндэслээд манай Тээврийн газрын дарга албан ёсны зөвшөөрөл өгсөн. Хүн өөрийнхөө мөнгөөр зам тавиад тэгээд.

Н.Учрал: Дэлгэрсайхан сайдад нэг минут өгье.

Б.Дэлгэрсайхан: Тэгээд энэ замаараа тээвэр хийе ээ гэдэг ийм хүсэлт тавьсны дагуу манай тээврийн газраас зөвшөөрөл өгсөн нь үнэн. Энэ одоо миний бодохдоо бол ямар нэгэн онгон зэрлэг ямар ч зам засаагүй газраар энэ тээвэр хийгдэж байна гэж би ойлгохгүй байна. Хэрэв тийм асуудал байхгүй байгаа бол би ингээд ойрын хугацаанд ажлын хэсэг дахин явуулаад ийм зассан замаараа биш өөр замаар явж байгаа байвал шууд энэ тээврийг зогсооно оо.

Тэгэхээр энэ компани өөрөө одоо хэдэн 100 тэрбум төгрөг гаргаад энэ ажлаа хийсэн гэдгийг манай ажлын хэсэг газар дээр нь нүдээрээ үзээд зураг хөргийг нь аваад дүгнэлтээ гаргаад тэгээд энэ дагуу явж байгаа л гэж би ойлгож байгаа. Тэрнээс бол би өөрийнхөө мэргэжлийн болон газар хэлтсийн дарга нартаа итгэж байна. Хэзээ ч ийм хууль бус бусармаг юм хийхгүй яах вэ зүгээр орон нутгийн иргэд тэд янз бүрийн явуулна явуулахгүй гээд. ялангуяа Баянхонгор.

Н.Учрал: Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль нэмэлт нэг минут уу? Тодруулга. Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Сэйкер Сорс компани Шинэжинст сумтай хариуцлагын гэрээ байгуулах асуудал яригдахад энэхүү энэ Шинэжинстийн уурхайгаас энэ Хотгорын уурхайгаас Нарийн сухайт, Шивээ хүрэн болтол зөөх замыг хатуу хучилттай замаа барьчихаад зөөнө өө гэдэг л юм яригдсан. Тэрнээс болсон болоогүй ганц нэг шуудуу татаж ганц нэг гүүр хоолой барьсныгаа нүүрс зөөх ийм байгаль орчинд хор хөнөөлгүйгээр зам барьсан гэдэг ойлголтоор явахгүй шүү гэдэг ийм ойлголтоор сум орон нутагтай тохиронгуутаа үгүй ээ бид нар нэг ганц нэг гүүр далан байгуулчихлаа зөөе гэхээр нь та нар зөвшөөрч болохгүй. Энэ чинь байгаль орчин сүйдэж байна. Мал амьтан тэнчээ, мал маллах ч боломжгүй болно. Та өөрөө сайн мэдэж байгаа говийн хүн.

Тэгэхээр энэ асуудлаа яаралтайгаар зогсоохыг Шинэжинст сум Баянхонгор сум энэ хангайн бүсийн говийн аймгууд, сумууд шаардаж байгаа учраас энэ дээр дахиж ажлын хэсэг гартал энэ ажиллагаагаа зогсоох шаардлагатай шүү гэж танд анхааруулах гэсэн юм.

Н.Учрал: Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Би Цогтбаатар гишүүний саналыг хүлээж авлаа. Тэгээд энэ он гараад ажлын хэсэг явуулаад газар дээр нь байдлыг дахиж үзээд энэ тээврийн асуудлыг зогсооё. Тэгээд уул нь энэ компани манайд хүсэлт өгөхдөө бол бид дулаарангуут хатуу хучилттай тавина бусад нь бэлэн болсон байна гэдэг ийм л хүсэлт өгсөн. Энэний дагуу ажлын хэсэг газар дээр нь яваад тийм байна аа гэдэг ийм дүгнэлттэй ирсэн. Тэгэхлээр нэгэнт ард иргэдтэй сумтай хийсэн гэрээндээ ийм заалт байгаа бид зогсооё. Таны хэлснийг ойлголоо.

Н.Учрал: Жудагийн Баярмаа гишүүн тайлбар хэлнэ.

Ж.Баярмаа: Дэлгэрсайхан сайд хэллээ л дээ. Улсын Их Хурлын чуулганаар орсон гэж байгаа. Нөгөө нэг үүр шөнийн заагаар гэдэг шиг энэ Улсын Их Хуралд чинь нэг ийм жишиг тогтчихоод байгаа. Шулуухан хэлэхэд. Баяр наадмын өмнө наадмын өмнө ч юм уу шинэ жилийн өмнө асуудал оруулж ирдэг. Энэ хэлэлцээрт баримтлах зарчим гэдэг асуудлыг бид нар 12 сарын 27-нд хэлэлцсэн байдаг юм. 25-нд Засгийн газраас оруулж ирсэн байдаг юм. Ердөө хоёрхон хоногийн өмнө 25-нд нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр хоёрхон хоногийн запаастайгаар оруулж ирсэн байдаг юм. Үүр шөнийн заагаар гэдэг шиг. 12 сарын 25, 12 сарын 27. Баримтлах зарчмыг бол тэрүүгээр тогтоосон. 58 дугаар тогтоол байна уу гарсан. Дараа нь яг тэр уг хэлэлцээр нь хэзээ яаж орж ирсэн бэ гэвэл 1 сарын 25-нд намрын чуулган завсарласан бүүр хаасан, дууссан атал.

Н.Учрал: Нэмэлт нэг минут. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: 12 сарын 25-нд завсарлагаа чуулган завсарлаад хаачхаад байхад тэрний ар дээр буюу 1 сарын 27-нд Улсын Их Хурлын чуулган завсарласны дараа Эдийн засгийн байнгын хороо Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороог хуралдуулж яаралтай юм уу яаж тэр ямар дэгээр хуралдуулсныг би мэдэхгүй байна. Хуралдуулж хэлэлцээрийн төслийг оруулж ирсэн байдаг юм. Хэлэлцээрийн төсөл. Тэгээд тэрийг баталсан журам нь их сонин байгаа биз? Яалт ч байхгүй завсарлачихсаны дараа. Тэгэхээр Улсын Их Хурлаар бүрэн дүүрэн хэлэлцсэн гээд байгаад би эргэлзэж байна. Дараа нь яг хэлэлцээрийн төслийг хэзээ соёрхон баталсан бэ гэвэл 3 сард. Чуулган дөнгөж эхлэнгүүт ингэж баталсан байдаг.

Дээрээс нь та бүхэн санаж байгаа бол энэ ер нь хэдэн төгрөгөөр ямар үнээр тогтчихов гээд асуухад Улсын Их Хурлын гишүүд мэдэхгүй ээ гэсэн. Ойлголт байгаагүй, байх ч үгүй, одоо ч байхгүй. Бид нар би бол ялангуяа маш их асуусан юм.

Н.Учрал: 1 минут нэмж өгье.

Ж.Баярмаа: 12 сарын 25-ны тэр хэлэлцсэн үеэр бол асар олон гишүүд асуусан байгаа. Үнийг нь яг яаж тогтоогоод байгаа юм бэ? Тэр 2012 оны Чалкогийн гэрээг суурь үнэ болгох гэж байгаа юм уу, үгүй юм уу гэдэг асуултыг маш их тавьсан.

Хариулт олж аваагүй олигтой хариулт. Яг ингээд ингээд ийм схемээр ийм томъёоллоор хийх гэж байгаа юм аа гэдэг хариултыг өнөөдрийг хүртэл гишүүд мэдэхгүй байгаа. Тэгэхээр иргэд бүүр мэдэхгүй. Дээрээс нь ЭТТ-оос материалыг нь нэхэхээр өгөхгүй байгаа. Тэгэхээр асуудал уул уурхайн салбарын энэ нэр хүндийн уналт бол хяналт шалгалтдаа биш юм аа. Хяналт шалгалтдаа огт биш. Хулгай гараад байгаа учраас эхнээсээ хэрэг төвөг орооцолдоод шоронд сууж байгаа шүү дээ Улсын Их Хурлын гишүүн хүртэл.

Тэгэхээр энэ нүүрсний ард хулгай явдаг гэдэг ийм хар Монгол Улс даяар битүү явчихсан. Энэ хар сэрийг арилгахын тулд Улсын Их Хурал маань өөрөө чиг үүргийнхээ дагуу хяналт шалгалт хийх гээд байгаа л асуудал. Тэгэхээр энэ хяналт шалгалтыг хий.

Н.Учрал: Хяналт шалгалтын хуулийн дагуу Их Хурлын гишүүд Түр хороо санаачлах эрхтэй. Түүнийг бид ойлгож байгаа. Уул уурхайн салбар дахь ил тод байдлыг илүү сайжруулах ажлууд хийгдэхгүйгээсээ болоод энэ салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт дээр нийгмийн зүгээс Их Хурлын гишүүдийн зүгээс шүүмжлэлтэй олон асуудлууд гарч байна. Манай улс бол Нээлттэй засаглалын түншлэлд нэгдсэн орон. Тэгээд би 3 жилийн өмнө Эстонид иргэний нийгмийн байгууллагуудтай энэ Нээлттэй засаглалын түншлэлд оролцож байсан. Тэр үеэр энэ олборлох салбарын ил тод байдлын санаачилгыг нэмэгдүүлснээр авлигын төсөөллийн үнэ индексүүд буурдаг талаар гаднын улсуудын сайн жишиг туршлагаудыг тухайн үед ярилцаж байсан.

Ингээд авлигын төсөөллийн индексийг бууруулахад манай улс олборлох салбарынхаа ил тод байдлыг сайжруулах энэ олборлох салбарын ил тод байдлын хуулийг батлах чиглэлээр олон ч удаа зөвлөмж авсан. Одоо хүртэл энэ хууль батлагдаагүй байна. Тийм учраас энэ ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг Засгийн газраас авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Үгүй бол энэ нэг талаасаа хөрөнгө оруулагч нарт их таагүй мессежүүдийг энэ олон түр хорооны сонсголүүд өгөөд байх шиг байна. Нөгөө талаасаа энэ иргэдийн мэдэх эрх иргэд шаардах эрхтэй.

Тийм учраас хуулиа гаргаад ил тод болгоод энэ ард түмэн байгалийнхаа баялагт эзэн байх энэ үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд улс төрчид, энэ Их Хурлын гишүүд, Засгийн газар манлайлж ажиллах ёстой. Тийм учраас цаашдаа Засгийн газар энэ олборлох салбарынхаа ил тод байдлын хуулийг оруулж ирж энэ асуудлыг томоохон агуулгаар нь шийдэж явах хэрэгтэй. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хуулийг бид хэрэгжүүлж байгаа. Биржийн хуулийн дагуу энэ гэрээ байгуулахдаа биржийн арилжааны дундаж үнийг баримтлаад явж байгаа гэж ойлгож байна.

Дээрээс нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.11-т заасны дагуу үнэ болон бусад нөхцөлийг 3 жилийн хүртэл хугацаанд тогтоох нөхцөлтэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж байгаа гэж ойлгож байгаа. Хуульд авсан гэрээ хэлцэл гэж байхгүй.

Тийм учраас энэ асуудлыг нээлттэй ярилцах ёстой. 2008 оноос хойш бид нар БНХАУ-д олон удаа хүсэлт тавьж дээрээс нь тунхаглалд дурдсан зорилтоо хамтарсан Засгийн газрын үед хэрэгжүүлж чадсан. Үүнийгээ одоо олон нийтэд зөвөөр таниулж ойлгуулж, энэ гишүүдийн мэдэх эрхийг хангуулах чиглэлээр энэ үнэ

тогтоож байгаа энэ асуудлуудыг Зам, тээврийн яам энэ аж үйлдвэр Эрдэс баялгийн яам мэдээлэл сайн өгөх хэрэгтэй. Тэгээд энэ ажлуудаа цаашдаа шат дараатай хийгээд явна гэж итгэлтэй байна. Тэгээд Баярмаа гишүүн түр хороо мэдээж санаачилсан. Их Хурлын гишүүд дэмжсэн байна. Тэгэхээр энэ бол зөвхөн хил холболтын асуудал ярих гээд байгаа юм биш. Энэ зөвхөн үүнтэй холбоотой асуудал аа гэдгээ өөрөө тайлбарлаж байна. Энэ бол 2 хөршийн бид нар Евразийн хэлэлцээрийг ч баталлаа. Энэ бол БНХАУ-тай хийсэн гэрээ хэлцэл. Тэгэхээр энэ геополитикийн асуудал учраас үүн дээр нэлээд сайтар судалж нотлох баримттайгаар аль аль тал хандаасай гэж хүсэж байна аа. Ингээд өнөөдөр тогтоолтой Түр хороо байгуулах тогтоолтой холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Өнөөдрийн Төрийн ордны үйл ажиллагаатай Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаагийн урилгаар СБД-ийн иргэд танилцаж байна. СБД-ийнхээ иргэддээ эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Та бүхэндээ шинэ оны мэндийг өргөн дэвшүүлье ээ. Манай дүүргийнхэн байна аа. Баярлалаа. Хөххүүгийн Болормаа гишүүнийхээ мэндчилгээг өргөн дэвшүүлье ээ.

Дүүрэг орон нутагт улс төржилтгүйгээр ажлаа сайн явуулж, ард түмнийхээ асуудлыг хамтдаа шийдвэрлэж явах нь зохистой гэдэг ийм зарчим дээр бид дүүргийн орон нутгийн төлөө ямар нэгэн улс төржилтгүйгээр хамтраад ажиллаж байна аа. Тэгээд та бүхэнд баярлалаа.

Ингээд эхний Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиар санал хураалт явуулаагүй. Санал хураалтуудыг нэгтгэж явуулах нь зүйтэй.

14.24 цаг

Дараагийн асуудалд оръё.

Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Шинжлэх ухаан технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дэг хэлэлцэнэ.

Хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Гишүүдийг танхимд урьж байна. Санал хураалтыг нэгтгэж явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна. Индэрт урья.

Хууль санаачлагчийн илтгэлийг танилцуулах юм байна шүү дээ. Рэгдэл гишүүн танилцуулах юм байна. Рэгдэл гишүүнийг индэрт урья аа.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуулийн зорилго нь шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хувийн хэвшлийн оролцоо, төрийн дэмжлэг, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна аа.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 2021, 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг баталсан. Тодруулбал 2 дугаар зорилтын 2.1.27-д шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд дээд боловсролын сургалтын байгууллагуудын оруулах хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлж, бүс нутагтаа өрсөлдөх чадвартай Үндэсний судалгааны их сургууль байгуулна.

2.4.4-т шинжлэх ухаан инновацын салбарт хөрөнгө оруулалт санхүүжилтийн олон эх үүсвэр, тогтолцоог бүрдүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ.

2.4.15-д ШУТС-г олон улсын адил төстэй сангуудын жишиг хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна гэж тус тус заажээ. Хэдийгээр Шинжлэх ухаан технологийн тухай хууль Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолд шинжлэх ухаан технологийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, санхүүжилтийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөрөнгө оруулалт санхүүжилтийн олон эх үүсвэр тогтолцоог бүрдүүлэх, ШУТС-г олон улсын адил төстэй сангуудын жишиг, хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна гэж тус тус заасан боловч төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтад төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага болон их сургуулийн багш эрдэмтэд оролцох боломж хаагдмал байна аа.

Тодруулбал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т захиалагч тендерийн баталгааг төсөвт өртгийн 05 хувиар тогтооно. Мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана хэмээн тендерийн төсөвт өртгөөс хамааруулан тендерийн болон гүйцэтгэлийн баталгааг оролцогчоос гаргуулах зохицуулалттай байна аа.

ШУА, төрийн өмчийн их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаач, багш нарын хувьд хувийн хэвшлийн ААН-тэй харьцуулахад аливаа тендер сонгон шалгаруулалтад оролцохдоо тендерийн болон гүйцэтгэлийн баталгаа гаргахад хөрөнгө санхүүгийн хүндрэл үүсдэг ээ ШУА-ийн хувьд жишээ авч үзэхэд өөрийн эзэмшиж ашиглаж буй үл хөдлөх хөрөнгийг тодорхой хугацаанд барьцаа болгон сонгон шалгаруулалтад оролцох эрх мөн хаалттай байна. Өөрөөр хэлбэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн зүйлийн 30.3 дахь хэсэгт хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-д төрийн өмчийг барьцаалах орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах бүрэн эрхийг Улсын Их Хуралд хэрэгжүүлнэ гэж тус тус ажээ. Эдгээр зохицуулалтууд нь төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллага болон их сургуулийн эрдэмтэн багш нар тухайн байгууллагуудынхаа үйл ажиллагааны үндсэн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгаа, хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалт оролцох боломжийг

хязгаарлаж байгаа тул дээрх хууль тогтоомжид заасан үйл ажиллагаа явуулах мэргэжлийн чиглэлээр судалгаа шинжилгээний холбогдох ажил гүйцэтгэхэд эрх зүйн орчныг бүрдүүлэх нээлттэй болгох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна аа.

Үр дүнд нь эрдэм шинжилгээний байгууллага их сургуулиудын хүний нөөцийн туршлага, чадамж олон жилийн судалгааны үр дүн бий болсон өгөгдөл мэдээллийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах нэг боломж нээгдэх юм аа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулгын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Рэгдэл гишүүнд баярлалаа.

Төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн танилцуулна.

Б.Хэрлэн: Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Г.Хосбаяр нараас 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд Засгийн газар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарласан сонгон шалгаруулалтад шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд тендерийн болон гүйцэтгэлийн баталгаанаас чөлөөлөх харилцааг зохицуулахаар тусгасан байна аа.

Мөн төсвийн хөрөнгөөр хийгдсэн шинжлэх ухаан судалгааны дата бааз байхгүйгээс судалгаа, шинжилгээний ажлыг давхардуулан хийж төсвийн үргүй зардал гаргадаг байдлыг арилгах үүднээс үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийн нэгдсэн санг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, тус сангийн ил тод байдлыг хангах зохицуулалтыг тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 04 дүгээр хавсралтаар батлагдсан хуулийн тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах

зардлын тооцоо хийх аргачлалыг баримтлан Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг баталснаар улсын төсөвт шинээр шинээр зардал үүсгэхгүй гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг D Parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн санал авч байгаа болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд хэрхэн уялдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад ямар байгууллагыг хамааруулж байгаа талаар, төсвийн хөрөнгөөр хийсэн судалгааны ажлыг үндэсний судалгааны нэгдсэн платформ sudalгаа.gov.mn цэг сайтад байршуулахад тавих академик шаардлага, шалгуур бий эсэх, дээд боловсролын сургалтын байгууллагын эрдэмтэн судлаачдад үзүүлэх үр нөлөөний талаар, мөн хуулийн үйлчлэлд хамаарах бараа, ажил, үйлчилгээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад давуу тал үүсгэж байгаа нь худалдан авах ажиллагааны зарчимтай нийцэж байгаа эсэх, Засгийн газраас шинжлэх ухааны салбарт баримтлах бодлого шийдвэртэй уялдаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа судалгаа инновацын үр ашгийг нэмэгдүүлэх эрдэмтэн судлаачдын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, шинжлэх ухааны салбаруудын уялдаа холбоог сайжруулах зохицуулалтад хуулийн төсөлд туссан эсэх болон шинжлэх ухаан технологийн судалгааны сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг нийтэд ил тод нээлттэй байх боломжийг хангасан эсэх талаар тус тус асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат эрдэм шинжилгээний байгууллага их, дээд сургуулийн бие даан хөгжих боломж бололцоог хангах, чадавхыг сайжруулах, цаашид хөгжих боломжийг нээж өгөхөд хуулийн энэхүү өөрчлөлт шаардлагатай бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуультай уялдуулж сайжруулах чиглэлд анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Дээд боловсрол хөгжихгүй байгаа шалтгаан нь орлого олох бүх боломж хаалттай, тендерт орох боломж нь хязгаарлагдмал байдагтай холбоотой. Мөн эрдэм шинжилгээний байгууллагууд 2 яаманд харьяалагдаж байгаа нь шинжлэх ухаан дээд боловсролын салбар хөгжихөд саад болж байгаа тул Засгийн газар бүтцээ эргэн харж нэгдсэн бүтэц нэгдсэн бодлоготой болох зайлшгүй шаардлагатай байгаа талаар, мөн Судалгааны их сургуулийн тухай хуулийг баталж цаашид энэ салбарыг хөгжүүлэх суурь шинжлэх ухааныг төрөөс бодлогоор дэмжих талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа шинжлэх ухааны бодлого нь Монгол Улсын хөгжлийн үндсэн хөдөлгүүр тул суурь судалгааг төрөөс санхүүжүүлэх судалгаа шинжилгээний бодлого хариуцсан тусгай институт байх шаардлагатай талаар, мөн гадаад улсад ажиллаж байгаа Монгол эрдэмтэдтэй хамтын ажиллагааг бий болгох чиглэлд анхаарах, Хуулийн төслийн зорилго, хэрэгжилт, хариуцлага гэсэн гуравласан уялдааг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар төрийн худалдан авах үйл ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх боломжийг хаасан хуулийн хязгааруудыг шуурхай шийдвэрлэх, шинжлэх ухааны салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, цаашид хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцох боломжийг нээх эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун Хуулийн төсөл нь

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төрийн өмчийн их сургуулиудад сургалтын их сургуулиас судалгааны их сургууль болгон хөгжүүлж академик эрх чөлөөг ханган инновацын эко системийг бүрдүүлэх зорилготой холбоотой эсэх нь тодорхойгүй, цаашид шинжлэх ухааны салбарт баримтлах чиглэлээ тодорхой болгож, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах замаар дэмжлэг үзүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны шалгуур хангасны үндсэн дээр бүртгэгдэж ил тод байдаг судалгааг төрөөс тусад нь мэдээллийн сан үүсгэх шаардлагагүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа шинжлэх ухааны хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нэгдсэн бүтэцтэй болгох бодлогын өөрчлөлт хийж төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад давуу байдал олгох нь оновчтой шийдэл биш тул цаашид шинжлэх ухааныг хөгжүүлэх бодлоготой уялдуулж цэгцлэх шаардлага байгаа талаар тус тус санал хэлсэн.

Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 64.7 хувийн саналаар хамт өргөн өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 58.8 хувийн саналаар, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 64.7 хувийн саналаар тус тус үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа.

Н.Учрал: Хэрлэн гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Сангийн яамны Хууль эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ганболдын Гийхнаран, Боловсролын яамны Дээд мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Гомбосүрэнгийн Батнэмэх, Боловсролын яамны дээд мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын шинжээч Доржпаламын Баттогтох, Дээд мэргэжлийн боловсролын газар гэдэг болчихсон юм уу тэ? Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Цэдэнбалын Батзул, Үндэсний ШУТС-ийн ажлын албаны дарга Батнасангийн Бат-Эрдэнэ ажлын хэсгийг танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж урьдчилан

ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна, хариулт авна. Жаргалсайхан гишүүнээр тасаллаа.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийн төслийг дэмжиж байна аа. Ялангуяа их дээд сургуулиуд маань судалгааны чиглэлээр илүү дагнасан байх энэ чадамжийг бий болгохын тулд энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт нэлээн чухал гэж харж байгаа. Зүгээр энэ хуулийн төсөл ингээд батлагдсанаар ер нь ойролцоогоор жилдээ манай их, дээд сургуулиуд хэдэн удаагийн тендерт оролцоод хэд орчим тэрбум төгрөгийн жилийн орлого болохоор ойролцоогоор тооцоолж байгаа юм бэ гэж 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт болохоор мэдээж энэ хуулийн төслийг боловсруулахдаа тодорхой хэмжээний ийм судалгаанууд хийгдсэн байх аа гэж бодож байгаа юм. Яам агентлагууд энэ хүрээлэнгүүд дээр маш их ийм судалгааны ажлууд хийгдээд байх шиг байгаа юм. Зүгээр гол нь тэр судалгааны ажлуудын чанар үр дүн хэр байдаг вэ гэдэг дээр тийм судалсан юм байдаг юм болов уу? Өөрөөр хэлбэл энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлт орсноороо чанар судалгаанд Монгол Улсад хийгдэж байгаа энэ судалгаануудын чанар дээр яг ийм хэмжээний ахиц гарах юм байна аа, ийм дэвшил гарах юм байна аа гэсэн ийм тооцоо судалгаа байна уу? Хэн хариулах вэ? Рэгдэл гишүүн хариулна.

Д.Рэгдэл: Нэмэлт, өөрчлөлт орсноор тодорхой хэмжээний өөрчлөлт, чанар чанарын өөрчлөлт гарах нь ойлгомжтой байгаа юм. Зүгээр ганцхан жишээг хэлэхэд одоо бид нар энэ хуулиас өмнө үндсэндээ төрийн өмчит үйлдвэрийн газруудаас Эрдэнэт үйлдвэртэй нэлээн хамтарч ажиллаж явсан. Тэгээд Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн лагийг үнэргүй болгоод бордоо болгох энэ ажлыг урьд нь хийчихсэн технологи ашиглаад явуулсны үр дүнд Эрдэнэт бол лаг нь чанар сайтай хөрс болоод мод тарихдаа ашиглагдаад, тэр цэвэрлэх байгууламжийн лаг бол үндсэндээ байхгүй болчихсон байх жишээтэй. Үүгээрээ тэр ажил бүтэн циклээрээ хийгдээд явж байх жишээтэй. Ер нь энэ одоогийн Шинжлэх ухаан технологийн тухай хуультай ойролцоо эрх зүйн орчинд явуулсан сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд нийтдээ нэг шинжлэх ухаан технологийн салбараас 5 мянга орчим үр дүн бий болсон гэж үздэг. Энэ 5 мянга орчим үр дүнгийн 60 гаруй хувь нь бол дандаа гадаадын болоод дотоодын эрдэм шинжилгээний бүтээлүүдэд хэвлүүлсэн өгүүлэл. 30-аас 40 хувь нь бол технологиуд, патентууд ашигтай загварын гэрчилгээнүүд, зохиогчийн эрхийн үнэмлэх гэсэн хэлбэрээр ингээд үр дүн нь баталгаажихсан байгаад байдаг.

Энэ үр дүнгүүдээс ялангуяа хүний гар дээр очих бүтээгдэхүүн болох энэ үр дүнгүүд яагаад ингээд том хэмжээнд үйлдвэрлэлд нэвтэрдэггүй үр ашгаа өгдөггүй юм бэ гэхтэй зэрэг хамгийн гол нь энийг үйлдвэрлэлийн хагас үйлдвэрлэлийн туршилт явуулаад үйлдвэр рүү шилжүүлэх дамжлага байхгүй учраас л саатаад байгаа юм. Одоо ингээд төрийн өмчит үйлдвэрийн газрууд Засгийн газраас ийм технологийг нэвтрүүлээд энэ ажлыг гүйцэтгэмээр байна гэдэг энэ тендерийг зарлаад явах юм бол эрдэм шинжилгээний байгууллагууд энэ хийсэн үр дүн дээрээ тулгуурлаад 1 дүгээрт, 2 дугаарт энийгээ цааш нь хөгжүүлээд бодитой ийм бүтээл гаргах энэ байдал бол эрс нэмэгдэнэ гэж харж байгаа.

Н.Учрал: Уянга гишүүн нэмж хариулна.

Б.Уянга: Соронзонболд гишүүний тэр тооцоолол дээр шинжлэх ухааны байгууллагууд яг энэ ажлуудыг авч гүйцэтгэснээр хэчнээн төгрөгийн ер нь эдийн засгийн боломж нь нэмэгдэх вэ тэлэх вэ гэж асуусан асуултад хариулъя.

Тэгэхээр 2026 оны төсөв энэ хуулийн төсөл болохоор ер нь улсын төсвөөр зарлагдаж байгаа шинжлэх ухааны чиглэлийн ажлуудыг яг энэ академи болон төрийн өмчит их дээд сургуулийн судлаачид өөрсдийнхөө чиглэлийн дагуу орж хийх боломж нь нээгдэнэ. Тэгээд зарим төслүүд дээр бол шаардлагатай тохиолдолд шууд гэрээгээр явах нь явах ёстой болох байх. Ялангуяа газрын доорх устай холбоотой асуудлууд нууцад байдаг.

Тэгэхээр энэ тохиолдолд яг судалгааныхаа төрлөөс шалтгаалаад нөгөө шууд гэрээлэх нөхцөлүүд үүснэ. Зарим тохиолдолд болохоор одоо зөвхөн компаниуд л төрийн өмчит биш одоо ер нь төрийн өмчийн шинжлэх ухааны байгууллагууд орох нөхцөл нь бүүр хаагдчихсан байдаг. Энэ асуудал нь нээгдэхээр өрсөлдөөн бий болох юм.

Н.Учрал: Соронзонболд гишүүн тодруулна.

Л.Соронзонболд: Түрүүн нөгөө танилцуулга дээр энэ төрийн өмчийн их дээд сургуулиудын хөрөнгийг бас энэ тендер худалдан авах үйлчилгээнд оролцохдоо ашиглах тухай дурдагдах шиг боллоо. Тэгэхээр яг ямар хэмжээний хөрөнгийн тухай яригдаж байна вэ гэдэг ийм асуулт байна.

Н.Учрал: Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Түрүүн гүйцэж амж хариулж амжсангүй. Тэгэхээр жил жил өөр байна аа. Нөгөө үндсэн чиглэлээрээ байгууллагууд орж ажил хийх учраас тухайн жилдээ ямар ажлууд зарлагдахаас шалтгаалаад өөр байна. Тэгээд манай хууль хэлэлцэх эсэх нь дэмжигдчихээр нь 2026 оны төслүүд төлөвлөгөөг харж байгаад яг хүрээлэн хүрээлэн, сургууль сургуулиар нь хэрвээ тухайн ажлыг авах юм бол ийм байдлын ийм төгрөгийн ажлуудыг хийх нь ээ гээд хариултыг бэлдэж орж ирж танилцуулъя.

Тэгэхээр төрийн өмчийн их, дээд сургуулиуд, хүрээлэнгүүд шинэ сонгон шалгаруулалтад ороод шалгараад тэгээд өөрсдөө гүйцэтгэлийн тендерийн баталгаа өгөх мөнгөн боломж байхгүй тохиолдолд өөрийнхөө өмчийг барьцаалах асуудал байж болно. Тэгтэл барьцаалах асуудлыг Улсын Их Хурал дээр л шийддэг төрийн өмчийг.

Тийм учраас энэ явдал ерөөсөө болдоггүй. Тэгэхээр төрийн өмчийн их дээд сургуулиуд хүрээлэнгүүд, тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгааг гаргах боломжгүй болоод байдаг. Энэ асуудлыг л энэ хуулиар зохицуулж өгөх гэж бичиж байгаа юм.

Н.Учрал: Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе ээ. Энэ хуулийг гишүүд маань дэмжиж өгөөрэй гэж хүсэх гэж байгаа юм аа. Яагаад вэ гэхээр бид судалгааны их сургууль гэж олон жил ярьсан. Олон улсын жишгээр судалгааны их сургуулийн тавигддаг 1 шаардлага юу вэ гэхээр тэр орлого нь 30 орчим хувь нь судалгаанаас

орж ирсэн байх ёстой байдаг. Монголд энэ 30 орчим хувь нь хүрдэг их сургууль гэж байхгүй. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Оюутны төлбөрөөрөө санхүүждэг. Миний мэдэхээр бол ерэн хэдэн хувьтай оюутны төлбөрөөр санхүүждэг. Тэгэхээр энэ ажлын хэсгийнхэн болоод та бүхэнд бас энэ тоон дээр өөрчлөлт гарсан тийм судалгаа байна уу гэдгийг нэгд тодруулмаар байна. Өөрөөр хэлбэл бид ядаж нэг 30 хувь нь шинжлэх ухааны судалгаанаас орж ирж байж их сургуулиуд маань судалгааны их сургууль гэж олон улсад зөвшөөрөгдөх гээд байна аа. Манайд энэ хувь дээшилж байна уу? Энэ хууль батлагдсанаар судалгааны их сургууль болох боломж нь яг энд ярьж байгаа асуудал дээр нэмэгдэж нөгөө 30 орчим хувьд хүрэх боломжийг нь нээж өгч байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгэхдээ энэ дээр тодорхой тоо байна уу? Энэ дээр түрүүн Соронзонболд гишүүн асуугаад байгаатай ерөнхийдөө төстэй агуулгатай. Яг энэ хүрээнд бас яригдах дараагийн нэг асуудал юу вэ гэхээр энэ бол би Байнгын хороон дээр бас хэлсэн. Энэ манай их сургуулиуд хөгжиж чадахгүй байгаа олон янзын хязгаарлалт байдгийн нэг нь бол энэ хуулиар засаж өгөх гэж байгаад их баяртай байна. Тэгээд энэ гишүүд маань энэ хуулийг санаачлан орж ирсэнд их баяртай байгаа юм аа.

Бас нэг зүйл өнөөдөр ярихгүй бол болохгүй нь ээ. Бид дунд сургууль ерөнхий боловсролоо зөндөө ярьсан. Их сургуулиудын багш нарын цалин муу байгаа. Би энэ дээр бүүр харьцуулалт хийчихсэн байна. АНУ гээд тэгэхэд ч сардаа дунджаар шүү дээ 8600-аас 14400 байх жишээтэй. Их Британи гэхэд 5200-аас 8 мянга байх жишээтэй, Герман 6500-аас 8800 байх жишээтэй, Франц 3400-аас 6800 байх жишээтэй. Солонгос 2500-аас 9500, Хятад 3400-аас 5100 Орос гэхэд 1900 орчим. Монголын их сургуулийн багш нарын цалин 500 долларын наана цаанатай л байгаа. Энэ бүр нарийн ярих юм бол зарим сургуулиуд маань дунд сургуулийн багш нараас ч бага цалин аваад явж байгаа.

Өнөөдөр энэ олон жил 35 жил их сургууль гэдэг бол тэнд байгаа хэдэн эрдэмтэн багш нар цалин голохгүйгээр зүтгэж байдаг энэ хүмүүсийн нуруун дээр явж ирлээ. Төрөөс дорвитой бодлого ерөөсөө байдаггүй. Мэдээж та бүхэн бодоод үзээрэй. Хэрвээ бид их сургуулиудаа чадавхжуулъя гэвэл хүний нөөцийн чадавхжуулах тухай асуудал яригдана. Яг одоо МУИС дээр багш нар цалингаа нэмүүлэх гээд хичээл хаях уу, ажил хаях уу гэдэг асуудал яригдаад байж байна.

Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлэх нэгэн гарц гаргалгаа нь бол энэ судалгааны ажилд оролцох тендер авах боломжийг нь нээж өгөх энэ хуулийн төсөл байгаа. Цаашдаа бид энэ асуудлыг яримаар байна аа. Анхаармаар байна аа. Бид бол үндсэндээ өнгөрсөн 35 жилийн хугацаанд дээд боловсролынхоо өсөж хөгжих өрсөлдөх боломжийг нь хаасаар ирсэн. Одоо 15 жилийн дараа хагас 100 жил болох гэж байна. Ингээд сууж байхад үндсэндээ удахгүй хагас 100 жил болчих нь байна шүү дээ. Тэгэхээр бид энэ дээд боловсролынхоо салбарт дорвитой бодлого явуулмаар байна аа.

Гэтэл өнөөдөр яг төрөөс дээд боловсрол дээр нэгдсэн бодлого байгаа юм байхгүй. Одоо дээр нь энэ шинжлэх ухааны асуудал маань 2 яаманд хуваарилагдчихсан. Тэгээд миний энэ нэг асуумаар байгаа зүйл энэ Засгийн газрынх нь сайд нар байхгүй байгаад байна л даа. Энэ Эдийн засаг, хөгжлийн яаманд шинжлэх ухааны салбараа өгсөн нь бараг жил гаран боллоо. 2 жил удахгүй болох гэж байна. Хэр зөв зүйтэй юм байсан юм бэ гэдгийг нь хэлмээр байна. Шаардлагатай бол буцаад энэ БШУЯ болгоод бүтцийн өөрчлөлт хиймээр байна.

Энэ асуудлыг засаг анхаарч ажилламаар байна. Энийг ингээд хаяад байгаад баймааргүй байна шүү гэдгийг хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл түрүүн би судалгааны их сургуулийн тухай ярьсан. Би энийг жил нэхэж байна. Хуулиараа судалгааны их сургуулийн тухай хуулийг Засгийн газар нь оруулж ирэх ёстой. Яам нь оруулж ирэх ёстой. Одоо болтол орж ирэхгүй байна. Энэ хуульгүйгээр бид боловсролын, дээд боловсролын асуудал энэ шинжлэх ухааны асуудлыг ярих боломжгүй байна аа. Энийгээ хурдан оруулж ирээч ээ гэж хэлмээр байна.

Н.Учрал: Санал хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн байхгүй байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Маш чухал хууль хэлэлцэж байна аа. Энэ дээр уг нь салбарын сайдуудаас л асуумаар байгаа юм. Би зүгээр мэдлэг гэдэг зүйлийг бид нар ерөөсөө 1 тийм өнгө зараад байна. Уг нь нөгөө баялаг бүтээгч гээд тэр агуулгын цаана яг л энэ мэдлэгийг эзэмшиж технологи оруулж ирж байгаа хүмүүс юм байгаа юм. Тэрнээс биш өнөөдрийн нэг тодорхой 9911-тэй дугаар бариад нэг том машин унаад нэг жоохон дамнуулах гэдэг юм уу үнэ нэмэгдүүлж зарж байгаа хүмүүсдээ бид нар нэг тийм гэж тодорхойлоод хэвшчихлээ. Уг нь энэ мэдлэг гэдэг зүйл буюу тэвчээр. Энэ уйгагүй хөдөлмөр, энэ анализ дүгнэлт хийх чадвар олон зүйлийн эх сурвалжийг ашиглаж шинэ санаачилга гаргах энэ хандлагыг бид нар уг нь урамшуулж байх ёстой.

Манайд хараахан энэ зүйл алга. Дэлхийн улс орнууд ч гэсэн эдийн засгийн нөхцөл байдал мэдлэгт суурилсан эдийн засаг руугаа явчихлаа. Тэгээд энийг хэн гартаа оруулна тэр л үндсэндээ дэлхий дээр повер хаус буюу нөлөөлөгч ийм улс орон болж чадаж байна. Тэгээд манайд энэ зүйлүүд их тодорхойгүй байна. Би боловсролын багц хуулийг ер нь агуулгын хувьд дэмждэг тэгэхдээ маш олон зарим зүйлүүдээс сэтгэл дундуур байдаг. Их сургуулиудыг аваачаад судалгааны, судалгааны бус гэж ангилж байгаа байхгүй юу. Ерөөсөө их сургууль гэдэг статусыг авахын тулд угаасаа судалгаа хийх л ёстой судалгаанд мөнгө зарцуулах ёстой. Энийгээ харин буцаагаад яаж олж авах вэ гэдэг арга зам нь тэр сургуулийн менежментийн асуудал байх. Тэгэхгүйгээр ерөөсөө нэг хэдэн диплом үйлдвэрлээд ийм л нөхцөлүүд л орчихсон. Тэгээд манайх шиг ийм их сургуулиудыг буюу дээд боловсролын байгууллагын их сургууль, дээд сургууль, коллеж гээд 3 ангилалтай орон байхгүй шүү дээ. Ерөөсөө их сургууль, коллеж.

Тэгээд их сургууль дотроо дахиад судалгааны гээд нэрлэчихсэн. Тэгэхээр ийм ингээд лобби яваад энэ жинхэнэ уураг тархи ажиллаж байх институцийг бид нар хүртэл ингэж мөн чанараар нь ангилаад заримыг нь толгойг нь илээд байгаа учраас Монгол Улсад мэдлэгт хөрөнгө оруулагч нар мэдлэгийг дэмждэг тэр институц сууриараа хөгжихгүй нь. Тэгээд энийг би зориуд хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт энэ нөгөө төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн суурь л яригдаад байгаа юм л даа. Одоо энэ ШУА-ийн эрх зүйн байдал хэлбэрээсээ шалтгаалаад ингээд төсвөөс санхүүжилт жоохон авчихаараа л бусад аж ахуйн юмнууд нь хязгаарлагдчихдаг. Тэгээд энэ хүрээлэнгүүдэд байгаа нөхдүүдийг ашиглаж ажлаа хийлгэдэг цүнхний компаниуд тендер шалгаж байгаа нь үнэн үнэн. Энэ судалгааны институцүүдээр. Тэгэхдээ яах вэ зүгээр энэ асуудлыг түрүүн Найдлаа. Гишүүн санал, дүгнэлтэд харагдаж байна лээ хэлсэн байна лээ. энэ

төрийн байгууллагад хэт давуу тал олгож байгаа юм биш биз дээ гээд. Ер нь яах вэ зүгээр Учрал сайд бид нарын нэг боловсруулсан Тендерийн хууль байгаа. 10 тэрбум төгрөгөөс доош энэ тендер худалдан авалтын үйл ажиллагаан дээр тендерийн баталгаа шаардахгүй болж байгаа юм. Өмчийн хэлбэрээс үл хамаараад. Уг нь асуудлуудыг шийдэх гээд яваад байгаа юм. Тэгэхээр энэ асуудлуудыг илүү их ингэж нэг төрийн байгууллага давуу байдал гэхээсээ илүүтэй сууриар нь уг нь тендерийн хууль дээр засаж нийтлэг байдлаараа зарчим тогтоох нь зөв байгаа. Би энэ хуулийг яамд Засгийн газар болон холбогдох институтээс санал авах гээд явж байгаа юм. Бодлогын хувьд зарчмын хувьд дэмжиж байгаа гэдэг зүйлийг энэ ташрамд ингээд хэлмээр байна.

Хоёрдугаарт энэ хуулийн цаана оюуны өмчийн асуудал байгаа. Энэ мэдлэгт оруулж байгаа хөрөнгө оруулалт энэ судалгаа шинжилгээнд оруулж байгаа юмны цаана патент одоо тодорхой хэмжээний зохиогчийн эрх үүсэж байгаа тохиолдолд энийг буцаагаад эргэлтэд оруулах асуудал байхгүй байна аа. Нөгөө сургуулиуд ч нэг их тийм хойрго ханддаг. Нөгөө хичээлийн хөтөлбөр агуулга бол аль бараг 90 оны эхээрээ байж байгаа байхгүй юу. Гэтэл энийг чинь энэ судалгаанд хөрөнгө оруулалт хийгээд улам баяжуулаад явж байх ёстой юмнууд дээр манай эрдэмтдийн хандлага ч байгаа. Нөгөө академик эрх чөлөө гэдэг зүйлээс байгаад хав дардаг. Өөрөөрөө л ашиглана. Цаг нь болохоор би өөрөө энүүгээрээ юмаа хийнэ гээд. Тэгээд ингээд цаг хуучирчихдаг байхгүй юу. Маш олон шинэ санаа патентууд ингэж явсаар байгаад эдийн засгийн эргэлтэд орох үнэт.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаагийн урилгаар СБД-ийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. СБД-ийнхээ иргэд та бүхэнд эрүүл энх аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. Өнөөдөр дандаа СБД-ийн иргэд Төрийн ордонтой танилцаж байна аа. Болормаа гишүүнийхээ мэндийг хүргэж байна. Манай СБД-ийн гишүүд хамтарч ажиллаж байгаа шүү. Баярлалаа.

Пүрэвжавын Сайнзориг гишүүнд нэмэлт нэг минут өгье өө. Тэгэхээр уг нь компаниуд маань ч гэсэн жоохон өрсөлдөх чадвараа нэмэгдүүлье, бүтээмжээ нэмэгдүүлье гэвэл энэ оюуны өмчид суурилсан энэ зүйлүүд дээр хөрөнгө оруулалт хийх тэр бололцоог нь татварын болон татварын бусаар бодлогоор дэмжмээр байгаа юм аа. Уг нь энэний нэг арилжаа хийх платформыг зохион байгуулах ёстой байсан. Одоо хүртэл хууль хэрэгжихгүй байгаа.

Дээрээс нь оюуны өмчийн үнэлгээний асуудлыг яг хөрөнгийн үнэлгээний асуудлыг мэргэшсэн этгээдүүд хийх энэ асуудал ингээд зогссон. Уг нь гоё санаачилгууд гараад байдаг хуулийг аваачаад хэрэгжүүлэх асуудал дээр очоод зогсчихоод байгаа юм. Тэгээд энэ нь хуулийн нэг олзуурхууштай тал нь энэ олон судалгаанууд буюу төрийн мөнгөөр хийгдэж байгаа судалгаануудыг мэдээллийн сан үүсгэе гэж байгаа.

Нэг нэгийгээ хуулаад нэрийг нь өөрчлөөд ШУА-аас ч гэсэн маш олон зүйлүүдийг давхардуулж авсан гэдэг яриа хэлэлцээ гарч байсан шүү дээ. Энэ дээр ч гэсэн цэг тавьчих ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна аа. Тэгээд энэ тендер худалдан авалтын хууль талаасаа бас яг мэргэжлийн байгууллага нь ирчихсэн байна. Энэ дээр нэг хариулж өгөөч. Уг нь сайдууд нь байвал тэр оюуны өмчийн асуудлыг эдийн засгийн эргэлтэд ШУА энэ тэртэй хүрээлэнгүүдтэй хамтраад.

Н.Учрал: Сайнзориг гишүүн бид 2-ын хамтарч ажилласан олон хууль байгаа. Энэ Оюуны өмчийн тухай хууль маань хэрэгжилт ямар байна. Тэр Оюуны өмчийн газар чинь тэр оюуны өмчийн хуулийг тэврээд бүүр нам дараад унтуулсан. Тэгээд Оюуны өмчийн газар гэж ер нь байгууллага байна уу Монгол Улсад. Тийм байгууллага байна уу? Тэр байгууллагыг идэвхтэй ажиллуулахын тулд оюуны өмчийн хуулиа амилуулах хэрэгтэй. Тэгээд Оюуны өмчийг тухай хуулийг хэрэгжилтийг нь шалгах ажлын хэсгийг ер нь энэ Сайнзориг гишүүнээр ахлуулна аа. Тэгээд энэ хаврын чуулганаар нэг энэ оюуны өмчийн эдийн засгийн эргэлтэд оруулах нэг дэвшилтэт сэдвүүд ярихгүй бол ер нь өнөөдөр нэг гэрлэлтийн сэдэв ярьж байна шүү дээ манай парламент сүүлийн үед яригдаагүй. Манай энэ Рэгдэл гишүүн, Уянгаа гишүүн нар нэг дэвшилтэт сэдэв өнөөдөр яриулж байгаад их талархаж байна.

Ингээд Оюуны өмчийн хууль байна.

Дээрээс нь Тендерийн хууль эсвэл одоо Их Хурлын гишүүдээрээ энэ Тендерийнхээ хуулийг өргөн мэдүүлье. Сайнзориг гишүүн нарын бүрэлдэхүүнтэй энэ хуулийг Их Хурлаас өргөн мэдүүлээд ингээд явъя. Засаг дээр их удлаа. Батзул дарга мэдэж байгаа. Энэ хууль удаан хугацаанд бид нар хэлэлцсэн бэлэн болсон шүү дээ. Батзул дарга нэг нэмэлт мэдээлэл хийгээдхээч ер нь танай үйл ажиллагаа ямар түвшинд байна? Энэ тендерийн хуулиа өргөн мэдүүлэхэд бэлэн болсон уу? Батзул дарга 4 дүгээр микрофон.

Ц.Батзул: Сайн байцгаана уу? Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул. Гишүүдийн асуултад хариулъя. Түрүүн Соронзонболд гишүүний асуулт дээр нэг хэдэн тоо хэлээд тэгээд дараа нь Сайнзориг гишүүний асуултад хариулъя аа.

2025 оны хувьд төрийн худалдан авах ажиллагааны цахим систем буюу тендер гов системд нийт 185 тендер шалгаруулалт төсөвт өртөг нь 56.8 тэрбум төгрөгийн тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Би сая өөрөө хайлт хийж үзэхэд 2025 онд МУИС нийт 41 тендер шалгаруулалт оролцсон байна. Үүнээс 13 тендер шалгаруулалтад шалгарч 2.6 тэрбум төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээ авсан байна аа. Тэгэхээр Шинжлэх ухааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдуулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд орж байгаа 3 заалт байгаа. Нэг нь бол үйлчлэх хүрээтэй холбоотой. Тэр нь юу вэ гэхээр ер нь Засгийн газрын захиалгаар шинжлэх ухааны хүрээлэнгүүдээр ажил гүйцэтгэж байгаа тохиолдолд энэ хуулиар ямар нэгэн байдлаар энэ харилцаанд орохгүй юм байна аа гэдэг зохицуулалт байгаа.

Дараачийнх нь болохоор тендер шалгаруулалтад ороход энэ төрийн өмчийн хүрээлэнгүүд болон академ тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа гаргахгүй байх ийм зохицуулалт орж байгаа. Тэгээд энэ нь бол Төрийн худалдан авах ажиллагааны газрын зүгээс бол нэгэнт энэ хуулийн үйлчлэл орохгүй бол энэ хуулийн дагуу шаарддаг баталгаа шаардах нь бол ер нь хуулийн төсөл маань өөрөө зөрчилдөөнтэй байгаа юм байна аа гэж үзэж байгаа. Энийгээ Байнгын хорооны хурал дээр хэлсэн. Тэгээд 2023 оны 6 сарын 16-ны өдөр баталсан шинэчилсэн найруулгаар зөвхөн тендерийн баталгааг арилжааны банкны баталгаагаар гаргахаар биш мөн даатгалын байгууллагын баталгаагаар гаргадаг болсон байгаа.

Хүрээлэнгүүд болон энэ их дээд сургуулиуд маань төрийн мөнгийг нэгэнт барьцаалж чадахгүй юм чинь харин даатгалын үйлчилгээ аваад баталгаа гаргах боломжтой болж байгаа. Тэгээд энэ маань хэрэгжээд хэвийн явж байгаа. Хуулийн төслийн хувьд бол ажлын хэсэг гараад эцэслэсэн байгаа. Тэгээд одоо яг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бүрдүүлбэрээ энэ сарын 20-д гэхэд ер нь бол бүрэн дуусчихсан. Ялангуяа нэг зардлын судалгаа болон үр нөлөөний шинжилгээ дээр бид нар нэг апдэйт хийж байгаа. Энэнийхээ хүрээнд 20 гэхэд дуусчихна.

Өнгөрсөн 12 сарын 3-ны өдрийн Засгийн газрын хуралдаан дээр мөн Ерөнхий сайд энэ асуудлаар ярилцаад шаардлагатай бол гишүүдээр өргөн барих тал тэр талаар ярьсан байгаа. Тэгээд энэ талаар Их Хурлын даргатай тусгайлан ярилцах бодолтой байгаа. Мөн Сангийн яамтай зөвшилцөх шаардлага байгаа. Ажлын хэсэг хуулиа бүрэн дуусгасан. Мөн түрүүн Сайнзориг гишүүний хэлснээр шинэчилсэн найруулга дээр бол төсөвт өртөг нь 10 тэрбумаас доош тендер шалгаруулалтын хувьд аливаа хэлбэрийн тендерийн баталгаа шаардахгүй байхаар хуулийн төсөлд тусгасан явж байгаа. Баярлалаа.

Н.Учрал: Төрийн худалдан авах ажиллагааны газар энэ Тендерийн хууль дээр сайн ажилласан. Тэгэхээр цаашдаа ажил хийх нөхцөл бололцоогоор хангуулах томоохон төслүүдээ явуулах чиглэлээр Тендерийнхээ хуулийг яаралтай батлан гаргахад би өөрөө Хэрэг эрхлэхийн сайдаар ажиллаж байхдаа энэ хуулийг ахалж байсны хувьд манлайлал үзүүлж ажиллана. Тэгээд Сайнзориг гишүүн нарын гишүүд энэ хуулийг өргөн мэдүүлэхэд бэлэн болсон. Тийм учраас гишүүдээр өргөн бариулах боломжтой.

Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа дарга аа. Тэгээд мэдээллүүдийг олон нийтэд өгөх нь чухал байгаа юм. Тэгээд би ер нь зүгээр энэ боловсролын яам байдаг бол энэ их дээд сургуулиудад тавьж байгаа шаардлагыг яг судалгааны байхаар л тавимаар байна. Магадгүй тухайн жилд олж байгаа орлогынхоо 10-аас 15 хувийг заавал судалгаанд зарцуул гээд дэргэдээ судалгааны хүрээлэн байгуулахыг шаардаж болж байна. Эсхүл хүрээлэн байгуулахгүйгээр ШУА болоод бусад судалгааны хүрээлэн шилжүүлээд тэндээс гарч ирж байгаа тэр судалгааны үр дүнг хичээлийн хөтөлбөр агуулгадаа эсвэл гарааны компани дээр хамтраад явмаар байна. Ийм байдлаар явахгүй зарим нь судалгаанд зарцуулдаг зарим нь судалгаанд зарцуулдаггүй гэдэг ийм их сургуулиуд Монгол Улсад байж болохгүй ээ. Их сургууль бол судалгааны байгууллага.

Дээрээс нь боловсон хүчин бэлддэг. Тэгэхээр энэ мөн чанар руу нь оруулж байж энэ сууриараа бид нар зөв болно шүү. Энийг хэлмээр байна.

Хоёрдугаарт яах вэ Учрал сайдтай би сайд байх хугацаанд нь ажиллаж байсан. Энэ нийтийн мэдээллийн ил тод байдлыг энэ шинжлэх ухаан технологийн хуулийн өөрчлөлтөөр амилуулах гэж байгаа юм байна. Уг нь энэ төрийн зардлаар хийсэн бүх мэдээллүүдийг ил тод болгох буюу санг.

Н.Учрал: Нэг минут өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр манайхан нэг ийм зүйл байгаа. Яг нэг хуулийг гаргаад аймаар буужигнаж гоё ач холбогдол өгч байгаад тэгээд мартчихаад байна. Тогтмол

апдэйт хийх шүү дээ. Тэр Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн чинь үзэл санаа нь төрд байгаа тэр ил болох мэдээллийг тогтмол ил болгох. Тэгэхээр уг нь энэ төрийн захиалгаар буюу төрийн мөнгөөр хийсэн бүх судалгаануудыг нэгдсэн сан үүсгээд байнгын л апдэйт хийж нээлттэй болгох ёстой. Тэгэхээр энэ зүйлүүдийг нэг бүжигнаад өнгөрсөн дахиад мартагдчихлаа. Цахим хөгжлийн сайд маань энийг хиймээр байна аа Батшугар сайд аа даанч алга байна. Оюуны өмчийн хуулийн тэр хэрэгжилтийг багцаар нь дүгнэх асуудлыг дэмжиж байна аа дарга аа. Ингэж байж энэ эдийн засгийн суурь юман дээрээ жоохон хандлагын өөрчлөлт авчрахгүй бол тэгээд уул уурхайгаа бүгд үзэн ядаж байна.

Тэгээд уул уурхай ч гэсэн уг нь мэдлэг л юм байгаа юм л даа. Тэгээд ерөөсөө ингээд бид хэд ерөөсөө ийм зүйл дээр ингээд нэг гацчихаад байна аа. Энэний нэг түгжээг хандлага ойлголт эргээд энэ төрийн зохион байгуулалтаасаа чиг үүргээсээ эхлээд өөрчлөхгүй бол болохоо байжээ. Тэгээд энэ хууль бол залуучууд Монгол хүний хөгжилд оруулж байгаа хууль байна аа гэж би.

Н.Учрал: Аюушийн Ариунзаяа гишүүн асууна.

А.Ариунзаяа: Сайнзориг гишүүн, Учрал дарга ингэсэн, Учрал дарга ингэсэн гээд л хэлж байна. Би нэгдээд Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүд их сайхан юм бодож элдэв янзын хууль оруулж ирж байгаа нь зорилго нь зөв боловчиг яг нидэр дээрээ хуулийн төсөл нь батлагдаад явахлаар их сөрөг нөлөөллүүдийг үзүүлээд байна аа. Ийм учраас Засгийн газар өөрөө асуудлуудыг гартаа авч хариуцлагатай баймаар байна аа гэж хэлсэнтэй санал нэг байгаа.

Энэ хуулийн заалт өөрөө 4 заалттай. 2 заалт нь зөрчилтэй. Нэг зөрчлийг нь бол түрүүн Батзул тендерийн хуультай зөрчилдөж байна аа гэдгийг бол хэлсэн. Нэг заалт нь бол энэ эрдэм шинжилгээний байгууллагад хамаарах субъектийг зөвхөн судалгааны их сургууль байна аа гэж зааж өгсөн нь өөрөө ямар сөрөг нөлөөтэй юм бэ гэхлээр одоо байгаа их сургуулийн болон тэдгээрийн дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэн үйлдвэр туршилтын лабораторид ажиллаж байгаа эрдэмтэн судлаачид цалингийн 30 хувийн нэмэгдлээ авч чадахгүйд хүрнэ. Яагаад гэвэл эрдэм шинжилгээний байгууллагад хамаарахгүй болчихож байгаа байхгүй юу. Монгол Улсад яг одоогоор судалгааны нэг ч их сургууль байгуулагдаагүй. Яагаад гэвэл Улсын Их Хурлаар судалгааны их сургуулийг байгуулна аа гэж балай хууль баталчихсан байгаа байхгүй юу. Дээд боловсролын тухай хуулиар.

Тэгэхээр эрдэм шинжилгээний байгууллагын статусыг заавал судалгааны их сургуульд хамаатуулаад бусад их сургууль, дээд сургууль, бусад энэ сургалтын байгууллагууд эрдэм шинжилгээний ажил хийхгүй юм шиг ийм заалтыг оруулж болохгүй шүү дээ. Уг нь их л сайхан зүйл санасан байх. Гэхдээ нидэр дээрээ бол бүх их сургуулиудыг, дээд сургуулиудыг, эрдэм шинжилгээний энэ байгууллага лабораториудыг бүгдийг нь статусгүй болгочхож байгаа байхгүй юу. Ийм учраас энэ асуудлаа хууль санаачлагчид олж харсан уу мэдэж ийм заалт оруулчхав уу, мэдээгүй ийм заалт оруулчхав уу. Энийгээ хэрхэн яаж засах вэ?

Боловсролын дээд хууль дээр орсон байгаа энэ судалгааны их сургуулийн асуудлыг эргэж засахгүй юм уу? Боловсролын сайдаас асуумаар байна. Наранбаяраас өмнө батлагдсан заалт. Энэ заалт бол өнөөдөр маш олон их сургуулиудад хүндрэл учруулж байгаа. Тэгэхээр энэ заалтаа мэдэж оруулсан уу мэдээгүй оруулсан уу гэдгийг асууж байж ажлын хэсгийн хүрээндээ үүнийгээ

залруулах уу, үгүй юу энэ хэвээр нь гол зорилго нь юу байсан юм бэ гэдгийг бол асуумаар байна.

Боловсролын системээ бас нэг сайжруулахгүй л бол дээд сургуулиудын статусыг байхгүй болгоод хаячихсан. Дээд сургуулиудыг бүгдийг нь коллеж болгочихсон. Энэ Наранбаяр сайд сайдаа өгчихлөө. Ашгүй дээ дараагийн сайд нь тэгээд ирэхээс нь өмнө гялс юмыг нь цэгцлээд өгье гээд сайдаасаа буухаас нэг өдрийн өмнө нэг тушаал гаргачихсан. Маш олон дээд сургуулиудыг коллеж болгоод нэг танилын хүрээнийхээ ганц нэг сургуулийг их сургууль дээд сургууль болгочихсон явдал байгаа. Тэгэхээр иймэрхүү хүнийрхүү байдлаар хүнийрхүү сэтгэлээр хандмааргүй байна аа. Энэ асуудлуудаа цэгцэл ээ. Эрдэм шинжилгээний ажилд дан ганц нэг сургуулийн асуудал эс үгүй бол хүрээлэнгийн, ШУА-ийн асуудал огт биш шүү дээ.

Тэгээд Монгол улс юу л байна уу оюунлаг толгой л байж байж бид нар хөгжинө шүү дээ. Манай өвөө хэлж байсан юм. Монгол Улсыг бол Оюу толгой гэхээсээ илүүтэй Монгол хүний оюунлаг толгой л аварна аа гэж. Тэгэхээр яг энэ боловсрол шинжлэх ухааныг шүтэе, дээдэлье л гэж байгаа бол энэ хуулийн зөрчлүүдийг арилгах шаардлагатай гэж үзэж байна. Тэгээд ажлын хэсгээс асууя. Мэдэж энэ заалтыг оруулав уу? Мэдээгүй алдчихав уу? Энийг яаж засах вэ?

Н.Учрал: Ажлын хэсэг хариулъя. Боловсролын яам хариулах уу? Уянга гишүүн хариулъя.

Б.Уянга: Ариунзаяа гишүүнд баярлалаа. Судалгааны их сургууль эрдэм шинжилгээний байгууллага гэдэг дотор судалгааны их сургууль нь өөрсдөө орох юм аа гэдэг агуулгаар 18.2.2 гэсэн заалтыг хөндөж орж ирж байгаа. Тэгээд таны хэлсэн зөв. Судалгааны их сургууль Монгол Улсад хараахан байгуулагдаагүй байна. Тэгсэн мөртөө Алсын хараа 2050 бусад бодлогын бүх бичиг баримтдаа л энэ сайхан үгээ ингээд аваад явчихдаг. Тэгээд энэний төлөө ажиллая энийгээ гүйцэлдүүлье гэхээр манай Нийгмийн бодлого, хүний хөгжлийн байнгын хорооны зөвлөхүүд, ахлах референтүүд бид нар ярилцсан л даа. Байнгын хороогоор орохдоо. Хэлэлцэх эсэх нь дэмжигдчихээр яг энэ 18.2.2-ыгоо нэлээн сайжруулж ажиллах ёстой юм байна аа гэдэг дээр тохирсон. Тэгэхээр бол энэн дээр ажиллаад асуудалгүй болгоод орж ирнэ. Тэгээд яах вэ өчигдөр бас нэг хуулийн төсөл боловсруулаад орж ирээд хэлэлцэх эсэх нь ингээд 1 дүгээр шатад явсан. Өнөөдөр ингээд хуулийн төсөл орж ирж байна. Тэгээд зүгээр хэд хэдэн гишүүд нэг ингээд байх шиг байх юм. Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхгүй юм шиг. Тэгвэл тэгээд тэр хуульдаа тэгээд оруулаад өгөх хэрэгтэй шүү дээ. Бүгд Хууль тогтоомжийн тухай хуулиа мэдэж байгаа шүү дээ. Ямар их ажлын цаана ордог билээ. Тэгээд хавар ажиллаж, ажиллаж, чуулган дуусахаас өмнө өргөн барьчаад одоо хугацаагаар ороод ирэнгүүт засаг нь хийхгүй яасан юм гээд байгаа юм.

Тэгээд Батзул даргын хэлэхийг бүгдээрээ сонслоо шүү дээ. Аль намайг л УУХУ гээд хуучин тэр яамны нэрээр ажиллаж байхад л энэ Худалдан авахын хууль нь явж л байсан юм шүү дээ. Тэгээд оруулж ирэхгүй яасан юм. Тэгээд 2 баталгааных нь нэгийг нь байхгүй болгосноо бүх баталгааг нь байхгүй болгож байгаа юм шиг яриад л. Тэгснээ зөвхөн МУИС орж авч байгаа л гээд байгаа юм. Тэгээд бусад сургуулиуд чинь байгаа шүү дээ. Бусад 5 төрийн өмчит, энэ хууль хэрэглэгдэхгүй байна Батзул дарга аа. 2024 онд Тендерийн хууль сайжирч орж ирсэн та хэд сайн ажилласан. Муу ажилласан гэж энд нэг ч хүн яриагүй. Яаж хуулийг хэрэгжүүлдэг

болох юм, яаж чанартай судалгаа гаргах юм бэ гэж ярьж байна. Тэгээд энэ Улсын Их Хуралд чинь нэг тийм судалгаа хийж байсан гишүүд байгаа шүү дээ. Яг практик дээр нь зүгээр нэг байгууллагад сая 500 мянган төгрөгийн цалингаар эрдэм шинжилгээний судалгааны ажил хийгээд өөрийнхөө ажилладаг сургуулийн нэрийг бичүүлэх эрхгүй ажиллаж байсан Улсын Их Хурлын гишүүд нэгдсэн байна шүү дээ. Хосбаяр гишүүн ШУТИС-д ажиллаж байсан. Рэгдэл гишүүнтэй маргах хүн байхгүй. Би ШУТИС-д ажиллаж байсан. Хөрсөн дээрээ буухгүй байгаа юмыг хурдхан шиг засаад оруулъя гээд оруулж байна шүү дээ.

Тэгээд л нэг зөрчил яриад байх юм. Тэгээд тэрийг чинь бид нар хэлэлцэх хэсгийн дараа ажлын хэсэг дээр ярина шүү дээ.

Н.Учрал: Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Наранбаяр сайд ороод ирлээ. Та миний асуултад хариулаад өгөхгүй юу? Тэгэхдээ танд нэг л минут өгөгдөх байх. Энэ судалгааны их сургуулийн заалтыг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байгаа.

Хоёр дахь нь болохоор яг одоогийн энэ хуулийн төсөлтэй холбоотойгоор яг энэ хэвээрээ батлагдах юм бол их сургууль болон тэдгээрийн дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэр туршилтын лаборатори, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаачдын цалингийн 30 хувь алдагдах ийм нөхцөл үүсэх үү, нөлөөлөл байх уу үгүй юу? Яагаад гэвэл эрдэм шинжилгээний байгууллагад зөвхөн судалгааны их сургуулийг хамруулна аа гэсэн ийм заалт орж ирж байгаа учраас судалгааны их сургууль биш л бол бусад сургуулиудын иргэн лабораториудын эрдэм шинжилгээний ажил гэж үзэхгүй юм байна аа гэсэн ийм ойлголт давхар өгөгдөөд байна аа гэсэн үг тиймээ.

Тэгэхээр энэн дээр яг Боловсролын яам засаг ямар бодолтой байна вэ гэдгийг хариулаад өг.

Н.Учрал: Наранбаяр сайд хариулна.

П.Наранбаяр: Баярлалаа. Сая би энэ гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн хуралдаанд оролцож байгаад хоцроод ороод ирлээ. Уучлаарай. Тэгэхээр энэ 1 дүгээрт бид энэ судалгааны их сургууль тусдаа хуулиар гарах, тусдаа энийг чинь Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль гэж санаачилж оруулж ирэх ёстой. Энэ нь үндсэн суурь судалгаа нь явагдаж байгаа. Өнөөдрийн нөхцөл байдал дунд дандаа сургалтын их сургуулиуд байгаа шүү дээ. Тэрэн дотроо мэргэжлийн мөн бусад гээд ингээд ангилагдаад явж байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ судалгааны их сургууль болох энэ үйл явц процесс нэлээн удаан цаг хугацаа шаардана аа. Энэтэй холбоотойгоор тэнд ажиллаж байгаа профессоруудын мөн багш нарын цалинг зөвхөн эрдэм шинжилгээний байгууллагатай шууд адилтгаж үзэж цалинг нь бууруулна гэдгийг хүлээн зөвшөөрч болохгүй ээ. Хэрвээ ийм зүйл энэ хуулийн төсөлд байгаа бол бид нар эргэж харах ёстой.

Гэхдээ энэ хуулийн төсөлд байгаа нэг дэвшилттэй тал нь тендерийн харилцаанд төрийн өмчийн сургуулиуд оролцох боломжийг нээж байгаа нь зөв шүү гэж харж байгаа.

Н.Учрал: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн. Дахиад тодруулах юм уу? Ариунзаяа гишүүн Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Та хэд маань уг нь засгаас санал авч байгаа шүү дээ. Тэгээд энэн дээрээ анхаараад өмнө нь харчихгүй яасан юм бэ дээ ийм юм байгаа юм уу үгүй юм уу гэдгийг эргэж харж байгаад хэлье гэх юм. Энэ хууль дээр чинь хуулийн төсөл дээр яг л энэ эрдэм шинжилгээний байгууллагад зөвхөн судалгааны их сургуулийг хамруулна аа гээд заачихсан байна шүү дээ.

Гэтэл судалгааны их сургууль нэг ч байхгүй. Нэгийг ч байгуулаагүй байгаа. Тэгээд 1 сарын 1-ээс яах юм болж байна. Ийм нөлөөллүүдтэй байна аа гээд асуухаар салбар яам нь уншаагүй танилцаагүй мэдэхгүй болохлоор чинь тэгээд яах юм болж байна? Ийм учраас Засгийн газрын оролцоо маш чухал аа гэж би хэлээд байгаа байхгүй юу даа. Тэрнээс биш гишүүдийн хууль өргөн барих эрхэд нь халдах гээд байгаа ийм асуудал огтоос биш. Энэ чинь хүний амьдрал үр нөлөөтэй.

Н.Учрал: Санал хэлсэн. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Өдрийн мэнд хүргэе ээ. Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ерөнхий агуулгыг судалгааны их сургуулиудыг хөгжүүлэх тодорхой байнгын тогтмол тулгамддаг их дээд сургуулиудын багш нар болон удирдлагуудын зүгээс тавьдаг энэ судалгаа эрдэм шинжилгээний ажлуудад оролцохтой холбогдолтой энэ саналуудыг хөндсөн байгаа агуулгын хүрээнд нь дэмжиж байгаа. Хэд хэдэн тодруулах зүйлүүд байгаа. Их сургуулиудын хүрээнд бол яг өнөөдрийн байдлаар их сургуулиудын орлогын эх үүсвэр дээр эрдэм шинжилгээний энэ ажилтай холбогдолтой хувь хэмжээ юмнууд нь ямаршуу байгаа вэ? Мэдээжийн хэрэг дийлэнх хэсэг нь сургалтын төлбөртэй холбогдолтой асуудлаас орж ирж байгаа.

Тэгэхээр яг энийгээ нэг олон нийтэд нэг тодорхой мэдээлээд энэ дээр ямар нэгэн өөрчлөлт гарах тодорхой ийм судалгааны ажлууд хийгдсэн үү гэдэг эхний асуулт байгаа. Зөвхөн сургуулийн орлого нэмэгдэхээс гадна хоёрт нь яг багш нарын, профессоруудын, судлаач нарын цалин хөлс дээр энэ тодорхой яг нарийвчилсан зохицуулалтаар очих уу? Одоо бол зөвхөн цалингаас гадна судалгаа эрдэм шинжилгээний ийм чиглэлийн нэмэгдэл урамшууллуудыг ер нь их сургуулийн багш нар ямар хэмжээнд авч байгаа вэ? Тэгэхээр яг бодит яг багш нарын гар дээр очиход энэ өөрчлөлт яаж тусаж болох вэ гэдэг ийм асуулт, хоёрт нь.

Гурав дахь нь хувийн сургуулиудын асуудлыг ер нь яаж харж байгаа вэ? Төрийн өмчит сургуультай холбогдолтой асуудлууд явагдаж байна. Бусад судалгааны байгууллагуудаас илүү давуу байдал олгох тухай асуудал Байнгын хороон дээр яригдсан. Тэгэхээр энэ дээр хувийн сургуулиуд болон судалгааны байгууллагуудтай хэрхэн зөрчилдөж байгаа вэ? Өрсөлдөөний ийм нээлттэй байх энэ зарчим хэрхэн хангагдах вэ гэдгийг асууя.

Шинжлэх ухаантай холбогдолтой суурь асуудлууд нэлээн байгаа. Эрдэм шинжилгээний байгууллагуудын хувьд бас ялгамжтай ийм нөхцөл байдлууд нэлээн байна.

Ялангуяа салбарын эрдэм шинжилгээний байгууллагууд тухайн салбарынхаа бодлогод нөлөөлөх гаргасан судалгаа шинжилгээний ажлуудыг тодорхой түвшинд

хэрэгжүүлэх чиглэл дээр миний бие ХХАА-н дэд сайдаар ажиллаж байх хугацаанд бол бас шинжлэх ухаан технологийн салбарынхныг хариуцаж ажиллаж байсан. Энэ дээр уялдаа холбоо нэлээн бага байдаг аа, Боловсролын яам. Одоо бол Эдийн засаг, хөгжлийн яаман дээр энэхүү асуудлууд нь харьяалагдаад ингээд явж байгаа. Тэгээд бид бас шилжүүлээд явж байгаа. Энэ процесс дээрээ нэг дүн шинжилгээ хийх гэдэг гишүүдийн саналтай санал нэг байна.

Эдийн засаг хөгжлийн яам руу үндсэндээ шилжээд саяын энэ 5 жилийн зорилт тодорхой энэ бодлого хөтөлбөрүүд дээр эрдэм шинжилгээний байгууллагуудын үндсэндээ энэ саналуудыг яг бодитойгоор юу юун дээр тусгасан бэ жишээлбэл. Үнэхээр үр дүнтэй байгаа ийм шийдэл саналуудыг аль хүрээлэнгээс гаргаад энэ бодлого болоод бид батлаад явж байгаа вэ гэдгийг нэг тодорхой жишээн дээр та бүхэн маань тайлбарлаад өгөөч ээ. Яг тэр салбарын үндсэндээ хүрээлэнгүүдийн хамгийн гол зорилго тэр сангийн л үндсэндээ төсөлд хамрагдах тухай асуудал яг үнэндээ байгаа. Тэгээд тэр нь хүртээмжтэй биш. Авсан аваагүй энэ тэр гэдэг ийм асуудлууд дээр нэлээн судлаач нар маань үндсэндээ хуваагддаг. Тэгэхээр энэ сангийн үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт, мөн энэ төсөл шалгарсан тэр төслүүдийг тухайн салбар нь авч хэрэгжүүлж байгаа байдал дээр яаж дүгнэлтүүд хийж байна, түүнтэй холбогдолтой тодорхой судалсан саналууд байвал нээлттэй хэлээч ээ гэдэг ийм асуултуудыг асууя аа.

Н.Учрал: Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Ганхүлэг гишүүн нэлээн олон асуулт асуучихлаа. Заримд нь хариулж амжихгүй ч юм шиг л байна. 1 дүгээрт багш нар нь цалингаас өөр ямар орлого байж болох вэ гэж. Тэгэхээр манай төрийн өмчийн их сургуулиудын цалин харилцан адилгүй. Түрүүн Бум-Очир гишүүн дурдаад авна лээ. Жишээлбэл МУИС эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ЭША-ы цалин хооронд 2 дахин зөрөө бий. Өөрөөр хэлбэл эрдэм шинжилгээний ажилтнууд 2 дахин бага цалин авдаг. СУИС зэрэг сургуулиудын багш нарын цалин бол сая 500 орчим л эхэлдэг маш бага. Энийг бол ер нь сургуулийн менежмент л шийдэж байгаа. Өөр орлогын хувьд бол сая Батзул дарга хэллээ шүү дээ. Тендерт ороод багш нар 2.5 тэрбум төгрөгийн тендер аваад ингээд гүйцэтгэсэн гэж. Эндээс бага зэрэг орлого олдог ийм тал байна.

Хувийн сургуулийн асуудал энд яг эрдэм шинжилгээний ажилд оролцох, тендерт оролцох асуудал дээр хувийн сургуулиуд давуу байдалтай. Эд нар бол яг тендерт зарласан тендерийн ажилд оролцоод биелүүлээд явах бүрэн боломжтой байдаг. Яагаад гэвэл компани нь тэр батлан баталгаа батлан даалтуудыг нь хийгээд явчихдаг учраас чөлөөтэй оролцдог атал төрийн өмчийн сургуулиуд, төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд бол үнэндээ орж чадахгүй байгаа юм. Одоо энэ өөрчлөлтөөр энэ 2-ыг адилхан болгоё тэгш байдалд тавья гэсэн өөрчлөлт. Улсууд бол эсрэгээр нь хараад байгаа юм. Төрийн өмчийн сургуулиудад давуу юм бий болгох гэж байна гэж. Дутаж байсан юмыг нь гүйцээх тухай асуудал. Эрдэм шинжилгээний асуудал.

Ер нь шинжлэх ухаан технологийн бодлогын асуудлыг үндсэн хуулийн 38.2-оор зохицуулчихсан. Засгийн газар шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогыг боловсруулж батлуулж хэрэгжүүлнэ ээ гэж байгаа юм. Тэгэхдээ зэрэг энэ нь эрдэм шинжилгээний байгууллагууд нэг яамны харьяанд байгаад байна гэсэн үг биш. Нэг бодлоготой байна аа. Одоо өнөөдөр төрийн өмчийн хүрээлэнгүүд гэхэд яамны харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн байна, академийн харьяа байна. Их

сургуулиудын харьяа. Ингээд 3 харьяалалтай. Нэгдсэн бодлого нь Засгийн газрынхаа хуулиар Эдийн засаг, хөгжлийн яаман дээр зангидагдаад явж байгаа. Өнгөрсөн жилийн туршлагаар харахад энэ зөв юм шиг надад санагдсан. Сая жишээлбэл Монгол Улсын хөгжлийн 2026-02030 оны үндсэн чиглэлийг боловсруулахад Эдийн засгийн хөгжлийн яам бол яг Монголын шилдэг эрдэмтдийн багуудыг ашиглаад энэ үндсэн чиглэл дээр бүтэн ажиллуулсан. Учрал дарга маань тэгэхэд сайд нь байсан. Энэний сая үндсэн чиглэл их өөр хэлбэр агуулгад аятайхан орж ирсэн явдал бол яг шинжлэх ухааны үндэстэй хэлэлцсэнтэй холбоотой юм байгаа юм.

Эрдэм шинжилгээний байгууллагууд салбарын хөгжлийн бодлогод нөлөөлөх асуудлууд үндсэндээ хүнд. Салбар хөгжлийн бодлогодоо нөлөөлүүлэх сонирхолтой байвал эрдэм шинжилгээний байгууллагадаа захиалга өгч байж л нөлөөл нөлөөллийг нь авч чадна. Түүнээс эрдэм шинжилгээний байгууллага өөр.

Н.Учрал: Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Та бүхэндээ оройн мэнд дэвшүүлье ээ. Шинжлэх ухаан технологийн асуудлыг хөндөж Улсын Их Хурлаар хууль хэлэлцүүлж байгаад баяртай байна. Зарчмын хувьд дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье ээ. Их сургууль дээр би 3 зүйлийг хэлье гэж бодож байна. Энэ Боловсролын яамныхан ирсэн байгаа болов уу гэж бодож байна. Монгол Улс судалгааны их сургуулиа байгуулахаас өөр аргагүй ээ. Судалгааны их сургууль байгуулна гэдэг бүгдээрээ судалгааны их сургууль болох боломж их бага байдаг.

Хоёрт бол мэргэжлийн их сургуулиудаа байгуулна. Коллежуудаа байгуулна, тэгээд судалгааны их сургуулийн дэргэд бол харин ямар шинжлэх ухааны хүрээлэнг харьяалуулах вэ гэдэг өөрөө онолтой юм байна лээ. Солонгосын загвар бол Монголд тохирч магадгүй гэж би бодоод байгаа юм. Тэр бол холимог систем. Шинжлэх ухааны хүрээлэнгүүд нь бол их сургуулиа тойрдог. Нөгөө талдаа бол тусдаа шинжлэх ухааны суурь судалгаа буюу стратегийн судалгаа хийдэг академи нь тусдаа байдаг.

Тэгэхээр одоо АНУ нэлээн бидний үлгэр жишээ авдаг хөгжсөн улс орнууд бол Шинжлэх ухааныхаа академийг суурь судалгаа, эрсдэл өндөртэй зардал өндөртэйгөө төр хариуцаад бусдыг нь ингээд их сургуулиуд нь хамтарч ажилладаг. Их сургуульдаа ямар ашигтай байдаг вэ гэхээр их сургууль зөвхөн оюутны төлбөрөөр амьдрах биш, их сургууль, хувийн хэвшил, бизнесийн байгууллага, тэгээд судалгааны байгууллага гэсэн гуравласан хөгжил бий болж байгаа юм аа. Та хэдийн хууль дээр нэг зүйл арай дутуу байх шиг байх юм. Зөвхөн энэ шинжлэх ухааны байгууллага төрийн тендерт орох тухай л асуудал ярих юм. Энэ их сургуулийг тойрсон шинжлэх ухааны байгууллага хувийн хэвшлийн захиалгаар хэрэглээний судалгааг хийж байг гэмээ нь Монгол Улс хөгжинө. Хувийн хэвшилд бизнесийн байгууллага, их сургууль, судалгаа шинжилгээнд тодорхой хэмжээний төсөвт зардал гаргахын хэрээр татварын хөнгөлөлт авдаг байх хэрэгтэй. Энэ манай энэ ХАҮТ их буруу шалгаруулалт хийдэг юм.

Татвар төлөгчдөөр нь ингээд байр эзлүүлдэг. Үргэлж Эрдэнэт нэгд орж байгаа. Хамгийн их патент авсан, хамгийн их инновац гаргаж байгаа хамгийн их инновацад хөрөнгө оруулж байгаа, хамгийн их Юникорнд мөнгө өгч байгаа энэ бизнесийн топ 100 компанийг шалгаруулдаг болох хэрэгтэй. Дандаа нэг ийм

уламжлалт моделиор явж байна л даа. Энэ моделийг энэ парламент өөрчилье өө гэж бодож байна.

Тийм учраас би тийм санал гаргаад энэ ХАҮТ-д өгсөн юм. Өнөөдөр бол бидний өмнөд хөршийн компаниуд бол хамгийн их патент инновацын тоогоороо тэргүүлж байна шүү дээ. Улс орон бол юникорн буюу нэг тэрбум доллароос дээш үнэлгээтэй старт апынхаа тоогоор өрсөлдөж эхэлж байна шүү дээ. Тэгээд хэдүүлээ өөрөөр сэтгэе. Энэ хуулийн үзэл санаа зөв байна. Гэхдээ санхүүжилт зөвхөн төрөөс байна гэдэг энэ сэтгэлгээг өөрчилье. Хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагаа хувийн хэвшил өөрөө RND буюу судалгаа шинжилгээнд мөнгө зарцуулах цоо шинэ соёлыг бий болгох ёстой шүү гэж бодож байна аа. Баярлалаа амжилт хүсье.

Н.Учрал: Үг хэллээ. Отгоны Саранчулуун гишүүн байхгүй байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн нэрээ татаж байна уу? Үг хэлэх юм уу? Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууна.

Д.Жаргалсайхан: Өнөөдөр энэ орж ирж байгаа энэ шинжлэх ухаан түүнтэй холбоотой ингээд хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд бидний хувьд олон жил энэ шинжлэх ухаан технологийнхоо тал дээр анхаарал тавьсангүй. Үүнийхээ ач нөлөөг авч чадсангүй. Одоо яах вэ их дээд сургуулиудаа бас энэ судалгаа шинжилгээнд тендерт албан ёсоор оруулдаг болъё гэж байгаа эхлэл юм байх аа гэж би дэмжиж байна. Ер нь хими, хими технологийн хүрээлэн ингээд олон хүрээлэнгүүд ингээд ажиллаж байсан удирдах ажил хийж байсан Рэгдэл дарга бүх хүмүүс байна. Тэгээд байгууллагууд хариуцаж байгаа хүмүүс ороод ирсэн байна л даа.

Тэгэхээр бидний хувьд эргэж харах энэ хуулийг цааш нь сайжруулах энэ шинжлэх ухааныхаа байгууллагуудыг ашигладаг болох юм үнэхээр чухал байна аа. Ингээд энэ утаатайгаа, хөрсний бохирдолтойгоо, энэ түгжрэлтэйгээ ингээд л үзэлцээд л байгаа юм. Янз янзын л аргаар үзэж байна л даа. Тэгээд энэ маань бол амжилтад хүрэхгүй байгаа нь бол энэ байгууллагуудаа ашиглахгүй байгаагийн шинж. Энэ гаднын байгууллагыг хэдүүлээ ингээд ер нь яаж ажилладаг юм байна, энэ улс орнууд яаж хөгжөөд байна гээд очихоор л төр нь шинжлэх ухааны байгууллага нь хувийн хэвшил нь л ерөөсөө хамтарч ажилладаг. Тэгээд энэ хамтарлын үр дүн дээр л хөгжил байдаг.

Хэдүүлээ энэ жил энэ коксожсон нүүрс гээд ингээд Хятадаас оруулаад ирж байгаа юм. Хаана шинжлүүлсэн юм, хаана судалсан юм, ямар үр дүнтэй юм. Ийм юм асуухаар үгүй ээ эхний ээлжид туршилтаар үзэх гэж байгаа юм аа л гэж ярьж байгаа юм. Тэгээд энэ чинь юу гэсэн үг юм. Туршилт гэдэг чинь шинжлэх ухааны байгууллага хийдэг биз дээ. Сая манай Баатар гишүүн ярьж байна л даа? Ер нь бидний хувьд гадаад дотоодод зөндөө л судалгаа шинжилгээн дээр ингээд ажиллаж байгаа юм. Австралид очоод яг энэ ажлыг ингээд судлаад явж байхад их дээд сургуулиуд нь төр хувийн хэвшлийн захиалгаар яг энэ судалгаануудыг хийдэг туршилтыг хийдэг. Энэ дээр тэр сурч байгаа оюутнууд нь ажилладаг. Тэгээд тухайн төсөл амжилттай болох юм байна, үр дүнтэй болох юм байна гээд ингээд төрөөс нь санхүүжилтийг нь гаргадаг. Хувийн хэвшлийн ажил гүйцэтгэхэд нь яг тухайн их дээд сургуулийн оюутнууд яг тэн дээр очиж дадлагаа хийж байдаг. Тэгээд тухайн байгууллагууд нь эндээс орлогоо олж байдаг. Үндсэндээ бол яг ийм л хамтын ажиллагааны үр дүнд бол энэ техник технологи энэ инновац юм л бол тухайн улс орондоо үлддэг юм байна аа гэдгийг бид нар харж үзэж байсан. Тэгэхээр энэ тал

дээр бид нар ажиллах шаардлагатай болсон. Тэрнээс өнөөдөр ингээд нэг ард иргэд дээрээ ингээд л нэг коксожсон нүүрс, сайжруулсан нүүрс, Тавантолгой түлш гээд л ингээд л туршаад л жишээ нь бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Энэ замын цагдаагийн гүүрийг барихад юу гэж байлаа түгжрэл 30 хувь буурна аа гэж байсан. Түгжрэл 30 хувь буурсан уу? Одоо энэ яармагт баригдаж байгаа тэр дүүжин гүүр гээд. Энэ дүүжин гүүрийг яах гэж барьж байгаа юм? Очоод үзэхэд л ерөөсөө л үгүй ээ тэндээс зээл өгнө гээд байхаар нь л авчихсан юм аа л гэж байгаа юм. Тэрнээс ямар ч судалгаа шинжилгээ ерөөсөө байхгүй, үр дүн юу ч байхгүй.

Яармагаас Хархорин руу тэр дүүжин гүүрийг барихад үгүй ээ ямар түгжрэлд нөлөөлөх юм бэ. Хажуугаар нь гүүр тавьчихсан байхад тэр гүүрэн дээр тэр явж байгаа шинэ зам дээр аравхан машин л явж байна шүү дээ. Яармаг таг битүү байхад тэр гүүр тэр холбосон зам дээр аравхан машин явж байна шүү дээ.

Тэгэхээр энэ шинжлэх ухааныхаа байгууллагыг бидний хувьд энэ төрийн бодлогоор энэ төсвийн мөнгөн дээрээ оруулж ирэх нь зөв болсон. Энийг нэн шаардлагатай Улсын Их Хурлын дарга аа Улсын Их Хурал авч бүүр тогтоол гаргаж энийг ажиллуулах шаардлагатай. Тэгэхгүй бол энэ төсвийн мөнгө энэ татвар төлөгчийн мөнгө үнэхээр хайран урсаж байна. Энэ ААН-үүд гадна дотнын янз янзын техник технологи ингээд л үүслээ боллоо, бүтлээ, янзын гоё юм боллоо гээд л аваад л ирж байгаа юм. Манай энэ хөрсөн дээр энэ хүйтний энэ эрс тэс энэ 4 улиралтай таарахгүй байна шүү дээ. Ямар ч шинжилгээ судалгаагүй баахан ингээд л үйлдвэрлэл оруулж л шатаж байдаг.

Тэгэхээр энэ шинжлэх ухааны байгууллагаас энэ техник технологи энэ шинэ технологиудыг судалдаг. Энийг манай нутаг оронд яг тохирч байгаа үгүйг нь судлаад.

Н.Учрал: Нэмэлт нэг минут өгье.

Д.Жаргалсайхан: Энэ тал дээр ер нь яг энэ судалгаанууд хийгээд мэдээллийн бааз суурь үүсгээд ингээд тавьдаг юм руу бол орох ийм ер нь бололцоо нөхцөл байна уу? Энэ утаагүй түлш, энэ нүүрс, энэ түгжрэл дээр хийсэн энэ хөрсний бохирдол дээр хийсэн судалгаа шинжилгээнүүд байна уу? Энийг төрийн байгууллага, нийслэл энэ төсөв мөнгө энэ хариуцаж байгаа энэ яамд, Тамгын газар өгдөг харилцан уялдаатай ажилладаг юм байна уу? Ийм асуултыг асуух гэсэн юм. Баярлалаа.

Н.Учрал: Рэгдэл гишүүн хариулъя

Д.Рэгдэл: Төр, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тухай маш чухал оновчтой асуулт санаа гаргаж байгаа явдалд би их баяртай байна. Ер нь төр бол энэ шинжлэх ухааны байгууллагыг ашиглаж чадвал нөөц их байгаа. Одоо энэ Улаанбаатарын утааны асуудал чинь 2016 онд үндсэндээ нэг багассан шүү дээ. Тэр бол яг шинжлэх ухааны байгууллагууд үндэслэлээ гаргаж өгөөд ингээд багасаад ирсэн. Одоо энэ хагас коксоор хийсэн түлшний хувьд эрдэмтэдтэй зөвлөлдсөн юм аа. Тэгээд эрдэмтэд блд зарчмын хувьд хагас коксоор түлш хийхэд болно. Энэ утаа багасна. Тэгэхдээ яг ямар хаанахын коксоор хийх гэж байна вэ тэрнийгээ авчраад энэ химийн хүрээлэн дээр энэ хүрээлэн дээр шинжлүүлээд ингэж байгаад хийгээрэй гэсэн.

Тэгээд авчирсан нүүрсээ бол шинжлүүлэлгүй л түлж байгаа. Үүний үр дүнд бол утаат тортог тодорхой хэмжээгээр багасгах нь багасна. Зүгээр яг нарийвчилсан шинжилгээгүй ингэж явж байгаа нь үнэн. Ер нь ашиглаж чадвал жишээлбэл энэ хий дамжуулах хоолой чинь ажилд орох шахуу л юм болоод яригдаад байгаа. Энэний урьдчилсан ТЭЗҮ-ийг бас эрдэм шинжилгээний байгууллагуудаар хийлгээд трассын дагуух. Тэгээд тэрний хүчинд энэ ТЭЗҮ чинь жилийн дотор гараад ирчихсэн шүү дээ. Тийм учраас эрдэм шинжилгээний байгууллагад нөөц бий. Энийг л төр ашиглах асуудлыг Их Хурлаас чиглүүлж өгвөл нөөцөө ашиглаад зөндөө юм хийчихнэ. Эрдэм шинжилгээний байгууллага энэ хуулийн өөрчлөлтөөр их сургуулиуд тодорхой хэмжээний нэмэлт орлоготой болох боломжтой. Одоо ч гэсэн эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нэмэлт орлого олж байна. Тэр нь хувийн хэвшилтэй, хувийн хэвшлийн захиалгат ажлыг хийгээд жишээлбэл ШУА-ийн хүрээлэнгүүд гэхэд нийт зардлынхаа 40 хувийг 40 хувьтай тэнцэх орлогыг 2028 он гэхэд энэ захиалгат ажлаас оллоо гэсэн зорилготой. Одоо бол 30 орчим хувиа бол хувийн хэвшлийн захиалгат ажлаас ихэвчлэн олоод байгаа юм.

Тийм учраас суурь бол байна. Төр бодлоготой чиглүүлээд ингээд явчихад хүний нөөцийн хувьд тэгээд хуримтлагдсан мэдлэг технологийн хувьд суурь сайн байгаа энэ дээр.

Түрүүн Баатархүү гишүүн тэр хамтарсан моделийн тухай яриад авсан. Тэр шинжлэх ухааны байгууллага хувийн хэвшлийн хамтын ажиллагааны модель бол үнэхээр дэлхийд байдаг их чухал модель. Манай хувийн хэвшлүүд харин энэ хувийн хэвшлүүд эрдэм шинжилгээний байгууллагад захиалга өгдгийн хувьд одоо бид нар академийн хэмжээнд гэхэд жилд нэг 15-аас 20 тэрбумын ажлыг хийгээд байгаа. Төр захиалах ажил 60-80 тэрбумын захиалга жилд явдаг. Гагцхүү төрийн өмчит үйлдвэрийн газрууд, төсвийн байгууллагууд, төр засаг, Засгийн газар тэрийгээ захиалж өгөхгүй байгаад байгаа юм.

Тийм учраас хуулиар зохицуулалт хийгээд төрийн өмчит үйлдвэрийн газрууд Засгийн газрын байгууллагууд эрдэм шинжилгээний.

Н.Учрал: Жанчивын Галбадрах гишүүн. Рэгдэл гишүүнд нэмэлт нэг минут өгье.

Д.Рэгдэл: Тэгээд одоо ингээд Засгийн газрын байгууллагууд нь эрдэм шинжилгээний байгууллагадаа захиалгаа өгөөд хийлгээд явбал тэр тодорхой хаана ч юу хийгдээд байгаа нь их мэдэгддэггүй яваад байдаг. 60-аас 80 тэрбумын ажил бол улс орны хөгжилд төрийн бодлогод хэрэгтэй үр дүнгүүд гаргаж өгнө гэсэн энэ тооцоон доор л энэ өөрчлөлтийг оруулж ирж байгаа. Зүгээр хууль хэлэлцэх нь дэмжигдээд явчихвал цааш нь ажлын хэсэг оролцоод сая Ариунзаяа гишүүний хэлдэг тэр санал болон бусад саналуудаар мэдээж сайжруулалт хийгээд явна аа л гэж бодож байгаа.

Н.Учрал: Сая төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг дагалдуулаад нэг өөрчлөлт оруулсан тиймээ? Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар хэрвээ гадаадын хөрөнгө оруулалт татаад оюуны өмчөө ашиглуулах юм бол ирэх жил нь тухайн зардлынхаа тодорхой хувийг 10-аас доошгүй хувийг RNT судалгаа хөгжүүлэлтэд зарцуулахыг нээсэн шүү дээ. Тэгэхээр ер нь бол эрдэмтэн судлаачдаа дэмжих бодлогууд бол ингээд үе шаттай хэрэгжиж байгаа. Тэгээд Рэгдэл гишүүн парламентад орж ирснээрээ шинжлэх ухааны салбарыг бүрэн төлөөлж зовлон

жаргалыг нь мэддэг хүн бодитой санал шийдлүүдийг илэрхийлж хуулийн төслүүдэд тусгаж ажиллаж байна аа. Баярлалаа.

Жанчивын Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Бид яг төрийн бодлогоор их дээд сургууль эрдэм шинжилгээний байгууллагаа дэмжиж ажиллахад энэ их тус нэмрээ өгнө өө. Энэ эхлэл байна аа гэж хүлээж авч байгаа. Их, дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллагууд хүрээлэнгүүд хөгжих тийм боломж нь нээгдэнэ ээ гэж харж байгаа юм. Хуульд орж байгаа хамгийн дэвшилттэй зүйл манай эрдэм шинжилгээний байгууллага их дээд сургуулиуд тендерт оролцоход давуу байдал болж байгаа гэж харж байгаа. Гүйцэтгэлийн баталгаа юм уу, тендерийн баталгаа зэргийг нь хөнгөлж өгч байгаа. Энэ их сайшаалтай. Тэгээд энэ дээр бас дагаад сөрөг зүйл үүсэх вий гэдгийг би зүгээр асууж байна. Хувийн компаниудын лобби орох вий. Тендерийн хуультайгаа зөрчилдөж байгаа юу? Хувийн их дээд сургуулиуд энэ төрийн өмчийн их дээд сургуулиуд гээд ингээд заачихсан байгаа.

Тэгэхээр энд хувийн их дээд сургууль, төр хувийн, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байгаа эрдэмтэн судлаачдын оролцоо эрх ашиг хумигдах тал байх уу гэдгийг асуух гэсэн юм.

Нөгөө талаас зөвхөн төрийн өмчөөр, төсвөөр энэ тендер зарлаж хийхдээ биш хувийн хэвшлийнхний зарлаж байгаа тендерт их дээд сургууль уу энэ эрдэмтэн судлаачдаа оролцуулах энэ боломж хэр нээлттэй байгаа вэ? Энийг тодруулж асууя. Ер нь бол бид нар их дээд сургуулиудын хөгжлийн үе шатыг хардаг. Сургалтын буюу ингээд оюутнууд сургаад байдаг академик сургалттай. Дараагийн шатанд бид нарын одоо яриад байгаа судалгааны их сургууль. Энд ингээд судалгаа хийнэ гэж байна. Тэгээд хийсэн судалгаагаа яг орлого олдог механизм болгоод оюутан сурагчид тэр судлаачдыг ажиллуулаад старт ап нээгээд явах нь 3 дугаар шат. Интрепренёр гээд МIТ-ийн загвар энэ тэр гээд байдаг шүү дээ. Тэгэхээр бид нар энэ шат руугаа явах одоо тэр судалгааны их сургуулиудынхаа хуулийг Боловсролын яамнаас хэзээ оруулж ирэх гэж байгаа энэ талаар тодруулж асуумаар байна.

Мөн их дээд сургуулиас энэ бодлогоор дэмжиж байгаа энэ чухал бодлого оо. Тэгэхдээ бид нар зөвхөн байгалийн ухаан гэдэг юм уу тэр тал чухал. Мэдээж уул уурхай дээрээ түшиглээд саяын агаарын бохирдол гэдгээс эхлээд энэ судалгаанууд яг өнөөдөр Монгол Улсад тулгараад байгаа маш олон асуудлыг бид нар энэ судалгааныхаа байгууллагаар юугаар хийх судлаачдынхаа хүчин чадлаар хийх ийм боломж нэмэгдэж байна аа гэдгийг бид нар харах ёстой. Мөн гадаадын их дээд сургууль ижил төстэй эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарч хийх судалгааны ажлуудын талаар энэ хуулийн төсөлд хэр туссан бэ гэдгийг би асууя. Мөн коллежууд гэж байдаг. Манай Хосоо гишүүн бол энэ хууль санаачлахад орсон юм байна. Тэгээд МСҮТ гэж яриад хөдөө аймгуудад бүсчилсэн хөгжлөөр коллежууд байгуулна гэж байгаа.

Тэгэхээр коллежуудад ийм судалгаа хийх боломж тэнд коллеж төгссөн оюутнуудыг оролцуулах талаар Хосоо гишүүн хэр судалж бас энэ дээр оролцож харж байгаа вэ гэдгийг би асууя гэж бодож байна. Тэгээд ер нь бол бид нар их дээд сургуулиуд, юунуудыг оруулж ирэхдээ бол судалгаанд зарцуулах төсөв дээр нь бид нар төсвийг нь тавьж өгөх тал дээр их анхаарах ёстой. Түрүүн Сайнзориг гишүүн

хэлнэ лээ. Ядаж нэг 10 хувийг нь энэ судалгаандаа зарцуулдаг. Тэгээд профессорын оюутнуудыг нь тойруулаад оюутнуудаа компаниар ярих юм бол ажилчид гээд дээр нь профессорын баг бүрдээд тэр профессор нь судалгаагаа хийгээд. Харин тэр судалгаа хийхэд бол тоног төхөөрөмж хэрэгтэй. Тэр тоног төхөөрөмжийг худалдаж авна гэдэг нь тэр профессорын баг ч юм уу тэр мэдээж 1 1 тоног төхөөрөмж дээр эмнэлэг гээд л аваад л үзье л дээ. Одоо нэг лазерын аппарат байхад тэнд бөөрний тасаг нь орж ирж байгаа бол түрүү булчирхай юу байдаг юм ходоодны тасгийнхан нь тэрийгээ ингээд харж ашигладаг гэхээр тэр олон тэр тоног төхөөрөмжийг нь тавиад бусад эрдэмтэд нь тэрийгээ ашиглаж байдаг. Энэ боломж нь хэр туссан.

Н.Учрал: Болдын Уянга гишүүн хариулна.

Б.Уянга: Галбадрах гишүүнд баярлалаа. Олон асуулт асуусан учраас амжиж хариулж чадахгүй байж магадгүй. Одоогоор их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд бол хувийн хэвшлийнхнээс захиалгат ажил авдаг. Энэ бол нээлттэй. Энэ ямар нэгэн сайжруулалт шаардагдахгүйгээр явж байгаа ажил байгаа. Нэг хийж чаддаггүй юм нь улсын төсөв дээр тавигдаж байгаа судалгаа шинжилгээний ажил. Тэрэнд оролцож чадахгүй байх. Тэгээд тэрэнд оролцдог болгоё. Тэрэнд өрсөлдөөндөө ороод өөрсдөө авч чадаад хийвэл сайн байна аа гэдэг дээр энэ хуулийн төсөл санаачлагдаад явсан. Сүүлд нь яг аливаа судалгаа хийгдсэний дараа тайлан гарна. Тайлангууд нь нээлттэй байх ёстой. Тэрэн дээр нэгдсэн мэдээллийн сангаа ЗГХЭГ өөрөө харьяалдаг байвал зүгээр юм уу гэж харсан. Зөвхөн ШУТС-гаар эрдэм шинжилгээ судалгааны ажлууд зарлагддаггүй. Бүхий л чиглэлийн яамууд өөртөө судалгаа шинжилгээний зардалтай байдаг. Бас тендер зарладаг.

Тэгэхээр ингээд яамдууд хүртэл судалгааны ажил хийлгэдэг. Тэгэхээр бүх тайлангуудын мэдээлэл нь ингээд тайлан тайлангаараа ил болох гэхээсээ илүү ядаж хийгдсэн ажил нь абстракттайгаар ерөнхий агуулга нь ил байх юм бол давхардал хаа хаанаа үүсэхгүй ээ гэж харсан.

Тэгэхээр ингээд энэ хуулийн төсөл батлагдаад сайжруулагдаад ингээд явахад ямартай ч бүхий л эрдэм шинжилгээний судалгаа хийдэг судлаачид маань төрийн мөнгөөр ч гэлтгүй хувийн хэвшлийн захиалгат ажлыг угаасаа хийдэг учраас ингээд өрсөлдөөн хаа хаанаа бий болох юм байна аа л гэж харж байгаа. Аливаа судалгааны байгууллагын чадамжийг хийсэн судалгаагаар нь дүгнэдэг. Одоо ингээд хувийн хэвшилд очоод энэ судалгааг тэр сургуулийн тэр багш, тэр багшийн профессорын баг ингээд хийх боломжтой гээд ярихаар итгэхгүй байх тохиолдол элбэг байдаг. Яг хийж чадах болов уу гээд байдаг. Тэгээд ингээд яг тухайн сургуулийн тэр багийн хийж байсан ажлыг харахаар харагдахгүй байгаад байгаа байхгүй юу. Сургуулийн нэр нь бичигдэхгүй. Гэхдээ багш нар бол гэрээт байдлаар өөр газруудад судалгаагаа хийчихсэн л байдаг.

Тэгэхээр нэг ийм суурь энэ алдааг нь залруулаад эцэс төгсгөлдөө л энэ судалгааны их сургууль бий болгох замнал руу л орж байна л гэж найдаж байгаа. Тэгээд сайжруулах зүйл мэдээж байгаа. Тэгээд тэрэн дээр сайн шийдэлтэй ярилцвал зүгээр байх аа. Засгийн газраас санал авсан. Тэгээд засгийн санал нь болохоор энэ мэдээллийн санг нь харьяалах яам нь буюу Эдийн засгийн хөгжлийн яам нь аваад явсан нь зөв өө гэсэн санал ирсэн. Тэрийг ажлын хэсэг дээр дэлгэрэнгүй яриад явъя.

Н.Учрал: Галбадрах гишүүн тодруулж асууя.

Ж.Галбадрах: Баярлалаа. Тэгээд би тэр хувийн гэдэг дээр гадаадаас орж ирж байгаа хувийн компаниуд энэ тэр хийгдэж байгаа зүйлүүд дээр судлах талаар ярьсан юм байгаа юм. Би зүгээр Хосоо гишүүнээс асуугаад байгаа юм л даа. Энэ их дээд сургуулиуд дээр байгаа одоо манайд Эрдэнэс Монгол гээд л. Тэгэхэд нэг 6, 7 үндэсний технологийн парк гэххээд байна. Тэрэн дотор мэр МСҮТ-ийн буюу тэр коллежууд төгссөн хүмүүс их хэрэгцээтэй гээд байгаа юм. Тэгээд тэр хүмүүс хүмүүсийг бид 2 бүсчилсэн хөгжлийн талаар коллежууд байгуулъя гээд ярьж байсан шүү дээ. Тэнд МСҮТ тэр технологийн коллеж дээр байгаа тэр сурч байгаа залуучуудыг, оюутнуудыг, их дээд сургуулийн энэ судалгааны чиглэлээр орж ирж байгаа энэ профессор юуны багуудтай тийм холбох боломж энэ тэрийг энэ хууль дээр хэр тусгаж бодсон бэ гэдэг талаас нь би асуусан юм. Ялангуяа тэр коллежууд энэ тэрийн оюутнууд, багш нарыг, тэд нарыг их дээд сургуулиудынхаа багтай ажиллах боломж.

Н.Учрал: Санал хэллээ. Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ судалгааны их сургууль их сургуулийн ангиллын асуудал эд нар гээд. Яагаад бид өнгөрсөн 6 сард ангиллаар нь явуулсан коллеж болгож дээд сургуулиудыг нэг бол их сургууль, мэргэжлийн их сургууль гэсэн ангилал руу оруулсан. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн тийм хувийн юм огт оруулаагүй шүү. Энэ дээр яг ажлын хэсгийн гарсан дүгнэлтэд үндэслээд л ямар шийдвэр гарахаар байна тэр нь л яг автоматаар гараад л явсан гэж ойлгох хэрэгтэй. Буруу ойлголт өгч байгаа бол энийг залруулах шаардлагатай. Юуны хувьд бид энэ судалгааны их сургуулийн энэ тухай энэ хуулийг өргөн барина аа. Ирэх намрын чуулганаар. Анхны төсөл нь бэлэн болсон. Хэлэлцүүлэгт оруулж процедурыг хангана. Ингэснээр судалгааны их сургууль байгуулагдсанаар энэ чинь их дээд сургуулиудын эрх зүйн орчин бүрдсэнээр их дээд сургуулиудын дээд боловсролын хөгжил дахиад нэг шатаар ахих юм. Зөвхөн судалгаанд гэхэд нийт төсвийнхөө 15 хувийг зарцуулдаг л ийм л сургуулиуд бий болно шүү дээ.

Н.Учрал: Наранбаяр сайд нэмэлт нэг минут.

Тэгэхээр энэ бол зайлшгүй бидний явуулах ёстой цааш нь авч явах ёстой ийм эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой ийм ажил гэж харж байгаа. Бид ер нь их сургуулиудыг судалгааны болгож хөгжүүлснээр энэ цаашлаад инновацын болж ингэж хөгжиж явж улс орныхоо ирээдүйн хөгжилд шууд хувь нэмрээ оруулдаг. Мөн хувийн ААН-тэйгээ шууд холбогддог ажиллах хүчин нь их сургууль дээр байж байгаа энэ профессоруудтайгаа шууд холбоотой байдаг тэн дээрээ хүнээ өсгөдөг ийм инновацын судалгаанууд нь тэнд явж байдаг суурь судалгаанууд нь тэндээ явж байдаг ийм илүү ажил хэрэгч, илүү бизнестэй холбогдсон, илүү эдийн засагч ийм их дээд сургуулиуд бий болно гэж харж байгаа.

Энэ удаагийн энэ хуулийн төсөл хэдийгээр Засгийн газраас шууд ингээд албан ёсоор орж ирж бид яагаагүй ч гэсэн яамдаас санал авсан бид өгч байсан ийм хуулийн төсөл байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл дээр байгаа энэ, ялангуяа энэ төр, хувийн хэвшлийн одоо сургуулиудын хооронд зөв ийм өрсөлдөөн.

Арвижихын Эрдэнэбүрэн гишүүн байхгүй байна аа.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Нэрс байна уу? Байхгүй байна. Хосбаяр гишүүн индэрт гарах уу? Индэрт 1 дүгээр микрофон дээр. Та индэрт гарна аа. Шинэ дэгийн хуулиараа индэрт гардаг болсон байна. Ганбатын Хосбаяр гишүүн үг хэлнэ. 1 дүгээр микрофон.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Би өөрөө их сургуульд багшилж байсан. Тэгээд манай гэр бүлийн хүн бас Анагаахын Их сургуульд одоогоороо багшилдаг. Тэгээд ер нь их сургуулийн багш эрдэмтэн судлаачдын өнөөдрийн яг бодит ажил амьдралыг гадарлах ийм хүн байгаа. Тэгээд энэ хуулийг бол бас Уянгаа гишүүн Рэгдэл гишүүн нартайгаа хамтран өргөн барьсан. Энэ дээр бол яах вэ өнөөдрийн нэг бодит байдал өнөөдөр нэг яг эрдэмтэн судлаачдад тулгараад байгаа нэг бэрхшээлийг шийдэх цаашдаа ийм нэгдсэн сан үүсгэх ийм зохицуулалтыг л нэн даруй хийх ийм өөрчлөлтийг өргөн барьсан. Төрийн өмчийн 6 их сургууль байгаа. Энэ 6 их сургуулийн эрдэмтэн судлаачид бол энэ хуулийн хүрээнд бас хамрагдаж энэ ажиллах судалгаа шинжилгээгээ илүү боловсронгуй болгох бас энэ төрийн болон хувийн хэвшлийн оролцоотой энэ судалгаа шинжилгээний зарлагдаж байгаа тендер, энэ худалдан авах ажиллагаанд оролцох ийм боломж нь нээгдэнэ гэж харж байгаа.

Саяхан Төсвийн 2026 оны төсвийн тухай хуулийг дагалдуулж Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэлээд хувийн хэвшилд ээлтэй ийм өөрчлөлтүүд орсон. Үүнтэй уялдаад ч гэсэндээ хувийн хэвشلүүд бизнесийнхээ талаар ч юм уу одоо хийх гэж байгаа төртэй түншилж хийх гэж байгаа энэ ажлынхаа талаар энэ судалгаа шинжилгээний ажлыг захиалж хийлгэхэд бол энэ их сургуулийн эрдэмтэн багш судлаачид, энэ бааз суурьтай хамтарч ажиллах түншилж ажиллах ийм боломж нэмэгдэнэ ээ гэж ингэж харж байгаа. Тэгээд бас нэг давуу тал үүсэж байгаа нь бол энэ нэгдсэн мэдээллийн сан үүсгэх байгаа. Тэгэхгүй бол зарим судалгаагаар харахад маш олон төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд өөр нэг төрлийн судалгааг, шинжилгээг давхардуулж хийлгэдэг ийм зүйлүүд ажиглагдсан.

Тийм учраас энэ нэгдсэн мэдээллийн сан үүссэнээр энэ давхардлууд арилж цаашдаа цаг хугацаа хөрөнгө мөнгө хэмнэнэ ээ гэж ингэж харж байгаа. Тийм учраас гишүүдийн маань олонх хэлсэн үгэндээ энэ хуулийн төслийг маань дэмжиж байх шиг байна. Тэгээд хэлэлцэх эсэх санал хураалт явагдана гишүүд маань дэмжиж өгөөрэй. Тэгээд энэ хууль маань зөв зүйтэй хэлэлцүүлгийн шатад засагдах юмнууд нь засагдаад явах байх аа гэж бодож байна. Баярлалаа та бүхэнд.

Н.Учрал: Хосбаяр гишүүнд баярлалаа.

Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Шинжлэх ухаан технологийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх, хэлэлцэх эсэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулах ёстой.

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хууль, түр хорооны тогтоол, шинжлэх ухаан технологийн хууль гээд 3 асуудлыг нэгтгэж хурааа аа гэж шийдвэрлэсэн.

Тэгээд энэ хуулийг дагалдуулаад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хууль, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын хууль гээд ингээд хуулиудыг санал хураах ёстой нэмэлт өөрчлөлтийг.

Санал хураалтыг энэ 3 санал хураалтыг ирэх 7 хоногт болгож хойшлууллаа.

Та бүхэнд эцсийн найруулгыг сонсгоё.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо”. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Ингээд 2 тогтоол батлагдлаа.

Гишүүд ирцдээ анхаар. Ирэх 7 хоногт Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль, Их Хурлын хянан шалгах түр хороо ингээд Шинжлэх ухаан технологийн хууль, түүнийг дагасан хуулиудаар санал хураалт явуулна.

Хуралдааны түр хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Худалдааны түр хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдэд талархлаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Үргэлжлээд даргын зөвлөлийн хуралтай.

15.48 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА